

ШИХИХУТУГ

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ
УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ
МЭДЭЭЛЭЛ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч: *Д.Лундээжанцан*
Ерөнхий редактор: *О.Амархүү*
Зөвлөлийн гишүүд: *Ж.Болдбаатар*
Ж.Бямбаа
Н.Жалбажав

Нарийн бичиг: *М.Хатанзориг*

Шихихууг судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргав.



ГАРЧИГ

ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЭЛ

Ж.БЯМБАА

Эрүүгийн процесст нотлох баримтын тухай ойлголтыг шинээр тодорхойлох нь 6

Н.ЖАЛБАЖАВ

Нийгмийн (социал) шинэтгэлийн зарим гажиг 13

Р.ОЮУНБАДАМ

Гадаадын зарим орны пробацацийн албаны үйл ажиллагаа: харьцуулсан судлал 29

Э.АНХБАЯР

Шүүгчийн ёс зүй "монгол улсын шүүх эрх мэдэл"-ийн үнэт зүйл болох нь 40

Д.ОЮУНЧИМЭГ

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн боловсронгуй болгох зарим асуудал 46

Г.БАТНАСАН

Концессын гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал 52

ХУУЛИЙН ТАЙЛБАР

А.ДОРЖГОТОВ

Компанийн тухай хуулийн тайлбар (цуврал нийтлэл) 62

ОРЧУУЛГА

Т.СҮХБААТАР

Өнөө үед мэргэшсэн гэмт явдалтай тэмцэх үндсэн чиглэлүүд (өгүүллийн орчуулга) 118

ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЭЛ

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССТ НОТЛОХ БАРИМТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТЫГ ШИНЭЭР ТОДОРХОЙЛОХ НЬ

Ж.БЯМБАА

*(Шихихутуг их сургуулийн магистр, докторын
сургалтын албаны дарга, Ph.D, профессор)*

1. Нотлох баримт

Эрх зүйн аль ч бүлд эрүүгийн процессын тулгуур ойлголтод **нотлох баримт, нотлох ажиллагаа** зүй ёсоор тооцогддог юм. Ром-Германы гэгдэх эрх зүйн бүлийн төдийгүй “мэтгэлцэн шийдвэрлэдэг” уламжлалт процесс бүхий Англизэрэг орнуудад **нотолгооны бие даасан хууль 1989 оноос** үйлчилж байна. Эрүүгийн процессын үе шатуудыг туулсны баталгаа нь нотлох баримтад тулгуурласан шийдвэрүүдээр илрэлээ олдог юм.

“Нотлох баримт” гэсэн ойлголтын талаар өнөө хүртэл үзэл бодлын мэтгэлцээн өрсөлдөөн өрнөсөөр байна. Зарим судлаач, эрдэмтэд: нотлох баримт нь зөвхөн процесс ажиллагааг эрхлэн хэрэгжүүлэгчийн “ой тоонд буусан” мэдээлэл гэж үздэг.¹ Давамгайлах шинжтэй энэхүү ойлголтын үр дүн өнөө үйлчилж буй ЭХХШт хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх заалт. Тэнд нотлох баримтыг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээлэл” гэж тодорхойлжээ.

Ер нь мэдээлэл болгоны **эх сурвалж-баримт** факт буюу материаллаг зүйл гэдэг нь маргаангүй. Доктор (Ph.D),

¹ ЭХХШт хуулийн үзэл баримтлал /ХЗДХЯ/ 2015 он

профессор Д.Баярсайхан: “Нотлох баримт гэдэг нь тухайн хууль зүйн факт гэмт хэрэг мөн эсэхийг эрх зүйн хэм хэмжээний дагуу процессын хэрэгслээр бүх талаар батлах буюу няцаах замаар илрүүлж хянан тогтоосон бүхий л мэдээлэл, тэдгээрийн баримтат эх сурвалж”² хэмээжээ. Тэрбээр: эх сурвалж болгон баримттай байхаас гадна түүнийг тодорхойлох үндэслэлтэй гэснээрээ баримт үнэлгээ хоёрыг эн зэрэгцүүлжээ.

Түүнчлэн нотлох баримтыг органик, функционал гэж хувааж эхнийхд нь: нотлох баримтын материаллаг эх сурвалжууд, тэдгээрийг ангилан үнэлэх, хэлбэршүүлэн бэхжүүлэх талаас нь авч үзсэн, чингэснээрээ **“анхдагч”** байдлаар олдож буй үнэлэгдээгүй баримтыг, функционал түвшинд: мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаагаа баримт, мэдээллийн уялдаа, хамаарлын мөн чанарыг тогтооход чиглэгдсэн шинжийг Д.Баярсайханаас гадна доктор (Ph.D) Б.Амарбаясгалан, Ж.Эрхэсхулан нар онцолжээ³.

Эх сурвалжийг нь материаллаг, материаллаг бус хэмээн ангилснаараа тэд **нотлох баримтыг** процесс ажиллагаатай

² Д.Баярсайхан. Монгол Улсын ЭБШ эрх зүй. Ерөнхий анги 2014 он “Нотлох баримтын” тухай бүлэг

³ Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. 2018 он. 146 дахь тал

уялдуулахгүйгээр “баримтат мэдээлэл” гэж үзэж үл болно гэж буй нь хэрэг дээрээ ойлгогддог.

Манай (шинэ) хуулиар нотлох баримтын эх сурвалжийг баримтат мэдээлэлтэй адилтгасан нь **“нотлох баримт”** хэмээх эрх зүйн тулгуур ойлголтыг салаа утгатай болгож харагдуулж болзошгүй. Ер нь баримтат мэдээлэл болгон эрүүгийн процессын шалгуур, түүнийг зөвшөөрсөн эрх зүйн хэм хэмжээний зүйл заалттай нийцэж баймааж **“нотлох баримт”** хэмээх томъёололд агуулагдах учиртай.

Нотлох баримт нь бодитой агуулга болох хэргийн нөхцөл байдал болон үйл баримтын тодорхой бодьгалд тусгал болох субъектив илэрхийллийн **нэгдлээр** илэрхийлэгддэг. Бодит агуулга болох мөн чанар нь тухайн (гэмт) үйл явдлын нотлогдвол зохих нөхцөл байдлыг тодорхойлох шаардлагатай уялдаж байдаг бол субъектив хэлбэрийг илэрхийлэх эх сурвалж нь мэдээллийг агуулагч бодгалийн тусгал байх шинжийг харуулж байдаг.

Нотолгоо нь гүн ухааны нэрт эрдэмтэн Ц.Гомбосүрэнгийн зүйрлэж хэлснээр болж өнгөрсөн үйл явдлыг **“буулгах”** ажиллагаа юм. Баримт фактад тулгуурласан нотолгоо нь илүү бодит шинжтэй байдаг бол мэдээ, мэдээллээс авсан нотлох баримтууд учир шалтгааны уялдаа холбоог тунгаан нягтлах, сэтгэн бодох бүтээлч хандлагыг шаардсан нэмэлт шалгуурыг заавал шаардана. Эцэс дүндээ эдгээрийн аль аль нь мөрдөх, мэдүүлэг авах (байцаах) ажиллагааны өөр хоорондоо салшгүй

шинжийг ямагт харуулна.

Гэтэл мэдүүлэг авах уламжлалт арга хэлбэр “байцаалтыг”⁴ эрүүдэн шүүх ажиллагааны нэг хэлбэр хэмээн зарим судлаач, эрдэмтэд үздэгээс болоод чухамдаа **тайлбар, тодорхойлолт, хариулт** авах зэрэг эрүүгийн процессын янз бүрийн шатны хууль зүйн онцлог үр дагавар бүхий ажиллагаануудыг цөмийн базаж **“мэдүүлэг”** хэмээн томъёологдохоор болгосон аж. Энэ үзэл бодлыг “удирдан чиглүүлэгч” нэгэн нэрт эрдэмтэн хүртэл “хууль зүйн шинжлэх ухаанд үнэний тухай асуудал яригддаггүй, харин зөвшилцөл, зүй ёс, шударга ёс гол стандарт болдог. Үнэн зөв хэм хэмжээ, шийдэл гэж бас байхгүй. Тиймээс ч шүүхийн шийдвэр нь бас харьцангуй”⁵ хэмээсэн байдаг.

Үүнтэй уялдуулан тэмдэглэхэд “туйлын үнэн” хэмээх философи ойлголт нийгмийн атугай, байгалийн шинжлэх ухаанд **“үгүйсгэлийн үгүйсгэл”** -ийн хуулиараа аливаа үзэгдэл, юмс, материйн байнга оршин тогтнох шинжийг хэрэг дээрээ үгүйсгэдэг.

Хэрэв түүнийг “зайлшгүй зүй тогтол” гэж нотлох ажиллагаанд **“тулган хүлээлгэвэл” шүүхийн шийдвэр** болгон бодит байдлын **үнэлэмж болж чадахгүйд хүрнэ.** Тиймээс ч тодорхой цаг хугацаа өнгөрөхөд л үнэн бүхэн бодит байдалтай нийцэхээ больж “хэлмэгдүүлэлтийн түүхэн баримт”-нд тооцогдох болно.

⁴ Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь. Хамтын судалгаа. УБ., 2010 он. 35-70 дэхь талаас

⁵ “Шүүх эрх мэдэл” сэтгүүл. УБ., 2015 он. Тэргүүн өгүүлэл

Тэгээд ч эрх зүйд төдийгүй ЭХХШт хуульд “бодит үнэн” гэсэн суурь томъёонуудаа **“бодит байдал”** гэсэн амьдралын шалгуур бүхий ойлголтуудаар аль хэдийн сольсон. Товчдоо, хэргийн нөхцөл, байдлыг аливаа баримт, мэдээлэлд тулгуурлан тогтоох процесс ажиллагаа нь ЭХХШг хуулийн холбогдох заалтыг баримтлан явагдах учиртай. Өнөө үйлчилж буй ЭХХШт хуулийн зарим зүйлээс үзэхэд (тухайлбал, 16.1 дүгээр зүйлийн 3, 16.6 дугаар зүйлийн 1) эрүүгийн процесс ажиллагааг хэрэгжүүлэгч прокурор, мөрдөгчөөс гадна **төрийн байгууллагад иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн баримтат мэдээллийг** хүртэл эрүүгийн хэргийн нотлох баримтаар тооцохоор байна. Ийм тохиолдолд шүүх, прокурор, мөрдөгчөөс гадна төрийн болоод мэргэжлийн байгууллагуудад эрүүгийн процесс ажиллагааг эрхлэн явуулах эрх үүрэг хүлээнэ гэдгийг эцэс дүндээ зөвшөөрөхөд хүрнэ. Гэтэл нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэхэд ЭХХШт хуулиас өөр ямар ч хэм хэмжээг дангаар нь баримтлан ажиллах боломж одоохондоо бүрдээгүй байна.

Товчхондоо нотлох баримт цуглуулах нотолгоо явуулах нь зөвхөн ЭХХШ ажиллагаа эрхлэн хэрэгжүүлэгч нэр бүхий 3 этгээдийн эрх, үүрэг. Түүнээс биш тодорхойлж нэрлээгүй хууль, журмын дагуу хэн нэгний явуулж болох үйл ажиллагаа биш. Зүйрлэвэл, шинжээч байгалийн шинжлэх ухаанд тулгуурласан хичнээн нарийн дүгнэлт

гаргасан ч тэр нь заавал шүүх, прокурор, мөрдөгчөөс хууль зүйн үнэлгээ авах ёстой. Нотлох баримт нь эрх зүйн хоёр шаардлага, шалгуурыг заавалчгүй хангах учиртай. Тэрхүү шалгууруудыг нотлох баримтын агуулга тодорхойлогч **хамаарал**, хэлбэрийн илэрхийлэл болсон **болохуйц байдал** гэж ангилан авч үздэг.

Нотлох баримтын хэлбэр буюу эх сурвалж нь түүний агуулга болох мэдээллээс огт өөр зүйл. Жичлэн тайлбарлахад мөр гаргадаг биет зүйлийн агуулга, мэдээллийн мөн чанар хоёр өөр хоорондоо ялгаатай. Мөр гаргагч объект анхдагч мэдээллийг агуулдаг бол мөр буулган авагч нь эхний биетээс өөр дээрээ туссан /буусан/ мэдээллийг хадгалан үлддэг дамжуулагч шинжтэй.

Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн, бодитой шинжлэн тогтоохын тулд хэрэгт ач холбогдол, хамааралтай бүхий л баримт сэлт мэдээллийг цуглуулж бэхжүүлнэ.

Хэрэв цуглуулж бэхжүүлсэн тэрхүү баримт сэлт мэдээлэл нь гэмт үйл явдалтай орон зай, цаг хугацаа болон бусад ямар нэг шалтгаант холбоогүй /шууд ба шууд бус алин ч ялгаагүй/ бол нотлох баримт нь хамааралтайд тооцогдохгүй.

Нотлох баримтын хамаарлыг гарцаагүй тогтоох нь хэргийг түргэн шуурхай илрүүлэх, үндэслэлтэй шийдвэр гаргахад ач холбогдлоо ямагт агуулна.

Ер нь тухайн хэрэгт хамааралтай баримт, мэдээллийг урьдаас хатуу тогтоох нь бэрхшээлтэйгээс гадна нэг

талыг барьсан тийм хандлага гаргавал ноцтой төөрөгдөлд орж болзошгүй. Янз бүрийн таамаглал дэвшүүлж шалгах, улмаар учир зүйн холбогдлыг сэтгэн тунгааж дүгнэлт хийх, түүнийг баримтжуулан бэхжүүлэх нөр их ажиллагаагаар хамааралтай эсэхийг тодруулан тогтооно.

Болохуйц байдал гэдэг нь дараах шаардлагыг заавал хангасан байх нотлох баримтын чанар юм. Үүнд:

- Тухайн эрүүгийн хэргийг шалгаж буй эрх бүхий этгээд процесс ажиллагааны үр дүнд уг баримт сэлт мэдээллийг олж авсан байх
- Тэрхүү нотлох баримт нь ЭХХШТ хуулийн эх сурвалжийн “жагсаалтад” заавал агуулагдсан, тодруулбал, 16.1 дүгээр зүйлийн 2т нэрлэн заасан баримтат мэдээллийн төрлүүдэд нэрлэгдсэн байна.
- Уг нотлох баримтыг олж илрүүлэх болон бэхжүүлэх ажиллагаанд ЭХХШТ хуульд тодорхойлон заасан журмыг чанд сахисан байх ёстой. Цаашдаа ЭХХШТ хуулийн дээрх заалтыг илүү боловсронгуй болгож нотолгооны хэрэгслийг бүрдүүлэгч гол төрлүүдээс гадна хамааралтай бусад баримт сэлт мэдээллийг авч ашиглах боломжийг нэмэгдүүлэх зохицуулалт шаардагдах биз.

Болохуйц байдлын шаардлагаас үзэхэд ЭХХШТ хуульд заасан журмыг баримтлаагүй, эсхүл зөрчих замаар цуглуулж бэхжүүлсэн нотлох баримт нотолгооны хүчин чадлаа алдаж байна. Жишээ нь хөндлөнгийн гэрчийг

байлцуулалгүйгээр хийгдсэн үзлэг, нэгжлэгээр илэрсэн бүхий л зүйл хэдийгээр гэмт хэрэгт хамааралтай боловч нотлох чадваргүй болоход хүрнэ.

Нотлох баримтын хамаарал нь түүний тухайн хэрэгтэй ямар холбоо хэлхээтэйг харуулдаг бол нотлох баримтын болохуйц байдал нь түүний хууль ёсны эсэхийг илэрхийлж байдаг.

2. Нотолгооны зүйл, нотолгооны хэмжээ хязгаар

Танин мэдэх, төсөөлөн буулгах процессын нэгэн хэлбэрийн хувьд ЭХХШ ажиллагаан дахь нотолгоо нь өөрийн судлах зүйл, судалгааны объектой. Энэ нь (тухайн) гэмт хэргийг үндэслэлтэй зөв шийдвэрлэхийн тулд заавалчгүй тогтоох шаардлагатай үйл баримтын цогц.

Нотолгооны зүйлийг оновчтой тодорхойлох нь хэргийн бодит нөхцөл байдлыг танин мэдэх, эргэлзээгүй буулгах (бэхжүүлэх) улмаар зөв зүйлчлэхтэй ямагт уялдана.

Нотолгооны зүйл нь тодорхой биш бол уг ажиллагааг хууль зүйн үүднээс төдийгүй энгийн ухамсрын түвшинд эргэлзээ үүсгэнэ. Анхнаасаа зөв чиглэлээ тогтоохын тул хэргийн халуун мөрөөр шуурхай орж ач холбогдолтой, хамааралтай баримт мэдээллүүдийг цуглуулж авах нь тун чухал. Ер нь “олж авах, цуглуулж бэхжүүлэх” хэмээсэн тодотгол бүхий ЭХХШТ хуулийн холбогдох зүйл заалтууд нь процесс ажиллагааны эхний шатанд мөрдөгч, прокуророос идэвх санаачилгатай үйл ажиллагаа шаардана. Нотолгооны зүйлд

зайлшгүй, заавалчгүй орох нөхцөл байдлуудыг ЭХХШт хуулийн 16.2 дугаар зүйлд заажээ. Үүнд:

1. Гэмт хэрэг гарсан байдал /гэмт хэргийг хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдлууд/
2. Гэмт хэрэг хэн үйлдсэн
3. Гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр
4. Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал
5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэм хэмжээ
6. Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл хэмээжээ.

Нотолбол зохих байдал нь хэрэг дээрээ **нотолгооны зүйл** бөгөөд түүнийг ийнхүү хуульчилсан нь тухайн хэргийн бодит байдлыг бүрэн дүүрэн тогтоох, гэмт хэргийг зөв зүйлчлэх тухайн этгээдийн гэм буруутай эсэхийг шийдвэрлэх, хэрэв гэм буруутай бол тохирсон ял шийтгэл шударгаар оногдуулах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг оновчтой зохион байгуулах олон талын ач холбогдолтой байдаг.

Эдгээрээс гадна эрүүгийн тодорхой хэргийн хувьд ЭХХШт хуулийн 16.2 дугаар зүйлд заагаагүй бусад үйл баримт, нөхцөл байдлыг нотлох шаардлага тулгарч болох юм. Тухайлбал, ЭХХШ ажиллагааны явцад зарим шийдвэр гаргахад шаардлагатай нотлох баримтыг заавал тогтоох хэрэгтэй байдаг. Үүнд:

таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх, түүнийг өөрчлөх хүчингүй болгох, үзлэг нэгжлэг хийх, хохирогчоор тогтоох зэрэгт **холбогдох бусад мэдээ сэлт, баримтад** тулгуурлан уг ажиллагааг явуулах нь зүйн хэрэг.

Түүнчлэн дурдсан зүйлд заагаагүй ч тодорхой нөхцөл байдлыг үнэлэхэд ач холбогдолтой үйл баримт байдаг. Жишээ нь, гэрч, хохирогчийн хувьд яллагдагчтай ямар харьцаатай нь анхаарвал зохих асуудал яах аргагүй мөн. Эдгээр нь тухайн шийдвэр гаргахад нөлөөлж болохыг үгүйсгэх аргагүй юм.

Шүүх, прокурор, мөрдөгч аливаа шийдвэр нотлох баримтад л үндэслэхгүй бол тэр нь хууль бус дур зоргын шинжтэй болон хувирч хүний эрх, эрх чөлөөг бүдүүлгээр зөрчихөд хүргэнэ.

Нотолгооны хэмжээ хязгаар нь нотолгооны зүйлтэй харилцан уялдаатай боловч агуулгын хувьд өөр ойлголт юм. Нотолгооны хэмжээ хязгаар нь хэргийн бодит үнэнийг эргэлзээгүй тогтооход хангалттай⁶ нотлох баримтуудын нийлбэр цогц юм. М.С.Строгович: "хэргийн бодит байдлыг гарцаагүй тогтооход тулгуурлах үйл, баримт, мэдээ, мэдээллийн нийлбэр"⁷ гэж тэрхүү хэмжээ хязгаарыг тодорхойлжээ.

Нотолгооны зүйл нь хэргийн бодит байдлыг тогтоож, үнэн зөв шийдвэрлэхэд шаардлагатай ямар байдал байгааг

⁶ Хангалттай, хүрэлцэхүйц гэсэн ойлголтуудыг өрсөлдүүлэх шаардлага ЭХХШ ажиллагаанд төдийлөн гардаггүй. Б.Батзориг. Нотолгооны онол. 1999 он. УБ. 18-26 дахь тал

⁷ М.С.Строгович. Теория доказательства. М. 1993 г. с 8-10

илэрхийлдэг бол **нотолгооны хэмжээ хязгаар нь** нотлогдвол зохих байдлуудыг эргэлзээгүй гэсэн итгэл үнэмшлийг бүрдүүлэхэд хүрэлцэхүйц, хангалттай нотлох баримтуудын цогц шинжээр тодорхойлдог.

ЭХХШ ажиллагаанд нотолгооны хэмжээ хязгаарыг үндэслэлгүй багасгах, эсхүл шаардлагагүй байхад өргөжүүлэх нь ноцтой төөрөгдөлд хүргэж болно.

3. Нотолгоо, түүний үе шатууд

Нотлох ажиллагаа нь ямар ч гэмт хэргийн онцлогоос үл хамаарах, аливаа ямар ч тохиолдолд танин мэдэхүйн алхмуудаар явагддаг үйл ажиллагааны тогтолцоо юм.

Нотолгоо гэдэг нь ЭХХШт хуулийн заалтад үндэслэн эрүүгийн хэргийг үнэн зөв шийдвэрлэх, бодит байдлыг бататган буулгахын тулд болж өнгөрсөн үйл явдлыг нотлох баримтын тусламжтайгаар тогтоож танин мэдэх, баримтжуулах үйл ажиллагаа мөн.

Нотолгоо нь ЭХХШ ажиллагааны хөдөлгөгч хүч бөгөөд түүний үр дүнд процессын нэг үе шатаас нөгөөд дэвшин шилжих, эцсийн дүндээ хэргийг үнэн зөв бодитойгоор шийдвэрлэх боломжийг бүрдүүлдэг.

ЭХХШ ажиллагаан дахь хэргийн нөхцөл байдлыг тогтоох ажиллагаа нь шалгах байгууллага болон шүүхийн хэлэлцүүлгээр нягт нямбай хянагдсан үндэслэлтэй, хууль ёсны байх учиртай. ЭХХШ ажиллагаан дахь нотолгооны процесс нь **дараах онцлогтой**. Үүнд:

- Тодорхой хугацаагаар хязгаарлагдсан
- Тухайн үйл явдлын талаар шийдвэр гаргахад чиглэгдсэн
- Зөвхөн ЭХХШт хуульд заасан хэрэгслийг ашиглахыг зөвшөөрсөн
- Зөвхөн хуулиар эрх олгогдсон албан тушаалтан явуулах эрхтэй байна.
- Нотолгооны процесс нь дараах үе шатуудыг дамжин явагдана. Үүнд:
- Нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх
- Нотлох баримтыг шалгах, үнэлэх

Гэхдээ ингэж хуваах нь харьцангуй шинжтэй, амьдрал дээр тэдгээрийг хооронд нь шууд зааглахад бэрхшээл тулгарч болно. Тухайлбал, нотлох баримтыг цуглуулах үед уг хэрэгт хамааралтай эсэхэд заавал үнэлгээ өгөх шаардлага тавигдах нь ойлгомжтой.

4. Нотолгоо эрүүгийн процесс ажиллагааны үе шатыг тодорхойлогч болох нь

Өнөө үйлчилж буй ЭХХШт хуулиар Шүүхийн өмнөх шатыг **хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт** хэмээн 2 бие даасан зорилго чиглэлтэй цогц ажиллагааны бүрдэл гэж үзсэн байна. Хэрэг бүртгэлт нь гэмт үйл явдал, **эзэн холбогдогчийг** илрүүлэн тогтоох 2 үндсэн үүрэгтэй. Түүнийгээ хэрэгжүүлэхдээ Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл дэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хүртэл “ашиглах” өргөн боломжтойгоор хуульчлагдсан. Чингэснээрээ, эзэн холбогдогч нь олдохгүй, эргэлзээтэй байна гэдгээр **хэргийг түдгэлзүүлж** эрүүгийн эрэн сурвалжлах ажиллагаанд

даатган “хоёр яс хагацдаг” уламжлалт арга барил эрс өөрчлөгдөх нөхцөл бүрджээ.

Гэхдээ “хэрэг бүртгэлт” нэрээр ээдрээтэй ноцтой, нуугдмал, зохион байгуулалттай хэргийн сэжиг бүхий этгээдүүд, эрхтэн дархтануудыг хаацайлж “Танд эрүүгийн хэрэг ч үүсгээгүй, зөвхөн шалгасан нэр зүүж байгаа юм шүү” гэсэн ойлголт өгч “тал засаад” эхэлбэл мөрдсөн, мөрдүүлсэн аль ч этгээдэд өлзийтэй хохирсон этгээдэд хор уршигтай ажиллагаа болж хувирна.

Түүнчлэн анхан шатны шүүх хуралдаанаас “хэрэг буцааж болохгүй” гэсэн “Элбэгээ ерөнхийлөгчийн ивээлд багтдаг” **шүүх судлалын** гэх тодотгол бүхий онолч эрдэмтдийн өнөөгийн

амьдралд үл нийцэх үзэл баримтлалаас болоод прокурор хэргийг буцааж өгөөч гэж хэчнээн хүсээд ч огт нэмэргүй болгосон ЭХХШТ шинэ хуулийн маань зохицуулалт яаж үйлчлэх бол гэхээс яс хавтайх юм.

Учир нь манай өнөөгийн болхи ажиллагаанаас болоод “мөрдөхөө мөрдлөө” гэсэн ч “шүүхээр тогтоогдсонгүй” гэж олон арван хэлмэгдэгсэд тодрохыг үгүйсгэх аргагүй.

Энэ бүхнээс үзэхэд, эрүүгийн процесс ажиллагааны амин сүнс болсон нотолгооны материаллаг болон процесс үндэслэлийг ул суурьтай ойлгон орчин цагийн чиг хандлагын үүднээс байнга нягтлан үзэх цаг тулгарч байна.

НИЙГМИЙН (СОЦИАЛ) ШИНЭТГЭЛИЙН ЗАРИМ ГАЖИГ

Н.ЖАЛБАЖАВ

(Шихихутуг судалгааны хүрээлэнгийн
захирал, Ph.D, профессор)

Сүүлийн үед нийгмийн ухамсрын хүрээнд олны анхаарал татаж буй асуудлаар судлаачид сонирхолтой өгүүлэл бичсэнийг олны анхааралд толилуулж байна. Судлаачид нийгмийн социал өөрчлөлтөд ажиглагдаж буй гажиг буюу объектив, субъектив хүчин зүйлээс уялдан гарч буй алдаа завхрал, хүндрэл бэрхшээл, түүнчлэн улс үндэстний нийгмийн ухамсар, хүмүүний болон үндэсний ой санамж зэрэг асуудлаар дэвшүүлэн буй "бодрол, бясалгалын" зүйлүүд нь "номын садан" нарт ухаан бодлоо уралдуулах өчүүхэн ч атугай сэдэл болгохыг зорьжээ.

Санасан зорьсон нь бүтэх болтугай.

Нийгмийн амьдралын бүх салаа мөчирт (эдийн засагт, нийгмийн улс төрийн тогтолцоонд, хүмүүсийн харилцаанд гэх мэт) ардчиллын хэм хэмжээг түгээх, сахиулах, нийгмийн бүлэг, давхаргын гармони буюу зохицлыг хангах, социал шинэ соёлыг төлөвшүүлэхэд ихээхэн хүндрэл бэрхшээлтэй тулгарч онол, арга зүйн хувьд ч, практикийн хувьд ч шийдэх шинэ, шинэ асуудал хөврөх болов. Үүнтэй холбоотойгоор **"Нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн гажиг"**-ийн тухайд их ярьж бичих болов. (Тухайлбал: Ч.Даваадаш. Монголын нийгмийн шилжилтийн зарим онцлог. УБ.,2017он; З.Т.Голенкова.Даяаршлын нөхцөл дэх шилжилтийн нийгмийн гажиг, шилжилтийн нийгэм: шинэтгэл, соёл иргэншлийн асуудлууд.УБ.,2012он; Д.Дагвасүрэн. Монголын капитализмыг

яаж хүмүүнлэг болгох вэ?.УБ., 2016 он гэх мэт).

Судлаачид "нийгмийн гажиг" буюу нийгмийн хувьсал, хөгжлийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээл, зөрчил, алдаа завхрал зэрэг объектив (хүний хүчин зүйлээс үл хамаарах) болон субъектив (төрийн бодлого, хүмүүсийн үйлдэл, үйл ажиллагаа гэх мэт) хүчин зүйлээс үүдэн бий болж буй сөрөг (муу) үзэгдлүүд, тэдгээрийн уршиг, үр дагавар зэргийн учир шалтгааныг олох, туулах, арилгах, саармагжуулах, засаж залруулах арга замыг эрж хайхад анхаарлаа төвлөрүүлж байна.

Зарим сөрөг үзэгдэл (нийгмийн гажиг)-үүд тухайлбал олигархижилт, авлига, ажилгүйдэл, ядуурал зэрэг нь нийгмийн тогтвортой хөгжил, тэнцвэрийг алдагдуулах улмаар улс үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх түвшинд хүрсэнд санаа зовницгоож, хэлж анхааруулсаар авай.

Хэлний тайлбар толь зэргээс үзэхэд аливаа шулуун юм хэвийн байдлаас гарах (Алдагдах, эсхүл хэвийн хэмжээнээс өөрчлөгдөх) хазайж муруйхыг гажиг гэдэг байна. Гажиг олон төрөл, зүйл байх, Тухайлбал:

- **өсөлтийн гажиг**-өсөлтийн явцад гарах хэвийн бус үзэгдэл;
- **ухаан мэдрэлийн гажиг**-(Л.Түдэв

“Уулын үер”);

- **гажиг** **зожиг**-ганцаардмал, бусадтай таардаггүй;
- **гажиг зөрүүд** - үг авдаггүй, этгээд зөрүүд гэх мэт (Гоголийн Плюшкин эсхүл Гобсек лугаа).

Нийгмийн гажиг ч гэж байдаг ажээ. Нийгмийн үйл явц (өрнөл, хөгжил, үр дүн, үр дагавар гэх мэт) жам ёсны (байх ёстойн) голдирлоос зөрөх, хазайх, хүсэн хүлээсэн үр дүнд хүрэхгүй байхыг З.Т.Голенкова, А.С.Железняков нарын орос судлаачид **нийгмийн гажиг** гэсэн байх жишээтэй.¹

Даяаршлын гэгдэх энэ цаг үеийн “Глобаль” нийгэм, нэг төрлийн бус технологийн, эдийн засаг-санхүүгийн, экологийн (жишээ нь далаад гарцтай эсэх), хүний хүчин зүйлийн (хүн амын тоо, бүтэц, бүрэлдэхүүн гэх мэт) зэргээс шалтгаалан хөгжингүй, хөгжиж байгаа эсхүл уламжлалт, аж үйлдвэржсэн (АНУ, Япон, Европын холбоо гэх мэт) аж үйлдвэржилтийн дараах, мөн хэлбэршлээсээ хамааран модерн, постмодерн (ихэнхдээ судлаачдын хэрэглэж буй үг хэллэг) гэж ангилагдаж байна.

Марксын сургаал сонсож өсч өндийсөн манай ахмадуудад хүй нэгдлийн, боолын, феодалын, капиталист, коммунист нийгэм (эсхүл ангийн ба ангийн бус нийгэм) гэж ангилах нь чихэнд илүү нийцтэй мэт. Вебер нарынхаар нийгмийг улс төрийн тогтолцооны шинжээр нь харизмын болон уламжлалын гэх зэргээр ангилах

¹ Шилжилтийн нийгэм: шинэтгэл, соёл иргэншлийн асуудлууд.УБ., 2012 он. 174-175 дахь талд

жишээтэй.

Нийгмийн ийм олон төрөл байдал “Гажиг” үүсэх нэг үндсэн шалтгаан болдог байна. Энэ нь хөгжлийн зөрүү ихсэх, хөрөнгө капиталын хүчин чадал цөөн улс орнууд, үндэстэн дамнасан корпорацуудын гарт төвлөрөх, уршиг үр дагавар нь хөгжлөөр дорой, жижиг буурай улс орнууд өр ширэнд баригдан улмаар эдийн засгийн бие даасан байдал, тусгаар тогтнолоо алдахад хүргэх магадлалтай ажээ. Судлаачид (З.Т.Голенкова, Горшков нар) ийм төрлийн **гажгийг глобаль** хэмээн нэрийдсэн байх.

Зах зээлийн эдийн засгийн **чөлөөт өрсөлдөөний зохицуулалтын механизмд ажиглагдаж буй зөрчил, түүний уршиг**, үр дагаврыг мөн глобаль (нийтийг хамарсан) гажиг гэх үндэстэй юм. Зүй нь (“байх ёстой”-н үүднээс) зах зээлийн эдийн засгийн өсөлтийг хувийн өмчийн ид шид буюу Адам Смитийн томьёолсон “Зах зээлийн далд гар”-ын хүчин зохицуулах учиртай боловч энд нийгмийн материал баялгийн хуваарилалтын шударга ёсны зарчим алдагдах, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нигууртайг дэлхийн их, бага улс орнуудыг хамарсан эдийн засаг, нийгмийн хямралт үйл явцууд нотолж буй. Эдийн засгийн ямарч зохицуулалт үгүй либеральчлал (хувийн, хэсэг бүлгийн ашиг сонирхлыг дур зоргонд нь тавих гэсэн санаа) зах зээлийн үнэт зүйлс болох өсөлт, тогтвортой хөгжил, тэнцвэрт байдлыг алдагдуулах уршигтай ажээ. Учир нь чөлөөт өрсөлдөөнийг зөвхөн далд гарын ид шидэнд дулдуйдан зоргоор тавибал эдийн

засагт монополчлогдох, улмаар нийгэмд санхүү-эдийн засгийн олигархуудын нөлөөлөлд автан тэдгээрийн ашиг сонирхол төрийн бодлогыг тодорхойлох гол хүчин зүйл болох магадлалтай гэж үздэг байна.

Нөгөө талаас эдийн засагт төрийн оролцоог зөвхөн татвар, мөнгөний бодлого, хөрөнгө оруулалтын механизмаар хязгаарлахгүй бол нийгмийн социал ялгарал лавширах, авлига, хээл хахууль газар авдгийг постсоциалист орнуудын сургамж нотолж буй. Тэгэхлээр “хөндлөнгийн оролцоо”, “эс оролцоо” буюу “зохицуулалт”, “эс зохицуулалт” нь зах зээлийн нийгэм олох “Капитализм”-ын өөрийнх нь мөн чанартай холбогдох асуудал. Британийн энциклопедид бичсэнээр капитализм нь зах зээлийн эдийн засаг, хувийн өмч, чөлөөт аж ахуй эрхлэлт бөгөөд үйлдвэрлэлийн хэрэгслийн ихэнх нь хувийн өмчид байдаг, харин үйлдвэрлэл ба хуваарилалт зах зээлийн механизмын үйлчлэл дор явагддаг эдийн засгийн систем мөн ажээ.

Далд гарын ид шидийн давуу тал нь зах зээлд хамгийн хямд бөгөөд хамгийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэгчдийн гарт очих, өрсөлдөөн нь ашгийн нормыг тэгшитгэж улмаар салбаруудын хооронд хөдөлмөр ба капиталын оновчтой хуваарилалтыг бий болгодог. Гэхдээ үүнийг зөнд нь орхивол эдийн засагт өрөөсгөл байдлыг үүсгэх, өөрөөр хэлбэл үйлдвэрлэл, үйлчилгээний аль нэгэн төрөл зүйлийн монополыг бий болгох магадлалтай.

Английн философич, социологич Герберт Спенсер 1862 онд бичсэн “Үндсэн эхлэлүүд” буюу “Эхний зарчим” бүтээлдээ капитализмын мөн чанарыг “Илүү зохицох чадвартай нь амьд үлдэх” гэж тодорхойлсон байдаг. Хөндлөнгөөс оролцохгүй байх, өрсөлдөөнд эдийн засгийн хүчтэй нь эдийн засгийн хүчгүйгээ шахан зайлуулах нь капитализмын нууц, мөнөөх хувийн өмчид суурилсан чөлөөт зах зээлийн “далд гар”-ын ид шидийн нэгэн ажээ. Энэ нь яван явсаар зах зээлд дангаар ноёрхох буюу монополд хүргэдэг байна². Учир иймд зах зээлийн эдийн засагт гажиг (гажуудал) үүсэх, газар авах магадлал өндөр бөгөөд түүнийг сааруулах, саармагжуулах хүчин зүйл бол татвар, хөрөнгө оруулалт, гол нь хууль эрх зүйн оновчтой зохицуулалт зэрэг арга хэрэгслээр хэрэгждэг төрийн зохицуулалт гэх үндэстэй юм.

Гажигийн илрэх хэлбэрүүд:

- Нийгмийн социал ялгарлын туйлшрал буюу баян хоосны хэт зөрүү, ажилгүйдэл, ядуурал газар авах;
- Хөрөнгө, капитал цөөнхийн гарт төвлөрөх, монопол үүсэх, улмаар санхүү эдийн засаг, улс төрийн эрх мэдэл төвлөрөн нийгэмд олигархиудын ноёрхол тогтох;
- Эдийн засагт өрөөсгөл эмзэг байдал лавшрах. Тухайлбал бага, буурай хөгжилтэй улс орнуудад зөвхөн уул уурхайг шүтсэн эсхүл гадаад зах зээл, гадаадын хөрөнгө оруулалтаас

² Догсомын Дагвасүрэн. Монголын капитализмыг яаж хүмүүнлэг болгох вэ?. УБ., 2016 он.б-7 дах талд

үлэмж хамааралтай эдийн засагтай болох "баялгийн хараал"-д өртөх гэх мэт.

- Эдийн засагт хуурамч өсөлт (энэ нь түр зуурын шинжтэй бөгөөд гадаад зах зээлээс үлэмж хамааралтай өсөлтийг хэлж буй хэрэг) үүсэх, эдийн засгийн өрөөсгөл, эмзэг байдалтай холбоотой асуудал юм. Энэ бол мөн л түгээмэл, глобал шинжтэй гажиг юм. Хуурмаг "хоосорсон" өсөлт түр зуурын шинжтэй, гадаад зах зээлийн конъюнктураас үлэмж хамааралтай хэврэг, эмзэг, эдийн засгийн үндсэн салбаруудын; тухайлбал аж үйлдвэр, хөдөө аж ахуй (мал аж ахуй, газар тариалан), нийгмийн үйлчилгээ зэргийн зохистой харьцаа, тэнцвэрт байдлыг алдагдуулах нигууртай бөгөөд улмаар улам хүнд хямралд хүргэх магадлалтай ажээ.

Эрдэмтэн судлаачид нийгмийн улс төрийн систем (юны өмнө төр, төрийн эрх мэдлийн хуваарилалт, эрх зүйн зохицуулалт, хүний эрх, эрх чөлөөний баталгаажилт, сонгуулийн систем, иргэний нийгмийн төлөвшил, нийгмийн социал бүлгүүдийн зохицол гэх мэт)-ийн хэмжээнд илэрч буй зөрчил, хямрал зэргийг **төр-иргэний нийгмийн харилцааны гажиг хэмээн тодорхойлж байна**. Ардчилал, зах зээлийн харилцаа төлөвшсөн, төлөвшин буйгаас үл хамааран ардчиллын нэг тал буюу зөвхөн эрх чөлөө, дур зоргийг туйлчилсан либерализмын хямрал, эсхүл төр олигархигжиж "олонх, цөөнхийн" хэмээх ардчилал жинхэнэ утга учраа алдаж буйн нийтлэг үзэгдэл, сонгуулийн системийн хямрал, иргэний

нийгмийн төлөвшлийн удаашрал, төрийн эрх мэдлийн хуваарилалт алдагдах, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл холилдон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, төр түүний албан тушаалтан нар авилгад автах, төрийн удирдлагын нөлөө нэр хүнд алдагдах зэрэг нь ийм төрлийн буюу "тогтолцооны" ч гэж хэлж болох гажгийн илрэх үндсэн хэлбэрүүд нь болж байна. Төрд баячууд (олигархиуд) олноор шургах, иргэний сонгох, сонгогдох эрх, эрх чөлөө худалдагдаж боймлогдох, ядуурал газар авч ядууралтай тэмцэх, байгаль орчныг хамгаалах нэрийдлээр мөнгийг үрэн таран хийх, эдийн засагт монопол бүлэглэлүүдийн зөрчил ширүүсэх зэрэг нь ийм төрлийн гажиг бодитойгоор илэрч буй хэрэг юм. Төрийн удирдлагад бодит байдал дээр олон нийтийн (ард түмний) хяналт, оролцооны механизм төлөвшөөгүй, үүрэг хариуцлагын тогтолцоо алдагдсан, хууль, эрх зүйн зохицуулалт тодорхой, оновчтой бус зэрэг нь ийм гажуудал үүсэх үндсэн учир шалтгаан нь болдог байна. Үндсэн хууль, үндсэн хуульт ёс, бүгд найрамдах засаглалын хямралын тухай ч ярьж, бичиж, маргацгааж байна.

- Зах зээлийн чөлөөт өрсөлдөөний нийгэм, хэрэглээний нийгэмд нийтийг хамарсан ёс суртахууны доройтлыг **нийгмийн шинэчлэлийн "нэгэн сүүдэрт тал" буюу нэгэн гажиг хэмээн тодорхойлж байна**. Энэ бол зарим судлаачдын дүгнэж буйгаар тогтолцооны гэж бидний нэрлэсэн ардчиллын гажигтай шууд холбоотой, үр дагавар нь болох үзэгдэл юм. "Дүр эсгэсэн

ардчилал, дарангуйлалаас илүү хортой. Нийгмийн гажуудлыг засахгүй байх шалтгаан болдог”, “хуурамч ардчилал бол хариуцлага, сахилга бат, шийтгэл, алдагдсан эмх замбараагүй нийгэм болгож, хөгжилд бодит хор хүргэдэг (Сингапурын ерөнхий сайд асан Ли Куан Юу) байна. Бүр манай тооллын өмнөх үед Платон “Ардчиллын үед ард иргэд хуулийг сахин дээдлэхээ болино, хаа сайгүй эдийн хэрэглээ тархаж дэлгэрнэ, хүмүүс бие биеэсээ хөндийрнө, хувиа хичээнэ...Туйлын эрх чөлөө нь туйлын боолчлол болж хувирна. Олон нийтийн дураар авирлах явдал хэн нэгний дураар авирлал болж хувирна, улмаар ардчилал өөрийн диалектик эсрэг байдал болж дарангуйлалд шилжинэ” гэж анхааруулж байжээ.³

Нийгмийн энэ гажгийн гол уршиг нь нийтийн зорилго, хүсэл эрмэлзэл, идеал (туйлын хүслэн, зорилго) амин хувийн (эгоист) материаллаг ашиг сонирхол (хөрөнгөжих, баяжих)-д идэгдэх (автах), нийгмийн бүлэг давхаргын зөрчил тэмцэл ширүүсэх, автах хэрэг юм. Үүнийг академич, гавьяат хуульч С.Нарангэрэл⁴:

“Гайхамшигт өвөг дээдэс, үүх түүхтэй, эх байгаль, мал сүргээсээ эрүүл хүнс тэжээлээ хүртдэг монголчууд өнөөдөр

эрхэм дээд ямар ч зорилгогүй, мөнгө яаж олохов, хэрхэн яаж үрэх вэ гэсэн хоёрхон зүйл боддог нэг эст амьтан болон хувирсаар байна. Ард түмэн өдрийн үмх мах, зугаа цэнгэл хоёроос өөр юм бодохоо байн бусармаг явдалд дөрлүүлэх боллоо. Ийм хөрсөн дээр архидалт, мансууруулах зүйл, хормой хотны хувьсгал үерийн ус лугаа сад тавив. Бүх юм болно, бүх юм чөлөөтэй, хүн бүхэн эрхтэй ... гээч болов. Гэтэл энэ бүхний ард монгол хүн танигдахын аргагүй өөрчлөгдөн хувирч, монголчууд хамгийн ёс суртахуунгүй ард түмнээр нэрлүүлэх болов. Эрхтэй эн зэрэгцэн үүрэг, хариуцлага байдгийг мартаж шахжээ. Хувийн хариуцлагагүйгээр эрх дур зоргын авирлал болдгийг бид бэлхэнээ ухаарах боллоо.

Эх эцэг, өвөө эмээгийнхээ үгийг тоодоггүй, дуулгаваргүй, за гэдэг үгийг мэддэггүй, гар утас фейсбуукт донтсон хүүхэд багачууд-хойч үеийг “хүүхдийн эрх” гэгчээр хүн болгож чадах уу? гэсэн хурц асуудалтай бид өөрийн эрхгүй тулгарч байна. Толгой нь торлогдсон хүмүүс ч их болов. Тэд бусдын эрхшээлд автсан адгуус болон хувирч байна. Бид “хүний эрх”, “эрх чөлөө”, “тэгш эрх”, “ардчилал” гэх мэт ерөнхий нэр томъёогоор хөөцөлдсөөр байгаад, үүрэг, хувийн хариуцлагыг орхигдуулсаар байгаад хаашаа явж байгаагаа ойлгохоо болих дөхөж байна. Энэ учраас судлах, дүгнэлт гаргах, ирээдүйн зүг чигийг зөв тодорхойлох зэрэг олон асуудал шинжлэх ухаанд хүлээгдэж байна.” гэж дүрслэн хэлжээ.

Монголын нийгэм ёс суртахууны хомсдолтой байгааг гадаадынхан ч

³ Догсомын Дагвасүрэн. Монголын капитализмыг яаж хүмүүнлэг болгох вэ?. УБ., 2018 он. Дам ишлэв. 69-70 дахь талд.

⁴ Шихихутуг Их Сургууль. Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа: онол, практикийн асуудал. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал. УБ., 2018 он. 19-20 дахь талд үзнэ үү.



олж хараад хэлж анхааруулж буй нь цөөнгүй. Тухайлбал:

Японы судлаач Камура Аяако гэгч (интернэтэд): "...Хагас жил Монголд байхгүй байгаад буцаж ирэхэд юм болгон хөгийн байдалтай харагдаад, монголчууд нэг л хөгийн санагдаад болж өгдөггүй... Ер нь монголчууд нүдэнд харагдах ашгаас өөр сонирхолгүй, юу ч хэлээд нэмэргүй... Монголчуудыг харахаар л юмыг зөвхөн хэлбэрдээд л, агуулгыг нь орхих шиг бодогдож, санаа зовох юм... Мэдлэг нь өөрөө олж авсан биш, дандаа бусдаас л дуулсан зүйл байдаг. Ижилхэн санаа бодолтой, нэг түвшний хүмүүс уулзаж, ярилцахдаа ч хөгжиж дэвшихэд ямар ч нэмэргүй... Тархины тураал. Сайн сураагүй гэж хэлүүлсэн хэрнээ, бас өөрөө түүнийгээ мэдэж байгаа хэрнээ бодож санах юмгүй яваад л байна... Хэрэг болбол залхтал гуйж хоргооно, хэргээ бүтсэн хойно таг чиг болно... Дэлхий нийтээс ялгарах монголчуудын нэг онцлог бол дээр дурдсан хэргээ бүтмэгц таг чиг болдог зан"⁵

Ёс суртахууны доройтол эсхүл ялзрал хэрэглээний нийгэм дэх түгээмэл үзэгдэл авч Монголын нийгэмд илүү хүнд тус ч байгааг үүнээс илүүгээр онож хэлэх нь юу л бол. Энэ бол хүний язгуурын мөн чанар (хүн байгалийн зүйл, нэгэн төрөл зүйл амьтан), инстинкт (төрөлх мэдрэмж)-ийн ертөнцтэй нь холбоотой тул архаг өвчин лугаа илааршуулахад нь үлэмж цаг хугацаа, хүч чармайлт хэрэгтэй нийгмийн өвчин эмгэг гэлтэй. Монголчууд хүний нэг мөрөн дээр

бурхан заларч, нөгөөд нь чөтгөр шүглэсэн гэдэг нь туйлын мэргэн ухаан. Өнгө зүс, мөнгө хөрөнгө, тав тух, нэр алдар, сүр хүчинд дулдуйдах, татагдах нь хүн бүрт л байх зүйл. Харин тэдгээрийг хянаж цагдах, хязгаарлах нь хүний "ухаантай" нь ертөнц буюу мэдлэг боловсрол, хүмүүжил төлөвшлийн хүч, нөлөөний асуудал. Энэ бол хүн ардаа боловсруулах, гэгээрүүлэх, хүмүүжүүлэх, зохион байгуулах, зөв үйл хэрэгт залж удирдах төрийн бодлого, үйл ажиллагааны нэр хүнд, нөлөө, үр дүнгийн үзүүлэлт. Тиймийн учир нийгэмд итгүүлсэн үнэмшүүлэх иргэдийн (эрх зүйн боловсрол, эх оронч үндэсний үзэл, хүмүүжил, ухааруулах, сэнхрүүлэх гэх мэт) болон албадлагын (хуулийн зохицуулалт, шийтгэл, зэмлэл гэх мэт) бүх арга хэрэгслээр, бүх нийтийн санаа зоригоор шударга ёс, үүрэг хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхгүйгээр энэхүү гажгаас салж, ангижрахаас өөр зам үгүй мэт.

⁵ Д.Дашпүрэв. Монголын нийгэм. УБ., 2017 он. 52 дахь талд иш татсаныг үзнэ үү.

Шигтгээ. Аристотель ("Дээд суртахуун" номондоо):

"Маш товчоор хэлбэл, ёс суртахуун бол төр улсын ухааны бүрэлдэхүүн хэсэг юм. Нээрээ ч үндсэндээ ёс суртахууны тодорхой чанаргүй хүнийг, тухайлбал, тэнцэхгүй хүнийг улс төр-олон нийтийн ажилд оролцуулах огт хэрэггүй билээ. Тэнцэж чадах хүн гэдэг бол сайн үйлчилгээ эзэмшсэн хүн гэсэн үг. Олон нийтийн болон төр улсын амьдралд зөвөөр оролцье гэж бодож байгаа тэр этгээд сайн үйлийн дээд суртахуунтай хүн байвал зохино. Тэгээд бодохлоор ес зүй бол улс төрийн нэг хэсэг, нэг эхлэл (арче) болж түүнд багтан ордог, ер нь миний бодлоор бол, энэ судлагдахууныг ёс зүй гэх бус, харин улс төрийн ухаан хэмээн нэрлэх нь зөв юмаа."

Аристотель ("Уран илтгэхүйн ухаан" номондоо):

"Сайн үйл бол сайн сайхныг олж хадгалах бололцоо мөн, бас бус олон чухал тохиолдолд нийтэд ерөөлөө боломжтой бүхий л тохиолдолд ач тус үзүүлэх бололцоо юм" гээд "Сайн үйлийн хэсгүүд нь шударга ёс, эр зориг, тохитой ухаан, өгөөмөр сэтгэл, уудам бодол, харамгүй ааш, даруу зан, ухаан зарах сэтгэлгээ, мэргэн ухаан зэрэг чанаруудаас бүрэлддэг хэмээн" тайлбарлажээ⁶.

Ерөөс харьяат иргэнийхээ сэтгэл оюуны, ноён нурууг (Ч.Лодойдамба) хугарч нугарах элдэв нигуураас хамгаалж бэхлэж байх нь төрийн байнгын үүрэг нь бус уу. Хамгаас чухал нь иргэндээ, эх орондоо, шударга хөдөлмөр, авьяас билгээрээ сэтгэл хангалуун аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх хэрэг мөн.

ОЙ САНАМЖ, ҮНДЭСНИЙ ОЙ САНАМЖ ГЭЖ ЮУ ВЭ?

Ой санамж (оросоор память, англиар memory)-ыг байгаль, нийгмийн шинжлэх ухаанууд (тухайлбал, хүний анатоми, физиологи, сэтгэл зүй, мэдрэл судлал, социологи, антропологи,

философи, логик) өөр өөрсдийн судалгааны объект болгон нарийвчлан судалдаг байна.

Эрдэмтэн, судлаачдын дийлэнх нь энэ бол хүнийг сүүн тэжээлт, сээр нуруутан амьтдаас онцгойлдог ухамсрын илрэх дээд хэлбэр мөнгийг нотолдог ч халим загас, араатны популяци (олонлог буюу зохион байгуулалттай сүрэг гэх мэт)-уудын уураг тархины үйл ажиллагаанд хийсэн судалгаа, туршилтууд нь ой санамж зөвхөн хүнд заяагдмал зүйл төдийгүй дээр дурдсан адгуусан амьтны зарим үйлдэл (сүрэг араатны ан гөрөөний зохион байгуулалт, нутаг орноо таних, олох мэдрэмж гэх мэт) үнэхээр гайхширалд хүргэсэн дүгнэлтүүдэд хүргэдэг байна. Ан хийж буй арслан, чоно, цөөврүүд, ирвэсийн сүргийн зохион байгуулалт (отолт, бүслэн хаах, дайралт хийх гэх мэт) эсхүл сүрэглэн буй сармагчин, гөрөөс зэрэг амьтдын зохион байгуулалт бүр хүний ой тойнд оромгүй уран, нарийн байдаг шүү дээ. Алсын алс харь оронд галт тэрэг, усан онгоц зэргээр ачигдан хүргэгдсэн Монгол морь нутагтаа гүйн ирсэн домог гэмээр яриа ч бий. Харийн орноос тэр олон гол мөрөн, төмөр зам, хот суурин, араатан, хүн амьтны зүгээс учрах саад бэрхшээлийг яаж туулсан, нутгаа яаж олсон зэрэг нь санаанд багтамгүй.

Араатны сүргийн ан гөрөө хийх үед нь байсан зохион байгуулалт нь олзоо хуваах болохоор ямар амархан нурж илүү түлхүү өмх махны төлөө үр зулзагаа ч тасар татан хаяхад бэлэн болдгийг бид "Geographical Channel" зэрэг телевизийн нэвтрүүлгээс зөндөө үзсэн.

⁶ Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. 20 дахь талд

⁷ Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. 50 дахь талд.

Ой санамж ихэнхдээ түр зуурын юм шиг. Оч үсрэх мэт гэнэт орж ирээд нүдэнд чинь сэхээ авах завдалгүй үзэгдээд эхэлдэг ажээ. Түүнийг шууд хянах боломжгүй. Тэр ч бүү хэл санаж буй зүйлээ мартаж гээд чаддаггүй байна. Хүний тархи утгатай зүйлсийг хадгалахаас биш, архив, эсвэл компьютерын санамж шиг бүх зүйлийг хадгалдаггүй. Бас ой санамжийн "олон нууц"-ын нэг нь ой санамж танил, эсхүл танил бишийг ялгасны дараа хоёр дахь шийдэл гаргадаг нь: чухал бусаас чухлыг ялгах "чадвар" ажээ.

Хүний ой санамж нийтлэг, түгээмэл, мөн үндэстэн, ястны эсхүл ажил мэргэжлийн, (хөдөлмөрийн хуваарийн) анги, бүлэг давхаргын өнгө аястай байдгийг бид мэднэ. Ухамсарт хүн бүрт сайн сайхныг, буруу зөвийг мэдрэх, ухаарах, хайрлах, дурлах, хүсэх, тэмүүлэх, өлсөн цангах мэдрэмж нэг адил заяагдмал зүйл. Харин өнгө аяс нь тухайн улс, үндэсний хөгжил, дэвшил, соёл иргэншлийн өвөрмөц, боловсрол мэдлэгийн түвшин, амьдралын орчин зэргээс нь хамааран хурц, тод бас бүүдгэр бүрхэг байх. Энэ бүхэн нь ой санамжийн үндэсний (улс үндэстний) хэмээх түвшинг тодорхойлох гол хүчин зүйл гэх үндэстэй юм. Тэгэхлээр **үндэсний ой санамж** (товчоор илэрхийлэхэд) нь биологийн, нийгмийн, экологийн хүчин зүйлүүдтэй хамааралтай нь тодорхой байна. Үүнийг Эрих Кандел, З.Ш.Фрейд нарын "Доод би" ба "Би", "Дээд би"-ийн үүднээс тайлбарлавал нэг бүрийн (хувь хүний) ой санамжид "Ухаангүй" буюу сэтгэхүйн болон тусгалын онолын үүднээс бол төрөлхийн мэдрэмж (инстинкт)-ийн

зүйлүүд (өлсөх, цангах, тачаадах, дурлах, шунах гэх мэт) тодорхойлох үүрэгтэй бол үндэсний буюу хүмүүний олонлогийн (улс үндэстний, анги, бүлгийн) ой санамжид үүрэг, зарчим, ертөнцийг үзэхүй, идеал, эх оронч үзэл, хүмүүжил зэрэг "Дээд би"-ийн хүмүүний олдмол (боловсрол, хүмүүжлээр) зүйл зонхилох жишээтэй.

Үндэсний ой санамж нь хүмүүний олонлог (улс, үндэстэн гэх мэт)-ийн ёс суртахууны өнгө аястай, эх орон, ард түмнээ хайрлах, тухайн олонлогийн шашин шүтлэг, ертөнцийг үзэхүй, оршин тогтнохуйн ашиг сонирхол зэрэг нийтлэг зүйлийг шингээсэн. Тиймээс улс, үндэстнийг эвлэлдэн нэгтгэх, нягтруулах оюуны хүчин зүйл болдог байна.

Монголын "Нууц товчоо", "Эрдэнийн эрх", Болор толь "Алтан товч", Хөх дэвтэр (Ванчинбалын Инжиннаши), "Гэсэр", "Жангар" зэрэг Монголын түүх соёлын эх сурвалжууд, домгууд, Гумилев, Марко Поло, Ала-Ад-Дин, Ата-Мелик, Жувейни, Рашид-Ад-Дин, Ц.Дамдинсүрэн, Ш.Бира, Жак Уэтерфорд, Удо Б.Баркманн зэрэг дотоод, гадаадын эрдэмтэн мэргэдийн ном, судраас тунгаавал: **Үндэсний ой санамж бол тухайн улс үндэстэн өнгөрсөн, эдүгээ, ирээдүй цагийн хэлхээнд оршин тогтнох, туурга тусгаар төр улсаа (тусгаар тогтнолоо) бататган бэхжүүлэх, хөгжин дэвжих арга ухаан гэх үндэстэй байна.**

Тайлбар: Зигмунд Шломо Фрайд (1856-1939) хэмээх Австрийн сэтгэл судлаач, психилогич хүний ой санамжийн цаад утгыг тайлбарлах зорилгоор "Ухаангүй"-н хүч чадлын тухай 4 ном бичсэн (1899-1905), хүний "ухаангүй" нь "ухаан"-аа хэрхэн хянадаг тухай тайлбарлахын тулд гурван хэсэг психийн (сэтгэхүйн) төсөөллийг гарган тавьж, хүний амин сүнс нь: "Доод би", "Би", "Дээд би" гэсэн жолоодлогын гурван төвтэй байдаг гэж тайлбарласан. Үүнд: "Доод би" нь хүний сэтгэхүйн (психийн) хөдөлгөөх үндсэн элемент болох "ухаангүй" хэмээх ойлголттой дүйдэг. Жишээлбэл, өлсөх, тачаадах, хорсох, үзэн ядах, итгэх, дурлах гэх мэт. Харин "Дээд би"-ээр зарчим, идеал, үүрэг, үлгэр жишээ, ертөнцийг үзэхүй зэрэг боловсрол хүмүүжлээр олж авдаг зүйлсийг илэрхийлжээ. Энэ хоёрын дунд жинхэнэ "Би" орших ба дээрх хоёрынхоо эсрэг үргэлж тэмцсээр ирсэн ядуухан амьтантай зүйрлэжээ.

Дэлхийд нэртэй санамж судлаач **Эрик Рихард Кандел** (1929 онд төрсөн), Австри гаралтай, Америкийн мэдрэл судлаач, 2000 оны Нобелийн шагналтан. Тэрбээр "Мэдрэлийн мэдлэгийн салбарын зарчмууд" бүтээлээрээ З.Ш.Фройдын хүний ой санамжийн үзэл санааг хөгжүүлэн хүний ой санамж, дурсамж гэж юу вэ? гэдэг асуултад хариу өгөхийг зорьжээ. Фройд нарынхаар ой санамжгүйгээр бид (хүмүүс Н.Ж) өөрсдийн намтар ч үгүй, бас ухаарах амьдрал ч үгүй байхсан. Ойлгох гэдэг нь ямар нэг зүйлийг таньдаг (мэддэг) зүйлтэйгээ холбох мэт. Таньдаг зүйлс нь зөвхөн ой санамжид хадгалсан зүйл ажээ.

Өөрөөр хэлбэл: Үндэсний хэл, оюуны болон биет соёл (утга зохиол, дүрслэх урлаг, дуу хөгжим, нийгэм, төрийн байгууллага, төр ёс, хууль цааз, ёс зүй, ёс суртахуун, зан заншил, ертөнцийг үзэхүй, шашин шүтлэг, монгол аж төрөх арга ухаан гэх мэт)-ын үеэс үед уламжлагдан залгамжлагдах төр, нийгэм, иргэний хэргийг залж удирдах, хөтлөх арга ухааны үнэт зүйлсийн цогцыг үндэсний ой санамж гэж үндэстэй байна.

Энэ бол улс үндэстний дангаарших болон даяаршихын оюуны зохицол

(гармони) нь юм.

Тайлбар: Үндэсний ой санамж нь түүхэн тодорхой үзэгдэл гэж үзэж байна. Учир нь түүхэн тодорхой орон зайд (нөхцөлд) объектив болон субъектив хүчин зүйлийн нөлөөн дор үндэсний ой санамж сэргэх, хурцлагдах бас ч бүүдгэрэх магадлалтай юм.

Эдүгээ үндэстний ой санамжийг хурцлах эсхүл бүүдгэрүүлэх гол хүчин зүйл нь их, бага улс, үндэстэн, ястан бүрийн нийгмийн амьдралын бүх хүрээг хамран өрнөж буй даяаршлын үйл явц болж байна.

Бид даяаршлыг хөрөнгө, капитал, техник, технологи, ажиллах хүчин, оюун ухааны үнэт зүйлсийн хил хязгааргүй урсгал (шилжилт хөдөлгөөн), соёл иргэншлүүдийн харилцан нөлөөлөл гэх утгаар томьёолж, тодорхойлж буйтай санаа нэгтэй байна.

Бид даяаршлын үеийн соёл иргэншлүүдийн шүтэлцэл (харилцан нөлөөлөл)ийг:

- Зэрэгцэн орших (харилцан нөлөөлөх, нэвчин шингэх, уусах үйл явц)
- Зөрчил тэмцэл, харилцан үгүйсгэлийн үйл явц гэсэн 2 чиг хандлагад нь авч үзэж буй.

Соёл иргэншлийн зөрчил тэмцлийн нэг үндэс суурь нь үндэстэн ястны ертөнцийг үзэхүй, шашин шүтлэгийн зөрүү гэх үндэстэй байна.

Энэхүү зөрчил тэмцэл нь нөлөөлөл, оршихуйн орон зайн төлөөх өрсөлдөөн, үгүйсгэл үзэн ядалт, дайн, зэвсэгт мөргөлдөөн (хүчирхийлэл) гэсэн хэлбэрээр илэрч байна. Зарим талаар үндэстэн ястны өс хонзонгийн зүйлс зөрчил тэмцлийн нэг эх сурвалж болж буйг ч үгүйсгэхгүй байна.

Даяаршил хоёрдмол үр дагавартайг газар газрын эрдэмтэн судлаачид санал нэгтэй тэмдэглэж байна. Үүнд:

- Хөгжлийг хурдасгах, улс үндэстнүүдийг ойртуулах;
- Хөгжлийг зөрүүг ихэсгэх, баян, ядуугийн ялгарлыг улс орнуудын хооронд ч (буурай болон ядуу, хөгжсөн, баян, чинээлэг улс орнуудын), тухайн улс орны дотоодод ч хурцлах, нэмэх нигууртай ажээ. Үүнээс гадна бага, буурай улс орнуудын соёл, иргэншлийн оршин тогтнохуйд заналхийлэх, үндэстэн ястны өвөрмөцгийг алдагдуулах магадлалтай ажээ.

Бидний хийж буй энэхүү томьёолол нь Үндэсний ой санамж нь улс үндэстний үндэсний ухамсрын цөм болохыг (цаад утгаараа) илэрхийлж буй хэрэг юм. Монгол хүний оюуны ертөнц бол дахин

давтагдашгүй өвөрмөц өнгө төрхтэй (хорвоогийн үндэстэн, ястан бүрийн л нэгэн адил) бөгөөд хүн төрөлхтний үнэт зүйлсийн охь дээжсийн нэгэн юм.

Монголчуудын үндэсний ухамсар, ой санамж нь сэргэн мандсан, хорвоод хосгүй, эгэлгүй чанар нь тодорсон цаг үе бол суут богд Чингис хаан, түүний үндэслэн байгуулсан Их Монгол Улсын үе байжээ. Гумилевын хэлснээр тэр бол Монголчуудын дотоод их энергийн (эрчмийн) эрин байжээ. Тал нутгийн сурвалжитны хөвгүүн Тэмүүжинд Мөнх хөх тэнгэрээс заяасан ухаан бодол, мэргэн ухаан, сүр хүчээрээ "Дэлхийн хамаг хаадын орой нь байж, хүчирхэг хосровчуудын тухай бичигдсэн болгоныг, Фараонууд (Египетийн хааны цол хэргэм), кесариудын (Юлий Цезарийн нэр) тухай он дарааллын бичиг, эртний сурвалж бичгүүдийг судлах гэж зүдрэлгүй өөрийн хар толгойгоороо хууль, дүрэм тогтоон мөрдүүлсэн юм. Улс орнуудыг эзлэн авсан арга, дайсныхаа сүр хүчийг мөхөөдөг чадварын тухайд гэвэл тэр нь түүний төрөлхийн соргог ухаанаараа сайтар бодож, боловсруулдгийн хүч, өргөн дэвшүүлсэн дотно нөхдийнх нь тус байлаа." (Жувейни "Дэлхийг байлдан дагуулагчийн түүх" номондоо ийнхүү бичиж үлдээжээ.) Персийн түүхч Рашид-ад-дин Судрын чуулгандаа "Ирээдүйд таван зуу, мянга, арван мянган жилд ч хэрэв нарт хорвоод төрж, хаан төр барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэхээр Чингис хааны ёс суртахуун, засаг хуулийг өөрчлөлгүйгээр сахьвал тэдний гүрэнд мөнх тэнгэрээс аврал бууж, тэд хэзээ ямагт баяр баясгалантай,

аз жаргалтай байх болно. Орчлонгийн ихэс ч тэдэнд хишгээ хүртээж, дэлхийн хүн ам ч тэндээ наманчлан залбирсаар, урт удаан наслан, амьдралын сайн сайхан бүхнээр жаргах болно" хэмээжээ. Чингис хаан, тэр үеийн Монголын элитүүдийн суу билиг, ном сурах онцгой чадвар авхаалж, сэргэлэн ухаан нь Барууны эрдэмтдийн байнга татаж байдаг ер бусын үзэгдэл болно" гэж Германы эрдэмтэн Удо Б.Баркман бичсэн байдаг.

Чингис хааны сод ухаан, шударга ёс, өгөөмөр сэтгэл, эр зориг зэрэг ёс суртахууны эрхэм чанар ертөнцийн эгэлгүй удирдагч болгосон бөгөөд зуун зууны туршид түүний зохион байгуулах, удирдан жолоодох мэргэн ухаан, "алд бие минь алжааваас алжаатугай, ахуй төр минь бүү алдраг" алтан сургаал, түүний бодож боловсруулсан **"Их засаг" хууль нь монгол үндэстэн, монгол төрийн ой санамжийн чиг баримжаа нь болсоор иржээ.**

"Их засаг" хууль нь монголчуудын ахуй амьдрал, ёс суртахуун, ертөнцийг үзэхүй, зан заншлыг үндэслэн бүтээгдсэн жинхэнэ жам ёсны хууль байсан учир Их Монгол Улс, феодалын бутрал, Юань гүрэн, Манжийн ноёрхол, Богд хаант Монгол Улс, БНМАУ, Монгол Улс зэрэг Монголын буурал түүхийн бүхий л үед төрийн хууль цаазын бодлого, үйл ажиллагааны нэн чухал эх сурвалж нь болсоор иржээ. Энэ бол үндэсний ой санамж "үеэс үед", "цуснаас цусанд" уламжлагдан залгамжлагдах жам ёстойн бодит нотолгоо мөн гэх үндэстэй байна.

Монголын ард түмний ой санамж, үндэсний ухамсар нь түүхийн өгсөж уруудах их нугачаат замд улс үндэсний бутрал, доройтол, манжийн ноёрхол зэрэг хатуу ширүүн сорилыг туулж гарсан “хатуужиж хатаагдсан” ухамсар болно.

Тухайлбал Монгол хүний амьдралын хэв маяг, ертөнцийг үзэхүй (бурхан шашин, марксизм-ленинизм, интернационализм гэх мэтээр) хэдэнтэй хугарч нугарсан, манжийн ноёрхлын болон хэлмэгдүүлэлтийн жилүүдэд Чингис богдын удам угсааны үндэсний лидерүүд, ноёд дээдэс, үндэсний сэхээтнийг хомроглон устгасан, хэлмэгдүүлсэн зэрэг нь Монголын үндэсний ой санамжид учирсан (тохиосон), нөхөшгүй гарз, хохирол байв. Учир нь сэхээтэн (Чингисийн удмын ноёд бол засаглагчид, төр, цэргийн зүтгэлтэн нар байсан тул удам дамжсан сэхээтэн гэх үндэстэй) нар оюуны соёл, үндэсний тусгаар тогтнол, эх оронч үзэл, ой санамжийг тээгчид, хууль цаазыг бүтээгчид, төр, цэргийг засагчид, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэгчид байдаг.

Чингис богдын удам угсааг хүйс тэмтрэх, үндэсний сэхээтнийг хомроглон устгахын жинхэнэ эзэд нь харийнхан байсан бөгөөд далд цаад санаа зорилго нь Монголчуудын үндэсний ухамсар, бахархал, эв нэгдлийн үзэл санаа, тусгаар оршин тогтнох, хөгжин дэвжих хүсэл эрмэлзэл, чадавхийг нухчин дарах, үгүй ядахдаа л сулруулах хэрэг байжээ.

Үндэсний ой санамж нь тухайн улс,

үндэстний ухамсар, сэтгэлгээний онцлог, өвөрмөцөд суурилдгийг бид дахин онцолж байна. Дотоод, гадаадын эрдэмтэн мэргэд (Гумиловынхон, Перс, Хятад, Оросын болон Өрнө дорнын нэртэй бусад судлаачид гэсэн утгаар)-ийн өв санд монгол хүний сэтгэлгээ, ухамсрын сайн, мууг нь ч тэмдэглэн үлдээсэн нь цөөнгүй.

Шигтгээ. Дундад зууны үеийн монголчуудын тухай тусгайлан нэлээд дэлгэрэнгүй дурдсан нь Плато Карпинийн “Монголчуудын түүх” хэмээх зохиол юм. Тэнд: “Бидний ярьж байсан хүмүүс буюу Татарууд, лам санваартан ч, хар хүн ч ялгаагүй дэлхийн бусад газрын хүмүүсээс илүү гэмээр өөр өөрийн эзэндээ үнэнч, тэд нараа хүндлэн биширдэг бөгөөд тэднээс буцан урвах нь бараг үгүй. Тэдний хооронд аман хэрүүл үгүй хэзээ ч зодолддоггүй ажээ. Хоорондоо дайсагнах, зодолдох, нэг нэгнээ алах, эсвэл шархдуулна гэж үгүй. Дээрэмчин ба хулгайч байхгүй учраас үнэт эдлэл байгаа гэр ба тэрэгний хаалга үүд нь хэзээ ч цоожгүй, онгорхой байна. Хэрэв айлын мал нь алга болвол олж харсан хэн ч байсан тэр газраа орхин эсвэл томилогдсон тусгай хүмүүс дээр олсон малыг аваачин тэндээс эзэд нь алдсан малаа сураглаж олж авах боломжтой ажээ. Бие биенээ хүндэлж найрсаг байх ба ... нэг нэгэндээ атаархах зан байхгүй, тэдний хооронд түүхийн маргаан бараг байхгүй. Бие биеэ жигшиж, зэвүүцэхгүй, харин ч ядарч байгаа нэгэндээ тусалж, чада ядахаараа дэмжинэ⁹. Иймэрхүү утга агуулгатай ишлэлүүдийг XII ба XIII зууны үеийн монголчуудын тухай бичсэн гадаадынхны ном зохиол, замын тэмдэглэлүүдээс олныг үзэж болно. Мэдээж алс холоос мэдэхгүй газар, танихгүй хүмүүстэй уулзсан аянчин, гийчид, монголчуудыг өөлж, муулж бичсэн зүйл бас байлгүй яахав. Гэвч ерөнхийдөө тэр үеийн монгол хүний зан, чанарыг ихэвчлэн сайнаар үнэлсэн байдаг.

Монгол хүний тухай гадаадынхны ойлголт XVIII ба XIX зуун хийгээд ялангуяа XX зууны үед нилээд өөрчлөгдсөн, ерөнхийдөө мөхөж, сөнөж байгаа үндэстний төлөөлөгчид, ядуу зүүдүү амьдралтай бөгөөд нэн бүдүүлэг, соёлгүй, бас иргэншээгүй гэж үзэх нь даваймгайлах болсон байдаг.

⁹ Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. 50 дахь талд.

Бараг хоёр зуугаад жил манж гүрний зах хязгаар нутаг байсан Монголчууд, ялангуяа их говиос арагшаа орших ар ба ойрод Монгол хийгээд ар халхууд XX зууны эхэн болж ирэхэд тэр цагийн дэлхий нийтийн хөгжлөөс мэдэгдэм, хоцрогдож, ядуу зүдүү амьдрал, аж ахуйтай болсон нь үнэнтэй. Энэ талаар хамгийн тодорхой өгүүлсэн судалгааны бүтээлүүдийн нэг болох ЗХУ-ын эрдэмтэн, академич И.Майскийн "Орчин үеийн монгол" бүтээлийг үзэхэд тодорхой. Зохиолч өөрийн бүтээлд XIX зууны эцэс, XX зууны тэргүүн хагаст монгол хүний бие бялдар, зан төрх, ёс суртахууныг нягтлан судалжээ. Тэнд бичсэн нь "Монголчууд ... зан төрх нэгдэж, ... залхуурах, зүгээр суух хоёр дээр нь Монгол хүн ажил хийх дургүй, ... Хэрэв та монгол хүнтэй баасан гарагт тэмээн хөсөг хөдөлгөхөөр тохиролцсон бол тэр хөсгийг миний нөхөр нямд юм уу ирэх даваа гарагт л авч ирнэ гэж маш итгэлтэй найдаж болно. Та ... хожигдлоо гэвэл ... яарах юу байх вэ?, жилд өдөр мундсан биш, яарвал даарнаа хө ... гэнэ."⁹

Монгол хүн "халуун цустай", хувирамтгай, цочмог түргэн зантай, эрх дураараа бас "залхуу", аминчхан гэх мэтээр бичсэн, дурдсан ч бий. Гэхдээ л тал нутгийн эрэлхэг, дайчин, эрэмгий нүүдэлчдийг ухамсар, зан авирын сайн сайхан нь давамгайлж, өөд нь татаж хүн төрөлхтөн хэмээх цэцгийн мандлын нэгэн сор нь болгосоор иржээ. Монгол хүний ухамсар, үндэсний ой санамж ийнхүү хэдэнтээ "хугарах нугарах" эрсдэлтэй тулгарсан ч үндэсний хэмээх онцгой шинж чанар нь өвөрмөцөө гээлгүй зах зээлийн нийгэмтэй золгов. Монголчуудын ухамсар сэтгэлгээний эдгээр онцлогийг хураангуйгаар илэрхийлбэл:

- Монгол хүний "унасан газар, угаасан усан"-даа татагдах, хайрлан хамгаалах, сүсэглэн бишрэх өвөрмөц ухамсар сэтгэлгээ;

- Монгол хүний эрх чөлөөг эрхэмлэгч сэтгэлгээ. Уудам хээр нутагтаа өвсний сор, усны тунгалгийг даган эрх дураараа нүүдэллэгч Монгол хүн бусдын боол болсноос баатрын ёсоор үхсэн нь дээр гэж сэтгэдэг нэгэн ажгуу (хөдөөгийн Пэрлээ абугай);
- Монгол хүний эе эвээ хичээгч сэтгэлгээ. Алангуа эхийн домог, "Цувж явсан барнаас цуглаж суусан шаазгай дээр";
- Монгол хүний бие сэтгэлгээний зориг, тэвчээр, тэсвэр хатуужил, дасан зохицох чадвар. Төв Азийн өндөрлөг, чулуурхаг хөрс, эрс тэс хатуу ширүүн уур амьсгал Монгол хүний эрэмгий дайчин чанар, зүйрлэшгүй эр зориг, тэсвэр хатуужлыг нөхцөлдүүлсэн гэх үндэстэй;
- Монгол хүний эцэг дээдэс, төр, хууль цааз, сахилга дэг журмыг эрхэмлэн сахин, хүндлэн дээдлэх ухамсар сэтгэлгээ, зан заншил;
- Монгол хүний зовж зүдэрсэн нэгэндээ туслах, дэмжих элгэмсэг, энэрэнгүй сэтгэлгээ;
- Монгол хүний чин шударга зан чанар;
- Зарим эрдэмтэн судлаачид (О.Пүрэв, Р.Содномцэрэн гэх мэт) Монгол хүний эрдэнэт мал сүргээ (5 хошуу малаа) хайрлан хамгаалах, өсгөн үржүүлэх, ашиглах арга ухааныг бусад улс үндэстнийхээс илүү өвөрмөц, онцлог бүр заримдаа "хүмүүнчлэн хайрлах"-тай зүйрлэн

⁹ Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. 50 дахь талд.

тэмдэглэсэн нь бий¹⁰.

Монгол хүний эдгээр болон бусад эрхэм нандин зан чанар, ухамсар сэтгэлгээний үнэт зүйлс нь Монголын гал голомт, Монгол Улс хэмээх туурга тусгаар өрх айл түүхийн өгсөж уруудах их нугачаат замын хатуу ширүүн сорилтыг туулж ашид мөнх оршихуйн оюуны дархлаа нь болж иржээ. Тэгэхлээр ухамсар, сэтгэлгээний эрхэм чанарууд нь улс үндэстний оршин тогтнох, хөгжин дэвжихийнх нь оюуны амьд хэлхээс, аргамж холбоог бүрдүүлдэг байна.

Үндэсний ой санамж илрэх хэлбэрүүд:

- Монгол төрийн ой санамж буюу “Төрийн хар хайрцагны бодлого” (төрийн бодлого үйл ажиллагаанд хэлбэрлэлтгүй сахих үеэс үед залгамжлуулах бичигдээгүй хууль, төр, түүний албан тушаалтны бодлого үйл ажиллагааны үндсэн чиг шугам, баримтлах зарчим нь);
- Төр, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг сахин хамгаалах, бэхжүүлэх хүсэл эрмэлзэл, санаа зориг, үйл ажиллагаа;
- Монгол монголоороо үлдэх чин хүсэл зориг, бодлого, үйл ажиллагаа. (соёл, иргэншил, ахуйн өвөрмөц онцлог дахин давтагдашгүйг хадгалах, хамгаалах, дэлгэрүүлэх, хөгжүүлэх хүсэл зориг, бодлого, үйл ажиллагаа);
- Монгол хүн түүний удмын сангийн

аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг эрхэмлэх, сахин хамгаалах бодлого, үйл ажиллагаа;

- Монгол хэмээх нэр төр, олон улсын нэр хүнд, байр суурийг өргөх, бэхжүүлэх чин хүсэл эрмэлзэл, бодлого, үйл ажиллагаа;
- Газар нутаг, хил хязгаарынхаа халдашгүй дархан байдал, үзэсгэлэнт тогтолцоо, унаган дүр төрх, баялгийг хамгаалах, бэхжүүлэх, бүх нийтийн үйл хэрэг, улс үндэстний хөгжил дэвшилд зориулах бодлого, үйл ажиллагаа зэрэг болно.

Үндэсний ой санамж хадгалагдах, хэрэгжих орчин:

- Монгол Улсын төр, түүний байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагаа
- Иргэн, иргэний нийгэм, түүний байгууллага, нийгмийн үндэс болсон өрх, гэр бүлийн орчин.

Төрийн бодлого нь улс орны нийт иргэн (хүн ам)-ий дийлэнхийн язгуур ашиг сонирхол, хүсэл эрмэлзлийг агуулж ард түмнийхээ санаа бодлыг илэрхийлж байдаг. Төр нь байнга, тогтмол үйл ажиллагаа явуулдаг институт учраас бодлого, үйл ажиллагаа нь уламжлал, залгамж чанар, дэг ёс (төр ёс), үнэт зүйлс, үндэсний үзэл санаа (үзэл баримтлалд) суурилж байдаг.

Монгол Улсын төрийн бодлогын үнэт зүйлс:

1. Эв нэгдлийн үзэл санаа. (Алангуа эхийн домог)

Чингис Богд:

¹⁰ О.Пүрэв (Sc.D), профессор; Р.Содномцэрэн (Ph.D). Монгол эх оронч үзэл амин чанарыг боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах, үнэлэх асуудал: Өнөөгийн нийгмийн хөгжилд хүний оюун санааны хүчин зүйлийн гүйцэтгэх үүрэг.УБ., 2017 он. 49-59 дэх талд.

“Бие бөх болбоос ганцыг яльюу
Эе бөх болбоос олныг яльюу”

Жувейни:

Чингис хаан хөвгүүд, дүү нартаа ямагт эв найртай байж, бие биедээ тус дэм өгч, эв эеэ бэхжүүлэхийг чармайх хэрэгтэй гэж үргэлж, захиж сурган, яавал эвтэй байж болдог үлгэр жишээг таниулдаг байлаа. Сургаал, үлгэр домог (жишээ нь, Алангуа эхийн домог Н.Ж) ярьж... “Та нар багцалсан сум мэт байх ёстой...Ганц хоёроороо бол амархан хугарах сум, ийм олон болбол хэнд ч дийлдэхгүй... Тийм учраас та нар бие биеэ дэмжин эв найрамдалтай байх юм бол дайсан хэдий хүчирхэг ч гэсэн та нарыг ялж дийлэхгүй...” гэх мэтээр сургадаг байсныг “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” хэмээх бүтээлдээ тэмдэглэн үлдээжээ.

Төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл баримтлалын нэгэн үндэслэгч Францын философич Ш.Луй Монтесьеке 1748 онд “Хуулийн амин сүнс”-дээ Монголчуудыг “эвсэг” хэмээн бичжээ¹¹.

2. Тусгаар тогтнолын үзэл санаа

Монгол Улсын тусгаар тогтнол, монголын ард түмэн, төрийн үнэт зүйлсийн охь манлай дээжис нь мөн. Бид төр, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын үнэ цэн ач холбогдлыг сайн мэднэ. Энэ бол Монголын ард түмэн, төр засаг гадны хэний ч дарамт, шахалгүйгээр дотоод, гадаад бодлогоо тодорхойлж хэрэгжүүлэх үндэсний хийгээд олон улсын эрх зүйгээр

¹¹ Ш.Л.Монтесьеко.Хуулийн амин сүн.Тэргүүн дэвтэр.Монсудар.УБ.,2008он.313 дахь тал.

баталгаажсан эрх дарх билээ. Тусгаар тогтнолын эрх ашигт нийцүүлэн төрийн хэрэгт зүтгэхийн учрыг Богд Чингис хаан:

“Алд бие мину алжааваас алжаатугай

Ахуй төр мину бүү алдартугай

Бүтэн бие мину зовбоос зовтугай

Бүрэн улс мину бүү самартугай” хэмээн сургажээ¹².

3. Хууль дээдлэх ёс

Б.Чимид:

Хууль дээдлэх ёсон засаг төр барих урлаг, хүн зон амар жимэр амьдрахуйн арга юм. “Чингис хааны од гялалзаж тэр хүмүүс тушаал, зарлигийг дагах болсноор хатуу тогтоосон засаг ёсын (хууль ёсны Н.Ж) тусламжаар тэрээр хүмүүсийг удирдан захирах болов” гэснийг санахад илүүдэхгүй. Чингисийн билиг сургаалд “хатуу чанд, яв цав байдалтай бол хамаг улс бат бэх болой”¹³.

4. Шударга ёс

Академич С.Нарангэрэл: Ёс суртахууны нандин чанарын тэргүүн зэрэгт шударга ёс тавигдсаар ирсэн. Түүнийг хоёр дугаар зэрэгт тавибал яах бол?

Шударга бус явдал газар авна. Хэн шударга бусыг бусдаас ичгүүр сонжуургүйгээр үйлдэнэ. Тэр нийгэм

¹² Д.Лүндээжанцангийн энэхүү номонд байгаа “Тусгаар тогтнол-улс, үндэстний үнэт зүйлсийн охь дээжис мөн” өгүүлэгийг үзнэ үү. Номын 171-195 дахь талд.

¹³ Эрэнджен Хара-Диван. Чингис хаан түүний үлдээсэн өв. УБ.,2003.Монсудар.15 дахь тал. Б.Чимэд. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс.УБ.,2006.150 дахь талд.

төрд тэргүүлэх байр суурийг эзэлбэл улс гүрэн ямар болдог билээ.

Эрээ цээргүй нь хойморт заларч, чадалтай нь хатавчинд суудаг... "Шударга ёсыг Монгол гэрийн тоонотой адилтгаж болно. Тооногүй гэр Монгол гэр болж чадахгүйтэй адил аливаа хүнд авъяас мэдлэг байгаад ч шулуун шударга, ариун явахгүй бол хүний мөс чанараа алдана. Шударга ёс алдагдвал улс орон ч өөдлөн дэвжихгүй. Чингис хаан шударга удирдлага бүхий засаг төрийг цогцлоосон. Энэ тухай алдарт аялагч Марко Поло "Чингис хааны засаглал шулуун шударга, хүн арддаа энэрэнгүйг үзсэн бусад орны хүн ард түүнтэй өөрсдөө ирж нийлэн нэгдсээр байв" гэсэн гярхай ажиглалт хийжээ¹⁴.

5. Холч, голч шинж чанар буюу "Их малгайн бараа харах ёс"

Энэ нь улс үндэснийхээ язгуур эрх ашигт нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйлийг тунгаан бодож, хийг гаргаж бясалгасан "үүдэн бий болсон (болох Н.Ж) асуудлыг (үр дагаврыг Н.Ж) даамай эргэцүүлэн сэтгэж, давхар ухамсарлан бодож алсыг харсан төрийн холч (тогтвортой), голч бодлого (оновттой Н.Ж), бодлого шийдвэр гаргах" арга ухаан юм¹⁵.

Энэ бүхнээс үзэхэд иргэн нь нийгэм, төр засаг, гэр бүлдээ хүлээсэн үүрэгтээ үнэнч байх, өөрөөр хэлбэл төр нь төр шиг байж улс үндэснийхээ нийтлэг эрх

ашгийг эрхэмлэн ард олныхоо сэтгэлийг таньж өршөөл нигүүлсэнгүй хандах нь үндэснийхээ ой санамжаа хадгалагдах нэн чухал нөхцөл болой.

Д.Сүхбаатар "Ардын эрхт хэмжээт цаазат засаг байгууламж нь дээдэс хэмээн доодсыг учиргүйгээр эзэрхэн дарлах ба доодос нь мөн түүний эрх сүрд дарагдаж, зовон зүдрэх зэргийн эзэрхэг ёсыг халж, ард олонд эрх чөлөө олгон амгалан тохинуулахын учир болой"¹⁶.

Иргэн нь нийгэм, төр, ард түмний өмнө хүлээсэн **үүрэг, хариуцлага** гүнээ ухамсарласан байх, тэр нь аливаа үйлдэл, үйл ажиллагааныхан дотоод сэдэл нь болох нь нийгэм оршин тогтнох, хөгжин боловсрох чухал нөхцөл нь болдог ажгуу. Академич С.Нарангэрэл "Үүрэг (Тэрбээр ёс суртахууны үүргийг журамт үүрэг хэмээжээ.) бол аливаа хүмүүний хийх ёстой үйлдэл мөн. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, эх эцгээ энэрч асрах, хөдөлмөрлөх, хууль, дэг журам биелүүлэх, татвар төлөх, эх орон, байгаль орчноо хамгаалах гэх зэрэг үйлдлийг зохих ёсоор хэрэгжүүлэхэд үүргийн агуулга оршино" гэж тодорхойлжээ¹⁷.

Тэгвэл иргэний хариуцлага нь тухайн хүмүүн нийгэм, төр, түмэн олныхоо өмнө хүлээсэн үүргээ чин шударгаар биелүүлсний (эс биелүүлсний) төлөө сэтгэл санаа (оюуны), эд материалын хувьд авах таашаал, урамшуулал, нийгэм, төр, бусад иргэдээс хүртэх үнэлэмж (магтаал, сайшаал, шан

¹⁴ С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир. УБ., 2014 он. 31 дэх тал.

¹⁵ А.Хишигдаваа. ШУА. Философи, социологи эрхийн хүрээлэн. Монгол төрийн бодлогын үнэт зүйлсийн уламжлал, хэрэгжилт. Философи эрх зүйн судлал. XXII боть. 225-232 дахь тал.

¹⁶ Философи эрх зүйн судлал. XXII боть. 229 дэх тал. Дам ишлэв.

¹⁷ С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир. УБ., 2014 он. 49 дэх тал.

харамж, ял зэмлэл гэх мэт)-ийг багтаадаг. Өөрөөр хэлбэл хариуцлага нь хууль тогтоомж (Жишээ нь, төрийн алба хаагч-иргэн хуулиар зарлиг, тушаал, дүрэм журмаар зохицуулагдсан үүргээ биелүүлсэн /эс биелүүлсний/) -ий нь бодит үр дүн /өр төлөөс/ нь гэх үндэстэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулинд (Арван долдугаар зүйл) иргэний үүргийг:

1. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

- 1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
 - 2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
 - 3/ хуулиар ногдуулсан албан татвар төлөх;
 - 4/ эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.
2. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэж тодорхойлжээ.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПРОБАЦИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА: ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ

Р.ОЮУНБАДАМ

(Шихихутуг их сургуулийн клиник сургалтын
төвийн эрхлэгч, гавьяат хуульч, Ph.D)

**Пробацийг /тэнсэн/ онолын түвшинд
авч үзэх нь:**

Үгийн тайлбар: провац, probation- тэнсэн хянан харгалзах гэсэн агуулгыг илэрхийлдэг тул сэдэвт аль алианаар авч бичсэн болно.

Провац нь дараах 2 агуулгыг өөртөө багтаана. Шүүгдэгчид хорих ял биечлэн эдлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл тэнсэн хянан харгалзах шийдвэр гаргана. Хоригдлыг хорих ял эдлэж байгаад хугацаанаас өмнө тэнсэн суллагдаж хянан харгалзана. Тэнсэн суллах шийдвэрийг шүүх гаргахдаа тэнсэнгийн хугацаа хянан харгалзах тухай зааж өгнө. Тэнсэх агуулгын эцсийн зорилго “Нийгэмшүүлэх” агуулгатай байна. Ийм учраас тэнссэн хүнд тавих хяналт болон тэдэнд үзүүлэх дэмжлэг туслалцааг үр дүнтэй хэрэгжүүлэх арга, аргачлалыг хэд хэдэн хувилбараар боловсруулж боломжит хувилбарыг санал болгох явдал юм. Провац бол биеэ даасан институт болохынхоо хувьд хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх системд багтах боломжийг тодорхойлдог. Хорих ял эдлээд суллагдаж байгаа хүмүүс “нийгэм намайг хүлээж авахгүй” гэсэн айдастай байдаг ба бодит байдал дээр нийгэмд хэвийн ажиллаж амьдрахад нь төрийн бодлого гэхээсээ илүүтэй олон нийтийн чиг хандлага түлхүү

үйлчилж, гадуурхагдах, ажилд орж чадахгүй байх, ахин гэмт хэрэг үйлдэх зэрэг сөрөг үр дагаврыг амсаж, давтан гэмт хэрэг үйлдэх зам руу орох талтай. Эрүүгийн ялын бодлогын талаас авч үзвэл хоригдлыг хүмүүжүүлэх, нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй. Хоригдол дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь нийгмийн нөхцөлөөс гадна нийгэмшүүлэх ажлыг буруу томьёолж хэрэглэж байгаатай шууд холбоотой байна.¹

Тэнсэх пробаци гэдгийн хуулийн нэгэн чухал агуулга нь: хорих ял эдлүүлэхгүйгээр нийгэмшүүлэх гэм бурууг нь ойлгуулах зорилготой. Тэнсэн нь өөрөө юу юм бэ? Гэдгийг онолын талаас тайлбарлавал:

Тэнсэх гэдэг нь хэзээ ч аль ч улсын Эрүүгийн хуульд заасан ялын төрөл болон хуульчлагдаж байгаагүй. Тэнсэгдсэн этгээд шүүхээс оногдуулсан ялыг биечлэн эдэлдэггүй учраас ял биш. Түүнчлэн тэнсэгдсэн хүний эрхийн байдалд ямар нэг хязгаарлалт байдаггүй тул ял эдэлж байгаа онцгой хэлбэр ч болж чадахгүй. Тухайн этгээд шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдвэл түүний шийтгүүлсэн ялыг сэргээж биечлэн эдлүүлэх журамтай учраас эрүүгийн

¹ ХЗҮХ Судалгааны тайлангийн эмхэтгэл. УБ., 2012. т. 660

хариуцлагаас чөлөөлөгдөх гэж хараахан үзэхгүй.

Ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй нь тодорхой тохиолдолд шүүгдэгчид оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүйгээр ялын нийгэмшүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгод хүрэх ял биечлэн эдлүүлэх болзлыг төр, олон нийтийн хяналт, ажиглалт, олон нийтийн нөлөөллөөр төрийн өмнөөс зэмлэн шийтгэснээр солих явдал хангалттай болох нь тогтоогдсон нөхцөлд суурилан тулгуурласан байдаг.

Тэнсэх арга хэмжээг зөвхөн хорих ял оногдуулсан этгээдэд хуульд заасан нөхцөл, бүрдсэн тохиолдолд хэрэглэдэг. Иймд хорихоос өөр төрлийн ялыг тэнсэх гэдэг ойлголт байж болохгүй. Уг этгээдийн шийтгүүлж байгаа зүйлд заасан хэрэг нь ангиллын хувьд зөвхөн хөнгөн гэмт хэрэг байх ёстой. Хэрэв уг этгээдийн шийтгүүлж байгаа хэрэг нь хүнд бол оногдуулсан хорих ялыг тэнсэж болохгүй.

Эрүүгийн эрх зүйн онол практикт ял тэнсэх инстстутыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх онцгой хэлбэр, таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулах үйл ажиллагаа, эрүүгийн ял, ялыг биелүүлэх онцгой журам, шүүхийн тогтоолыг биелүүлэхгүй болгож байгаа явдал гэх зэрэг олон үзэл баримтлалаар тайлбарлаж ирсэн байна.²

Тэнсэх гэдэг бол шүүгдэгчид холбогдох зүйл ангиар хорих ял оногдуулаад түүнийгээ биечлэн эдлүүлэхийг түдгэлзүүлж хянан харгалзах тусгай

хугацаа тогтоохыг хэлдэг. Хянан харгалзах хугацаа 1 жилээс доошгүй 5 жилээс дээшгүй байна. Ял тэнсэгдсэн этгээд шийтгэх тогтоол уншсан үеэс суллагдах бөгөөд хянан харгалзах хугацаанд зөвхөн ял шийтгэгдсэнд тооцогдож байхаас өөрөөр иргэний ямар нэгэн эрх нь хязгаарлагддаггүй. Гагцхүү нэмэгдэл ял оногдуулсныг дангаар нь эдлүүлж болно. Тэнсэх институтийг шинээр авч үзсэнээр гэмт хэрэг үйлдэж гэм буруу нь шүүхээр тогтоогдсон этгээдийг гэмт зан үйлд суралцах, мэргэшсэн гэмт хэрэгтэн бий болгохоос урьдчилан сэргийлж буй хэрэг бөгөөд тухайн хүний гэм буруугий нь ухамсарлуулах, учруулсан хохирлыг барагдуулах зэргээр үр нөлөөтэй ялын тогтолцоог бий болгоход чиглэнэ.

Хянан харгалзах хугацаа нь ял тэнсэхийн үндсэн агуулга юм. Ийм учраас шүүхийн шийтгэх тогтоолоор заасан хянан харгалзах хугацаанд тэнсэгдсэн этгээд шинээр гэмт хэрэг үйлдвэл шинэ хэрэгт нь шийтгэсэн ял дээр урьд шийтгээд тэнссэн хорих ялыг нэмж эдлүүлдэг. Хэрэв тэнсэгдсэн этгээд хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг үйлдээгүй бол тогтоолыг биелүүлээгүй бөгөөд хугацаа дууссан өдрөөс эхлэн уг этгээд ял шийтгэлгүйд тооцогддог.³ **Ял тэнсэх үндсэн болзол нь:** Үйлдсэн хэрэг нь хөнгөн байх, Учруулсан хохирлыг нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан байхаас гадна үйлдсэн хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэргийн байдал хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөлүүдтэй байх ёстой.

² Нарангэрэл С. Монгол улсын эрүүгийн эрх зүй. УБ., 1999.т.326

³ Совд Г. Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002.т.97

Тэнсэн гэдэг бол Монгол улсын эрүүгийн хуульд уламжлагдан ирсэн төдийгүй ардчилал хөгжсөн бусад улс орнуудын Эрүүгийн хуульд нийтлэг үйлчилдэг эрүүгийн хариуцлагын нэг өвөрмөц арга бөгөөд үр нөлөө бүхий албадлагын арга хэмжээ юм.⁴

Дэлхий дахинд хорих газраас суллагдсан хүмүүст чиглэсэн төрийн бодлого үндсэн хоёр хэлбэртэй байдаг. Үүнд: **/нийгмийн хяналтын хэлбэр/ Social control of criminals нөгөө нь /нийгэмд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хэлбэр/ Rehabilitation of criminals**

Энэхүү хоёр хэлбэр нь тухайн улсын нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотой хандлагаар илэрхийлэгддэг. Жишээ нь: **Нийгмийн хяналт нь** хорих газраас суллагдсан хүмүүсийг “засаршгүй хүмүүс” гэж үзээд “давтан, рецидив гэмт хэрэгтэн” хэмээн нэрлэж, түүнтэй хийх тэмцлийг чангатгадаг. Хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь хууль тогтоомжийг үл ойшоож, засарч хүмүүжихийг хүсэхгүй байгааг илтгэн харуулах шалгуур гэж үзэж суллагдсан хүмүүст нийгмийн зүгээс тавих хяналт илүү чанга байх ёстой бөгөөд ингэснээр тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэж үздэг. Нөгөө хандлага нь либериаал баримжаатай барууны гэгдэх орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн сэтгэл зүйг эмчлэх, нийгмийн туслалцаа үзүүлэх ажлын онолын үндэслэл 1970-аад оноос хөгжсөн. Энэ нь гэмт хэрэгтнийг нийгэмд дахин

засаж, хүмүүжүүлж болдог, ингэхийн тулд шоронгоос суллагдсан хүмүүст туслалцаа дэмжлэг хэрэгтэй гэсэн хүмүүнлэг үзэлд тулгуурладаг.

Манай улсын 2017 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн *шинэчлэлийн нэг хэсэг болох тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх нь*: хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг өөрөөр ухамсарлуулах, хохирол нөхөн төлүүлэх, цаашид гэмт хэргийн карьер ахиж, мэргэшсэн гэмт хэрэгтэн бий болгохгүйн тулд авч байгаа шинэлэг арга хэмжээ гэж үзсэн.

Шүүхээс хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх нь дараах онцлогтой. 2002 оны Эрүүгийн хуульд “Тэнсэх” арга хэмжээг хүндэвтэр хэрэгт ял оногдуулсны дараа хэрэглэдэг байсан бол шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тусгай ангид таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан бүх төрлийн гэмт хэрэгт шүүхээс ял оногдуулахгүйгээр тэнсэх шийдвэрийг шүүх гаргаж болох юм. Гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах шаардлагагүй гэж үзэн шүүхээс тэнсэхдээ: Гэмт хэрэг үйлдсэн хүн буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, хор уршгийг арилгасан байх. Эсхүл гэм буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн байх гэсэн хоёр шинжийн аль нэгийг заавал харгалзан үзнэ.

Шүүхээс тэнсэн харгалзах шийтгэл оногдуулсан хүнийг хянан харгалзах

⁴ Совд Г. Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002.т.96

эрх зүйн орчины өнөөгийн байдал

2017 оны шинэчлэн найруулсан ШШГ-тухай хууль болон цагдаагийн албаны тухай шинэ хуулиуд батлагдан гарахаас өмнө цагдаагийн албаны тухай хуучин хуульд Шүүхээс хорих ял нь тэнссэн болон хорих ангиас хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдэд хяналт тавих чиг үүрэг цагдаагийн байгууллагад байсан ба цагдаагийн байгууллага дараах хяналт тавьж байв.⁵ Үүнд: Шүүхийн шийдвэрийн хувийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тэнсэгдсэн этгээдэд хувийн хэрэг нээж, тэнссэн этгээдийг дуудан ирүүлж тэдэнд тэдгээрийн эрх, үүрэг шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг тачилцуулна. Тэднийг зан байдал, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар сар тутам хяналтын хувийн хэрэгт тэмдэглэл хийнэ. Хянан харгалзах хугацаа дуусмагц энэ тухай шүүх болон тэнсэгдсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ гэх мэт гэтэл 2017.02.09-нд Цагдаагийн албаны шинэчлэн найруулсан хуулийн 10 дугаар зүйлд: цагдаагийн байгууллагын чиг үүргээс дээрх хяналт хасагдсан байна. ШШГ-тухай шинэ хуулийн 186 дугаар зүйлд: Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон шийдвэрийг биелүүлэх тухай заалт шинээр орж ирсэн байна. Энэ нь шинэ эрүүгийн хуулийн үзэл баримтлалтай шууд нөхцөлдөж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7-

д заасны дагуу дараах байдлаар хуульд тусгалаа олжээ. ШШГЕГ-ын харьяа ШШГГ-ын ХӨТЯ эдлүүлэх албанд хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон бүх чиг үүргийг хэрэгжүүлэх талаар ШШГ-тухай хуулийн 268 дугаар зүйлийн: 268.1.4; 5; 7 дахь хэсэгт: хорих ял эдлүүлэхийг хойшлуулсан, тэнсэн сулласан ялганд хяналт тавих ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах; хуульд заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, этгээдүүдийн ялыг эдлүүлэх хүмүүжлийн нөлөө үзүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үүргийг ШШГБ гүйцэтгэж байхаар тус тус заасан байна. Судалгаанаас үзвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд: гэмт хэрэг үйлдэж, таван жилээс дээш хугацаагаар хорих ял эдэлсэн хүн хорих ял эдэлж суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтооно гэж заасан боловч энэ хяналт хэрхэн биелэгдэж байгаа нь тодорхой биш байна.

Үүнтэй холбогдуулан **дараах дүгнэлт хийж байна.** Хэдийгээр цагдаагийн албаны тухай шинэ хуулиас тэнссэн болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнд хяналт тавих чиг үүрэг нь хасагдсан байгаа боловч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг нь

⁵ Нарангэрэл С. Монгол улсын эрүүгийн эрх зүй. УБ., 1999.т.330

хэвээрээ байгааг хаана хаанаас анхааран үзэж дээрх хоёр байгууллагын ажлын уялдаа холбоогоо сайжруулж тодорхой болгох хэрэгтэй байна. Тэгэхгүй бол хяналт тогтоох ёстой чухал ажил үндсэндээ орхигдсон байдалтай байгаа нь хамгийн их тулгамдсан асуудал болсоор байна гэдгийг судлаачийн хувьд зориуд тэмдэглэж байна.

Энэ асуудлыг ХЗДХЯ нэн даруй анхааралдаа авч шийдвэрлэх нь чухал байна. ХӨТЯ эдлүүлэх алба тэнссэн этгээдийн хууль заасан үндэслэлээр хүн бүрт хүрч ажиллан орон тоо, техник хэрэгсэл эрх зүйн зохицуулалт зэрэг нь илт дутмаг байгаа нь судалгаанаас харагдаж байна. Гадаадын зарим орны туршлагаар гэрийн хорионд байлгах, электрон гавны тусламжтайгаар хянадаг зэргийг өөрийн онцлогтоо тохируулан авч хэрэгжүүлэх боломж байж болно. Гадаадын зарим орнууд электрон гавны тусламжтайгаар хянах нь хамгийн түгээмэл бараг улс орон болгон энэ аргыг хэрэглэдэг байна. Ийм учраас Манай улс Эрүүгийн шинэ хуульдаа хуульчилж өгсөн зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэн эхлэх цаг үетэй хамтадган тэнссэнтэй этгээдэд хяналт тавих үүрэг зорилго адил төстэй байгаа тул эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломж харагдаж байна. Гагцхүү хууль тогтоох байгууллага ХЗДХЯ-наас Цагдаагийн байгууллага ШШГБ-ын хууль тогтоомжид болон өөрчлөлт оруулах бусад эрх зүйн актаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна.

Судалгаанаас харвал хорих ангиас суллагдаж байгаа хүмүүсийн 70 орчим

хувь нь давтан гэмт хэрэг үйлдэж, тэднээс үйлдэх гэмт явдлын нийгмийн хор аюул улам бүр өсөн нэмэгдэж байна. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлдэг “захиргааны хяналт” гэсэн арга хэмжээ нь давтан гэмт явдлаас урьдчилан сэргийлэх оновчтой шийдэл, нөлөөлөл болж чадахгүй байна. Нөгөөтэйгүүр хувь хүнийхээ үүднээс нийгэмд “гэмт хэрэгтэн” хэмээн гадуурхагдах, хэвийн ажиллаж, амьдрах эрх нь зөрчигдөх зэрэг байдлууд ч гарч байна.

Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмд хүлээн авах, ажлын байраар хангах, тусламж дэмжлэг үзүүлэх, амьдрах орчин нөхцөл сайн бүрдээгүй байна. Энэ нь төрийн байгууллагын үйл ажиллагааны болон эрх зүйн зохицуулалт учир дутагдалтай байгаатай холбоотой юм.

Хорих байгууллагад ял эдэлж байгаа хүмүүсээс суллагдаж гарсны дараа учрах бэрхшээлүүдийн талаар асуухад ялтнуудын ихэнх нь “хорихоос суллагдахад учрах бэрхшээл ихтэй байдаг, нэн ялангуяа тэднийг амьдралд хүлээн авах хэн нэгэнтэй үл ойлголцох байдал бий болно, ажил олдохгүй байх” гэсэн айдастай байхад, иргэд эсрэгээр шоронгоос суллагдсан хүмүүсийн талаар сөрөг төсөөлөл, хандлагатай байдаг нь ажиглагдлаа.⁶

Хорих байгууллагаас суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх, нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан ажилд зуучлах ажлыг нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг захиргааны болон төрийн бус байгууллагуудын

хамтын идэвх санаачилгаар идэвхжүүлж ажиллах ёстой.

Тэнсэж, хянан харгалзах арга хэмжээ нь гадаадын ихэнх орны гэмт хэргийн тухай хуульд тэнссэн суллагдсан үйл ажиллагааг хянах гэх parole, probation зэргээр нэрлэдэг. Энэ нь хэлбэрийн хувьд тодорхой хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэхгүй, засарч хүмүүжих талаар амлалт өгч, хууль сахиулах байгууллагын хяналтад байх хэлбэрээр хэрэгжинэ. Үүнтэй холбоотойгоор хорих байгууллагад хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх нэгж, алба байгуулагдана гэж үзээд Эрүүгийн шинэчлэн найруулсан хуульд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тухай заахдаа гадаадын орнуудын parole, probation-ийг хэрхэн хэрэглэдгийг судлаад өөрийн орны онцлогийг харгалзан хууль хэрэгжүүлэх эрх зүйн орчноо сайтар судлаагүй, эрх зүйн орчныг бүрдүүлээгүйгээр хуульчилсан

нь практикт маш хүндрэл учирч байгааг судалгаа харуулж байна. Тэнссэн хүнд хяналт тавих үүрэг цагдаагийн байгууллагын чиг үүргээс хасагдсан гэдгийг би нэгэнтээ дурдсан гэвч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд: гэмт хэрэг үйлдэж 5 жилээс дээш хугацаагаар хорих ял эдлээд хугацаанаас өмнө суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх нийгмийн хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтоох үүрэг цагдаагийн байгууллагын үүрэг юм. Тэнссэн харгалзах болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг цагдаагийн байгууллага давхар хянаж байгаа нь эрүүгийн хариуцлагын тэнсэх институтын агуулга зорилго алдагдаж байна гэж үзэх бүрэн үндэстэй байна.

ШШГБ-ын 2018 оны 3 дугаар улирлын байдлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгдсэн мэдээнээс харвал:

Хорих ял эдэлж байгаа хоригдлын тоо	Тэнсэнтэй хүний тоо	Хорихоос өөр төрлийн ялтай хүний тоо				Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээтэй хүний тоо	Эрүүгийн ялтай нийт хүн 13141 үүнээс 25% 4/1
		Торгох	Нийтэд тустай ажил хийлгэх	Эрх хасах	Дүн		
3415 Үүнээс эмэгтэй 185 өсвөр насны 68	Нийт 1404 хүн. Насанд хүрсэн хүн- 1392. Өсвөр насны хүн- 12	5595	1422	1180	8147	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ шүүхээс ирсэн-290 Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ шүүхээс ирсэн-143 Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ шүүхээс ирсэн- 1096	

МОНГОЛЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПРОБАЦИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

Ялын бодлогын шинэчлэлийн нэг хэсэг болох тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх нь: хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг өөрөөр нь ухамсарлуулах, хохирол нөхөн төлүүлэх, цаашид мэргэшсэн гэмт хэрэгтэн бий болгохгүйн тулд авч байгаа шинэлэг арга хэмжээ юм. Эрүүгийн ялын бодлого бодьтой болохыг бид 2018 оны эхний есөн сарын дүн мэдээллээс харлаа. **Энэ арга хэмжээг ШШГБ дангаараа хариуцаж байна. Тэр дундаа ХӨТЯ эдлүүлэх алба дангаараа хариуцаж байна.** Тэгвэл хуульд нэмэлт өөрчлөлт шинэчлэл хийгдсэнтэй уялдаж хэрэгжүүлэх биелүүлэх ажиллагаанд ямар шинэчлэл өөрчлөлт бий болов. Өөрөөр хэлбэл хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин хэр зэрэг бүрдэв гэдэг нь тулгамдсан асуудал болсоор байна.

Учир нь өнөөгийн байдлаар 1 шийдвэр гүйцэтгэгчид нийслэлд 621 орон нутагт 227 хэрэг ноогдож байна. Бодит амьдрал дээр тэнсэх болон эрүүгийн хариуцлагын бусад албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд нэг дүүргийн хэмжээнд 1 шийдвэр гүйцэтгэгч хяналт тавин ажиллаж байгаа нь материал тус бүрт хүрч ажиллах боломжгүй байна. 2017 оноос өмнө цагдаагийн байгууллага тэнссэн этгээдүүдэд хяналт тавьж ажилладаг байхдаа хороо болгонд хэсгийн байцаагч 1, эргүүлийн цагдаа 1, олон нийтийн цагдаа гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй хяналт тавьж 2-3 хэлтэс хамтран нэг дүүргийн хэмжээнд

дунджаар 56-98 цагдаагийн албан хаагч хяналт тавьдаг байсан байна.

Дүүргийн хэмжээнд ажиллаж буй **шийдвэр гүйцэтгэгч** зөвхөн тэнссэнг хянахгүй цаана нь торгох, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах ялтай этгээдүүдэд хяналт тавьж ялын биелэлтийг ханган ажиллаж байгааг дурдах нь зүйтэй. Энэ байдал нэг гүйцэтгэгч бүгдийг жигд сайн биелүүлдэг гэж үзэхэд үзэх үндэслэл муутай байна. Дээр дурдсан зүйлийг эргэн нэг харья.

Нэг талаасаа цагдаагийн байгууллагын чиг үүргээс хуулиараа хасагдсан тул ШШГБ хийх ёстой гэж үзээд орхисон. Нөгөө талдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээтэй этгээдүүд цагдаагийн хяналтад зайлшгүй байх шаардлага байгаад байна.

Тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүд хэрэг зөрчилд холбогдож байгаа эсэхийг Цагдаагийн байгууллагаас улирал тутамд мэдээлэл авдаг байна. Хяналтад байгаа этгээдүүдийн гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан талаар мэдээллийг Цагдаагийн байгууллага ASAP санд оруулсан гэдэг. ШШГБ бүтэц зохион байгуулалтыг шинэчилж ял эдлүүлэх ажиллагаа, тэнсэгдсэн этгээдэд хяналт тавих ажиллагааг хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэгчийг тус тус дагнан ажиллуулахаар зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллага тухайн бүс нутаг дэвсгэртээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд

суллагдсан ялтныг дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх засарч хүмүүжихэд хяналт тавих бүрэн боломжтой тул хорих ялаас тэнсэн суллагдсан болон тэнсэж албадлагын арга хэмжээ авагдсан нийт этгээдүүдэд Цагдаагийн байгууллага давхар хяналт тавих талаар ШШГБ-ын хамтын ажиллагаанд өөрчлөлт оруулсан эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна.

Гадаадын зарим орны эрүүгийн эрх зүйн онол сургаал нь ялаас чөлөөлөн институтэд тэнсэх арга хэмжээг багтааж авч үздэг. Тэнсэж, хянан харгалзах арга хэмжээ нь гадаадын ихэнх орны гэмт хэргийн тухай хуульд parole, probation гэх зэргээр нэрлэдэг хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр хянан харгалздаг албадлагын арга хэмжээ болдог. Энэ нь хэлбэрийн хувьд тодорхой хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэхгүй, засарч хүмүүжих талаар амлалт өгч, хууль сахиулах байгууллагын хяналтад байх хэлбэрээр хэрэгжүүлдэг байна. Пробацийг гадаад орнуудын эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэрэгт ял оногдуулахаар хуульд тэнссэн болон эрүүгийн эрх зүйн бусад арга хэмжээг өргөн хэрэглэдэг. Гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомжийн жишиг, харьцуулсан судалгаанаас үзэхэд: ялаас чөлөөлөх үндэслэл нь: **нэг талаас** ялыг биечлэн эдлэхээс чөлөөлөх **нөгөө талаас** ялыг эдэлж буй үед эдлээгүй үлдсэн ялаас хэсэгчлэн буюу бүрэн чөлөөлөх шаардлагаар нөхцөлдсөн байдаг. Ихэнхи орны хувьд ялаас чөлөөлөхийг ихэнхдээ тухайн гэмт хэргийн хууль зүйн үр дагавар хохирол нөхөгдсөн,

иргэд, нийгэм, байгууллагад учирч болох аюултай байдал арилсан буюу сөрөг нөлөөлөл багассан зэрэг зэрэг байдал бий болсонтой холбоотойгоор хүнд биш ялимгүй жижиг хэргүүдэд хамааруулж ойлгоно. Түүнчлэн хугацаатай хорих ял эдэлж буй ялтан эдлэх ёстой ялын ихэнхийг буюу зохих хувийг эдэлж дууссан нөхцөлд засрал, төлөвшил, ялын зорилго, үр нөлөөг харгалзан эдлээгүй ялаас чөлөөлж болох нөхцөлийг хуульчлан зохицуулж ирсэн нь харьцангуй нийтлэг ажээ. Хүнд биш /жижиг-хөнгөн/ гэмт хэргийн хувьд: Хийсэн хэрэг, үйлдлээ гэмшиж, сайн дураараа хэргээ илчилж ирсэн тохиолдолд, Хохирол төлбөрөө газар дээр нь буюу сайн дураараа төлж барагдуулан гэмт хэргийн үр дагаврыг арилгасан тохиолдолд, Хохирогчтой эвлэрэх, тохирох замаар бүх хохирол, хор аюулыг арилгасан тохиолдолд тус тус ял оноохгүйгээр ялаас чөлөөлөх боломж нөхцөлийг эрүүгийн хуулиудад зохицуулж өгчээ. Ялаас чөлөөлөх институцуудад:

1. Хорих /ялыг тэнсэх/
2. Ялын хугацаанаас өмнө тэнсэн суллах /пробаци/ зэрэг хэлбэрүүд хамаарч байна.⁶

Ял тэнсэх хэлбэр нь гадаадын олон оронд тухайлбал Англи, АНУ, Франц, ОХУ-д зэрэг улсад өргөн хэрэглэгдэж ирсэн энэрэнгүй агуулга бүхий эрүүгийн арга хэмжээ юм.

Тэнсэнгдсэн этгээд шүүхээс өгсөн үүрэг, даалгаврыг ягштал биелүүлж зан

⁶ С.Жанцан Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол .УБ., 2009. т.434

байдлаараа засарч хүмүүжсэнээ харуулж чадсан. Дахин гэмт хэрэг үйлдэхгүй болсоноо харуулж чадвал түүнийг тэнсэн харгалзах хугацааг дуусгаж бүрэн чөлөөлж ялгүйд тооцно. Үүнийг дараах орнуудаар харьцуулан үзвэл:

Гадаадын зарим орнууд хууль тогтоомжийнхоо дагуу ял оноох шийдвэр гаргах үеэс эхлээд ялаас чөлөөлөх ялыг тэнсэх нөхцөл байдлыг хянах шийдвэрийг цогцоор хэрэгжүүлдэг.

Герман улс - Германы эрүүгийн хууль тогтоомжоор ял оноох шийдвэр гаргах үеэс эхлээд ялаас чөлөөлөх, ялыг тэнсэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдлыг хянан шийдвэрлэхтэй холбогдсон цогц үйл ажиллагаа явагддаг.⁷ Судалгаанаас харвал ХБНГУлс, бусад орноос ялгаатай дараах хоёр онцлог зохицуулалт байдаг. Үүнд: **тэнсэнгийн бие даасан тусгай хуультай байдаг. Шүүгчийн туслах нь хяналт тавьдаг туршлага байна.**

Франц улс - Ял тэнсэх асуудлыг Францын эрүүгийн хуулиар тусгайлан зохицуулсан байдаг. Ялыг биелүүлэхийг хойшлуулах нь дараах төрөлтэй. Үүнд: Ердийн журмаар хойшлуулах, Ялтныг хянан харгалзах дэглэмд байлгах замаар хойшлуулах, Нийгмийн эрх ашгийн үүднээс заавал хөдөлмөрлөх үүргийг ялтанд хүлээлгэж хойшлуулах⁸ Ял тэнсэх нь: Эрүүгийн гэмт хэрэг болон хэрэг үйлдсэн тохиолдолд, Гэмт

хэрэг үйлдсэн хүнд хэрэглэнэ⁹, Ял биелүүлэхийг хойшлуулсан тохиолдолд тэнсэх нь 5 жилээс дээшгүй хугацаатай хорих ялыг оногдуулсан үед боломжтой, Хянан харгалзах хугацаа тогтооно. Тэнссэнг харгалзах нь дараах байдлаар хуульчилсан байдаг.

Засрах найдлагатай буюу итгэл найдварыг хангаж чадсан байх шаардлага, шалгуурыг ойлгомжтой нээлттэй тогтоосон байхаас гадна хоригдох үеийн хагас эрх чөлөөт байдлын хүрээ, хязгаарыг зөвшөөрөгдсөн зан үйлийн хэмжээг тогтоож өгөх

Австр улсад- Ялаас хугацааны өмнө тэнсэх нь бүх хугацаагаар эсхүл хэсэгчлэн тэнсэх гэсэн хоёр төрөлтэй. 2 жилээс ихгүй хугацаатай хорих ял болон торгох ял шийтгэгдсэн этгээдэд хэрэглэнэ. Ялаас тэнсэн суллахдаа шүүх шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэргийн хор аюулын хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, хувийн байдал зэргийг харгалзан 1-3 жил хүртэл хугацааны хянан харгалзах хугацаа тогтооно

Япон улсад- Ял шийтгэсэн шүүхийн тогтоолыг хойшлуулах институц үйлчилдэг. Хэд хэдэн үндсэн нөхцөл хамаарагдана. Шүүгдэгч хөдөлмөрт албадан татан оруулахаар 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих 500000 иенээр торгох ялаар шийтгэгдсэн байх. Шүүгдэгч өмнө нь албадан хөдөлмөрт татан оруулахаар хорих ялаар болон түүнээс хүнд ял шийтгэгдсэн ял эдлэсний дараа 5 жилийн турш дахин гэмт хэрэг үйлдэж шийтгэгдэж байгаагүй байх

⁷ Баярсайхан Д.Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012.т.195

⁸ Баярсайхан Д.Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012.т.259

⁹ Баярсайхан Д.Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012.т.259

ёстой. Хянан харгалзах хугацаа 1-5 жил байна. Арга хэмжээний биелэлтийг цагдаагийн байцаагч хэрэгжүүлнэ.

Швейцарийн улсад- 18 сараас илүүгүй хугацаатай хорих ял болон нэмэгдэл ял шийтгүүлсэн ялтныг тэнсэн суллах үндэслэл, журмыг тогтоодог. Шүүх тухайн шүүгдэгчийн хувийн байдалд үнэлэлт өгч шинээр гэмт хэрэг үйлдэхгүй, олон нийтээс тусгаарлан хорих шаардлагагүй гэсэн дүгнэлтэд хүрсэн хохирлоо нөхөн төлсөн тохиолдолд ялаас тэнсэн суллах шийдвэр гаргана. Шүүх тэнсэгдсэн ялтанд тодорхой үүрэг хүлээлгэж, хяналт тавих асуудлыг шийдвэрлэнэ

БНХАУ-д- Шүүх тэнсэн суллахдаа шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэргийн хор аюул, хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэрэгтээ гэмшиж байгаа байдал зэргийг харгалзана. Тэнсэн суллах тохиолдолд хянан харгалзах хугацаа, ялын хэмжээ, гэмт хэргийн хүнд хөнгөнөөс хамаарч өөр өөр байна. Шүүгдэгчид богино хугацаанд баривчлах ял оногдуулж байгаа бол 2 сараас нэг жилийн хооронд хянан харгалзах хугацааг тогтооно. Тодорхой хугацаатай хорих ял шийтгэгдсэн гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгчийг тэнсэхдээ 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хянан харгалзах хугацаа тогтооно

АНУ-д-Хянан харгалзах ял нь хүнд биш хэргийн хувьд хорих ялыг заавал эдлүүлэх шаардлагагүй үед хууль тогтоомжид заасан журмын дагуу цагдаагийн болон засаг, захиргааны тусгай албаны түшмэдийн хяналтан дор тодорхой үүрэг, шаардлагыг биелүүлэх болзол тавьж түүнийг албадан хангуулах

замаар эдлүүлдэг. Пробаци хэрэглэхэд урьд өмнө ял шийтгэгдэж байгаагүй, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг барагдуулсан, үйлдсэн гэмт хэргийн ял нь 10 жилээс багагүй байх гэсэн нэмэгдэл шаардлага тавигддаг. Нью-Йорк мужийн хуулиар бол пробацийг А-1 ангиллын гэмт хэргээс бусад бүх гэмт хэрэг үйлдсэн хүнд хэрэглэж болно. Хугацаа нь бүх тохиолдолд 1-5 жил байна. АНУ-д сүүлийн үед тэнсэгдсэн хүмүүсийн зан төлөв, үйл хөдөлгөөнийг электрон гавын тусламжтайгаар хянах болсноор гэрийн хорионд байлгадаг байсныг өөрчилсөн.

ОХУ-д- Хорих ял оногдуулахдаа ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж үзвэл хянан харгалзах хугацаа тогтоож шүүгдэгчийг тэнсэн суллах шийдвэр гаргана. Засарч хүмүүжихэд тустай тодорхой үүрэг хүлээлгэнэ. Шүүх ялтныг хугацаанаас нь өмнө ял эдлэхээс чөлөөлнө. Ялтан ялынхаа тодорхой хувийг эдэлсэн байхаас гадна засарч хүмүүжсэнээ нотолсон байх ёстой.

Швед улсад- Шведийн эрүүгийн хуулиар гэмт хэрэгт оногдуулах ял нь: Торгууль, Шоронд хорих, Мөн пробацийг нийгэмшүүлэх гэсэн утгаар нь хэрэгжүүлдэг төдийгүй ялын төрөлдөө багтаадаг онцгой зохицуулалттай болох нь ажиглагдлаа. Онцлог нь пробацийг торгууль төлөх, нийгэмд тустай үнэ төлбөргүй хөдөлмөр эрхлүүлэх, богино хугацаатай хорих ялтай хослуулан хэрэглэдэг. 1-3 жилийн хугацаагаар хэрэгжүүлнэ. Пробацийг хэрэгжүүлэгч субъектыг орон нутгийн шоронгийн удирдлага томилж үүрэгт ажилд нь оруулдаг. Хяналт хэрэгжүүлэгч ажилтан

нь тэнсэн суллагдсан этгээдийн зан төлөв, үйл хөдөлгөөнд хяналт тавихдаа түүнд өөрийн ажил, гэрийн хаягийг үнэн зөв мэдээлэх, байнгын харилцаатай байх, гэмт хэргийн хохирлыг төлөх, хууль ёс, дэг журмыг чанд сахих үүрэг даалгавар өгч биеллийг хянадаг. Тэнсэгдсэн хүмүүсийн зан байдалд цагдаа хяналт тавина. Пробацийн үед хяналтыг хяналтын зөвлөл, харгалзагч түүнийг хэрэгжүүлдэг. Швед улсад бусад улсаас ялгарах нэг онцлог бол Тэнсэх шийтгэх, Пробаци /нийгэмшүүлэх/, Тусгайлсан асрамжинд өгөх зэрэг ялын төрлөөс нь харвал тэнссэн харгалзахыг ялын төрөлдөө оруулсан байдаг.

Иймд: дараах дүгнэлт хийж байна. Тэнссэн хүнийг хянахад энэ албыг ХӨТЯ эдлүүлэх албанаас тусад нь биеэ даасан алба болгож шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт нь харьяалах нь хамгийн зөв шийдэл гэж үзэж байна.

Тэнссэн этгээдээ дэмжлэг туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин бий болгох шаардлагатай юм. Үүний тулд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах журмаар хяналт тавих үйл ажиллагааг тодорхой болгож пробацийн үр нөлөөг сайжруулах нь ач холбогдолтой гэж үзэж үзлээ.

Тэнсэн харгалзах албаны чиг үүргийг зөвхөн хяналт тавихаар хязгаарлахгүй пробацийн бүрэн агуулгаар хэрэгжүүлэхийн тулд нийгэмшүүлэх талаар гадаадын бусад улс орнуудад хэрэгжиж буй туршлагаас судлан

үзэж тэнссэн этгээдүүдийн дунд тэднийг нийгэмдээ дасан зохицох цаашид гэмт хэргийн замаар биш өөрийнхөө ухамсарт зан үйл шударга хөдөлмөрөөрөө амьдралаа авч явах дадал олгох сургалт зохион байгуулах хэрэгтэй байна.

АНУ-д Хянан харгалзах ял нь хүнд биш хэргийн хувьд хорих ялыг заавал эдлүүлэх шаардлагагүй үед хууль тогтоомжид заасан журмын дагуу цагдаагийн болон засаг, захиргааны тусгай албаны түшмэдийн хяналтан дор тодорхой үүрэг, шаардлагыг биелүүлдэг туршлагыг анхааран үзэж өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх.

Цагдаагийн байгууллагын ажилтан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан сум дүүргийн хорооны нийгмийн ажилтан гэсэн гурван байгууллагын ажилтны хуулиар хүлээлгэсэн чиг үүргийн хүрээнд тэнссэн болон хорих ангиас суллагдсан хүмүүст чиглэгдсэн ажил хангалтгүй хэрэгжиж байгаа тул цаашид хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, прокурорын ажил дүгнэх үзүүлэлтийг ч өөрчлөх

Тэнсэх буюу пробацийн тусгайлсан алба нэгж хэлтэс байгуулж, энэ ажлыг хариуцуулах замаар шийдвэрлэж болохоор байна. ШШГЕГ-ын харьяа ШШГГ-ын харьяанд Засгийн газраас ХЗДХЯ-наас Пробацийн алба байгуулах талаар шийдвэр гаргуулах санаачилга гаргаж цаг хугацаа алдалгүй шийдвэрлүүлэх зэрэг арга хэмжээ авууштай байна.

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ "МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ"-ИЙН ҮНЭТ ЗҮЙЛ БОЛОХ НЬ

Э.АНХБАЯР

(Шихихутуг их сургуулийн төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн докторант)

Шүүхийн тогтолцоо, шүүгчийн ёс зүй, шударга байдалд итгэх олон нийтийн итгэл нь орчин үеийн ардчилсан нийгмийн амин сүнс болж байна.¹

Манай улсад 1993 оны Шүүхийн тухай хуульд шүүгчийн ёс зүйн үндсэн зарчмыг тодорхойлсон байдаг. Улмаар 2002.07.04-ний өдрийн шүүхийн тухай хуулиар 1993 оны шүүхийн тухай хуулийг хүчингүй болгож, 2002 оны шинэчилсэн найруулсан "Шүүхийн тухай"² хуульд зааснаар шүүгчдийн зөвлөлөөс баталсан Шүүгчийн ёс зүйн дүрэм үйлчилж эхэлсэн бол 2013 оны шүүхийн тухай багц хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн одоогийн үйлчилж байгаа шүүгчийн ёс зүйн дүрмийг баталсан байна.

Монгол улсад шүүгчийн ёс зүйн чиглэлээр судалгаа хийж байгаа судлаачид шүүгчийн ёс зүйн асуудлыг хөндөхдөө шүүгчийн ёс зүйн дүрэм дээр тулгуурлаж судалгаа хийгээд байгаа нь ажиглагддаг. Тухайлбал:

Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн В.Жавхлангийн "МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ" илтгэлд: "...шүүгчийн ёс зүйн дүрэмд дараах зүйлийг нэмэлт

оруулж сайжруулахыг шүүгч нарт санал болгох, ..., шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т заасан шүүгчид хориглосон заалтуудыг бүрэн тусгах, ..., замаар шинэчлэн сайжруулах зэрэг амин чухал асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй." гэжээ

Хууль зүйн доктор О.Мөнхсайхан "МОНГОЛ УЛС ДАХЬ ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ПРОЦЕДУР АМЖИЛТ БА СОРИЛТ" илтгэлд: шүүгчийн ёс зүйн дүрмийн агуулгыг олон улсын стандартын дагуу шинэчлэх, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээс шүүгчид холбогдох заалтуудыг нэмж тусгах." гэжээ

Хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал "МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ ШИЙДВЭР. ҮР НӨЛӨӨ, ДҮН ШИНЖИЛГЭЭ" илтгэлдээ: Монгол улсад эдүгээ хэрэгжиж буй шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх загварыг тодорхой болгох." гэжээ. Тухайн судлаачид Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм³ болон одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалт дээр судалгаа хийж, шүүгчийн ёс зүйн асуудлыг зохицуулсан эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь зүйтэй гэсэн нийтлэг дүгнэлтэд хүрсэн байна.

¹ "Шүүгчийн ёс зүйн талаарх бангалорын зарчим, түүний тайлбар", 2002

² <https://www.legalinfo.mn/law/details/90>

³ <http://www.judge.mn/home/content?id=18>

Мөн Монгол улсын шүүгчийн ёс зүйн дүрмийн хувьд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн зарим зохицуулалт давхацсан шинжтэй байдаг. Манай судлаачдын хувьд энэ давхцал дээр акцент өгөөд энэ давхцлыг арилгах талаар л санал зөвлөмж гаргаад байдаг.

Шүүгчийн ёс зүйн асуудлыг зохицуулсан эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь зүйтэй ч эдгээр тулгамдсан асуудлын хажуугаар орхигдоод байгаа зүйл байдаг.

Шүүгчийн ёс зүйн дүрэм нь цорын ганц арга зам мөн үү?

Хүн болох багаасаа

Хүлэг болох унаганаасаа

Шүүгч ёс зүйтэй байхад:

- Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм боловсронгуй байх
- Шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэдэг шүүхийн ёс зүйн хороо⁴ хараат бус байх
- Эрх зүйн хөтөлбөрөөр оюутан сургадаг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, багш сайн байх нь чухал ч бид нэг зүйлийг анхаарахгүй, ач холбогдол өгөхгүй орхигдуулаад байна.

Тэр нь юу бэ?

Монгол улсад шийдэж чадахгүй байгаа маш олон асуудлын цаана ёс зүйн асуудал сүүдэр мэт нуугдаж байна.

Шүүхийн шударга бус шийдвэр, авилга, хээл хахууль гэх мэт эдгээр асуудал анхаарал татах хэмжээнд байна. Энэ

⁴ <http://www.judcouncil.mn/ysdarga.html>

нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг буруулж шүүх эрх мэдлийн тогтолцоог ганхуулахад хүрээд байна.

Шүүх эрх мэдлийг хэн хэрэгжүүлдэг вэ?

Шүүх эрх мэдлийг **шүүгч** хэрэгжүүлдэг гэж дуу нэгтэйгээр хэлэх байх.

Шүүгч гэж хэн бэ?

Шүүгч гэж Монгол улсын үндсэн хуулийн 51.3 дугаар зүйлд: “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; **хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно**”. гэсэн бол

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд⁵ “Шүүгч гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг хэлнэ” гэж хуульчилсан байна.

2013 оны хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19.6-р зүйлд “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үндсэн дээр хуульч нь өмгөөлөгч, прокурор, **шүүгчээр ажиллана**” гэсэн эрх зүйн зохицуулалт хийж өгсөн байна.

Эндээс дүгнэвэл: Шүүх эрх мэдлийг 25 насанд хүрсэн, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй⁶

⁵ www.legalinfo.mn/law/details/8660

⁶ <https://www.legalinfo.mn/law/details/8661>

хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэн байх нь харагдаж байна.

Шүүгчийн монгол улсын иргэн, хүн талаас нь авч үзвэл түүний ёс зүйн асуудал дээр дүгнэлт хийхэд хялбар болно.

Учир нь ёс зүйн асуудал бол хувь хүний ёс суртахуун, зан үйлийн зүй тогтолтой холбогдож тайлбарлагддаг. “Ёс зүйн шийдвэр гаргахад ихэнхдээ хувь хүний зан үйлийн зүй тогтлыг удирдлага болгодог.”⁷ Иймээс шүүгчийн ёс зүйн асуудлыг судлахын тулд “Ёс зүйн” ойлголт⁸-ыг эхлээд судлах ёстой.

Гэтэл бид **шүүгчийн гаргаж болох зөрчлийн жагсаалтыг гаргаж өгөөд**, гаргасан хойно нь хэрхэн шийдвэрлэх вэ?

Мөн хэдэн онд хэдэн зөрчил гарсан байна. Хэдийг сахилгын хэрэг үүсгэж шийдсэн талаарх судалгааг л хийсээр л байна. Тухайлбал:

Шүүхийн ёс зүйн хороо 2014 оноос 2017 онд 807 гомдол хүлээж аваад 42 шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэсэн гэх мэт судалгааг хийж, үүн дээрээ дүгнэлт хийж, Монгол улсын шүүгчийн ёс зүйн дүрмийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмтэй харьцуулан эдгээрийг боловсронгуй болгох тухай судалж яриад удаж байна.

⁷ Бүрэнжаргал.Т., “Нийгмийн ажлын мэргэжлийн ёс зүй”, УБ., 2017 он., 29 дэх тал

⁸ Дуламсүрэн.Ш “Хуульчийн мэргэжлийн ёс зүй”, УБ., 2007 он., 42 дахь тал

Судлаачдын хувьд үүнийг буруутгах гэсэнгүй харин судлагдаагүй орхигдоод байгаа асуудлыг хөндөхийг оролдож, шүүгч ёс зүйтэй байхад нөлөөлөх хүчин зүйлийг өөр өнцгөөс нь харахыг зорилоо.

Хүн хүнтэйгээ харьцах харилцааны асуудал бол ёс зүйн асуудал байдаг. Тэгвэл Хуульч хүн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа хүнтэй харилцах харилцааны асуудал нь хуульчийн ёс зүйн асуудал болно.

“Хүний үйл ажиллагаа хэчнээн янзаар илэрнэ, төчнөөн тоогоор тэдгээр нь сайн үйл, муу явдал хоёрын нэг байдаг”⁹ Жишээ нь шүүгч хүн мэргэжлийн ур чадвар сайн байлаа ч зан авираар бэртэгчин байх тохиолдол байдаг. Энэ нь шүүгч мэргэжлийн алдаа гаргахаас гадна ёс зүйн талаар алдаа гаргаж байгааг харуулж байна.

Ёс зүй гэж юу вэ?

Хүний ёс зүйн төлөвшил бага балчир байхаасаа олж авч тэр гэр бүл, анги хамт олон гэх мэт нийгэмтэй харилцахад илрэлээ олдог гэж үзэх судлаачид байхад зарим судлаачдын хувьд ёс зүй бол бүр төрмөл гэж үзэх тохиолдол байдаг. Тухайлбал: Академич, Монгол улсын Их сургуулийн Эмерит профессор С.Нарангэрэл **“Монгол улс дахь хуульчдын ёс зүйн тулгамдсан асуудал”** сэдэвт 2019 оны 4 сарын 26-ны эрдэм шинжилгээний хуралд илтгэсэн **“Монгол хуульчид ёс зүйгээ сахидаг уу?”** илтгэлдээ: “..... ёс зүйн өгөгдөл нь хүнд төрмөл байдаг.” гээд хуульч хүн

⁹ Гомбосүрэн.Ц., “Ёс зүй”, УБ., 2008 он., 109 дэх тал

мэргэжлийн ёс зүйн өгөгдлөө хамгийн дээд үнэт зүйл гэж үздэг болсон цагт хуульчийн нэр хүнд өснө. Хуульчийн ёс зүй үүсмэл бус төрмөл гэдгийг анхаар гээд “Хүн эхээс төрөхдөө **ёс суртахууны** өгөгдөлтэй төрдөг” гэжээ.

Тэгвэл ёс суртахуун гэж: “Этика буюу ёс зүйн нь шинжлэх ухааны мэдлэгийн бие даасан салбар, мораль буюу **ёс суртахуун** нь энэхүү салбарын судлагдахуун болжээ”¹⁰

“Эрх зүй, ёс суртахуун нь хоёул нийгмийн харилцааг зохицуулах нийтлэг шинжтэй боловч эрх зүй нь төрөөс тогтоогдон, түүний хүч нөлөөгөөр дамжин хэрэгжиж, зөрчигдөх тохиолдолд төрийн албадлага хэрэглэн хуулийн цээрлэл үзүүлж байдаг. Тэгвэл ёс суртахуун нь олон нийтээс тогтоогдон, түүний хүч нөлөөгөөр дамжин хэрэгжиж, зөрчигдөх тохиолдолд төрийн албадлагыг бус, харин олон нийтийн цээрлэл үзүүлдэг”¹¹

“Хүн анх адгуусны аймгаас тасран салж, одоогийн төрхийг олж эхэлсэн тэр цагаас зан суртахууны анхны үр хөврөл бий болсон.”¹² бол ёс зүйг судлах нь хүн ёсны ухааныг судалдаг.

“Хүн ёс” гэж бусдыг хайрлахыг хэлнэ. Бусдыг үнэхээр хайрладаг хүн нийгэмд хүлээсэн үүргээ биелүүлж чадна”¹³

¹⁰ Дуламсүрэн.Ш., “Хуульчийн мэргэжлийн ёс зүй”, УБ., 9 дэх тал

¹¹ Сэнгэдорж.Т., “Хуульчийн ёс зүй”, УБ., 1998 он 9 дэх тал

¹² Дуламсүрэн.Ш., “Хуульчийн мэргэжлийн ёс зүй”, УБ., 12 дахь тал

¹³ Гомбосүрэн., “Ёс зүй” , УБ., 2008 он., 25 дахь тал

Шүүгчийн ёс зүйн асуудлыг хөндөхөд

- Монгол улсын шүүгчийн ёс зүйн дүрэм боловсронгуй болгох нь чухал уу?
- Шүүгчээр ажиллах хүний төрмөл ёс суртахууны асуудлыг судлах нь зөв үү?

Манай улсад “., хуульчийн шалгалт тухайн хүний ёс зүй, зан байдлыг бүрэн шалгадаггүй бөгөөд мэдлэг, ур чадварыг голлон шалгадаг.”¹⁴

Бусад улсын туршлагаас харвал ямар байдгийг судалбал:

Германд шүүгчийн ёс зүйг хатуу дүрмээр зохицуулахаас аль болох зайлсхийдэг. Үүнийгээ төрийн эрх мэдлийн нөгөө хоёр институтын ёс зүйн дүрмийг ашиглан шүүх эрх мэдэлд нөлөөлөх боломжийг олгох магадлалтай гэж үздэг байна.

Японы Токио хот дахь Мэйжи их сургуулийн хууль зүйн сургуулийн эрх зүй судлалын профессор Ясүтомо Моригивагийн судалгаанаас харахад “АНУ-д шүүгчийн ёс зүйг хэм хэмжээгээр зохицуулсан байдаг.

Францын хувьд “цуглуулга” хэмээн нэрлэж болох аргийг сонгон авсан. Цуглуулга гэдэг нь зарчмуудын нийлбэр биш харин шүүгчийн хүлээх ёс зүйн үүргүүдийг хэлж байгаа юм. Үүнийг нь шүүгч бүр уншиж мэдсэн байх шаардлагатай байдаг.

Харин Канадад “going by principle” буюу зарчим мөрдүүлэх аргыг хэрэгжүүлсэн.

¹⁴ “Хууль дээдлэх ёсны баталгаа: хуульчдын өөрөө удирдах ёсны байгууллага” эмхэтгэл., УБ., 2019 он., 98 дахь тал

Канадын шүүхийн зөвлөл нь Канад улсын шүүгчийн ёс зүйн стандартыг голлон хариуцдаг. Канадын шүүхийн зөвлөлөөс “Ёс зүйн зарчмууд” хэмээх баримт бичгийг 1998 онд батлан гаргасан юм байна. Энэхүү зарчмуудад:

Заалт, зарчим болон тайлбарууд нь зөвлөх шинж чанартай. Тэдний зорилго нь мэргэжлийн болон ёс зүйн хүндрэлтэй асуудлуудтай нүүр тулсан шүүгч нарт туслах, мөн шүүгчийн үүрэг ролийг ойлгоход олон нийтэд дэмжлэг үзүүлэх явдал байдаг байна. Шүүгчид хориглосон үйл ажиллагааг жагсаан хэрэглэж болохгүй. Энэ нь шүүгчийн зохисгүй үйл ажиллагааг илэрхийлсэн стандартыг ч тогтоож байгаа хэрэг гэж үздэг.

Канад улсад тухайн зарчим нь заавал дагаж мөрдөх биш харин зөвлөх шинжтэй байдаг юм байна.

Харин манай улсын хувьд: Монгол улсын шүүгчийн ёс зүйн дүрэм¹⁵

- Ялгаварлах үзэл гаргахгүй байх
- Шүүгч нь хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлах, түүнчлэн тийм үйл ажиллагаанд дэмжиж оролцох эсхүл дээрх үйл ажиллагаа явуулдаг байгууллагад гишүүн байхыг хориглоно
- Шүүгч нь өмчийн аливаа төрөл, хэлбэрийг алагчилж болохгүй
- Шүүгч нь байгаль орчинд халтай үйлдэл хийхийг хориглоно
- Зохисгүй байдал гаргахгүй байх
- Шүүгч олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа

шүүх, шүүгчийн нэр хүндэд харшилсан, эсхүл шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дуу, дүрс бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл байршуулахыг хориглоно

- Шүүгч мэдсээр байж олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээнд хэргийн оролцогчидтой харилцахыг хориглоно гэх мэтээр хориглох заалтууд байдаг
- Германы хандлагын хувьд санал зөвлөмж, уншиж судлах материал шалгах асуултуудыг шүүгчид өгсөн байдаг. Жишээ нь:
- шүүгч надад ямар байдлаар хандаасай гэж хүмүүс хүсч байна.
- Шүүх хуралдаанд оролцогчдод би яаж хүндэтгэлтэй хандах вэ? гэх мэт асуултууд байдаг.

Өөрөөр хэлбэл өөрчлөх ёстой ямар муу болохгүй зүйл байна вэ? гэдгээ шүүгч өдөр тутам бодож байх ёстой байдаг.

Эдгээр өөр өөр хандлагууд бүгд өмнө шүүгчийн ёс зүйг хэм хэмжээгээр зохицуулахаас зайлсхийх хандлагатай байна.

Ёс зүйн дүрэм бол хэзээ ч төгс зохицуулалт байж чаддаггүй нь манай орны болон бусад улсын жишээнээс харагдаж байна.

Монгол улсын шүүгчийн ёс зүйн дүрэм¹⁶-ийг янз бүрээр тайлбарлаж, өөрт нь хариуцлага хүлээлгэхээс айсан, хулчгар шүүгч нар мөн дүрэм л зөрчихгүй бол юу ч хийж болох юм байна гэж үздэг шүүгч

¹⁵ <http://www.judge.mn/home/content?id=18>

¹⁶ <http://www.judge.mn/home/content?id=18>

нар манай улсад байгаа учраас бид шүүгчийн ёс зүйн асуудлыг шүүгчийн ёс зүйн дүрмийн боловсронгуй болгох асуудлын хамт цаана нь байгаа **ёс зүй** гэх философи ойлголтыг судлах шаардлага урган гарч байна.

"...Аливаа хүмүүний хамгийн үнэ цэнэт зүйл нь түүний ёс суртахуунд оршдог."¹⁷

Дүгнэлт, зөвлөмж:

- Шүүх эрх мэдлийг "Шүүгч" хэрэгжүүлдэг учраас шүүгч ёс зүйтэй байвал шүүх эрх мэдлийн тогтолцоо бэхжих үндэс болно.
- Монгол улсын шүүгчийн ёс зүйн дүрэм боловсронгуй байлаа ч түүнийг мөрдөх шүүгчийн ёс зүй бол эхээс төрмөл. Иймээс Монгол улсын шүүгчийн ёс зүйн дүрэм, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг боловсронгуй болгохын зэрэгцээ шүүгчээр ажиллах гэж байгаа хүний ёс зүйн асуудалд анхаарал хандуулах

Эрх зүйн хөтөлбөрөөр оюутан сургадаг их дээд сургууль оюутан элсүүлэхдээ **ёс зүйн шалгуурыг тавьдаг** болох /тухайн шалгуурыг цаашид нарийн судалж тодорхой болгох/

Суралцаж байгаа оюутны хувьд та бол "Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх бүхий субъект болно шүү гэдгийг сануулж, ёс зүйтэй байх асуудлыг сургалтын хөтөлбөр, сургалтын орчинд шингэж өгөх.

Хуульчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн шалгалт өгөх гэж байгаа хүнийг шалгахдаа мэргэжлийн ур чадварыг шалгахын зэрэгцээ ёс зүйд нь анхаарах /ёс зүйн шалгуурыг тодорхой болгох/, үүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг зохих хууль тогтоомжид оруулж өгөх нь зүйтэй.

¹⁷ Нарангэрэл.с., "Хуулийн амин сүнс буюу Чингис ухаан, монголчууд" ., УБ., 2018 он., 74 дэх тал

ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Д.ОЮУНЧИМЭГ

(Шихихутуг их сургуулийн төгсөлтийн дараах
сургалтын албаны мэргэжилтэн, хууль зүйн магистр)

Монгол Улсын Үндсэн хуульд анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна гэж заасан нь төрийн үйл хэрэгт иргэдийг оролцуулах мөн тухайн хэрэг маргааныг зөвхөн шүүгчийн байр сууринаас бус өөр өнцгөөс харан шүүхийн шийдвэрт өөрийн дүгнэлтээ тусгах боломжийг бүрдүүлсэн юм.

Монгол улсын хувьд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нь шинэ ойлголт биш. Урьд нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгч оролцуулах, тэд шүүн таслах ажиллагаанд шийдвэр гаргах эрхтэй оролцож байжээ. Энэ тухай БНМАУ-ын Аливаа шүүх таслах газруудыг байгуулах дүрмийн 1.1-т “Хошуудын жинхэнэ ардын шүүн таслах газруудад аливаа хэргийг нэг түшмэл ба ард олноор сонгосон хоёр төлөөлөгчөөр шийтгүүлбэл зохино”¹ гэснээс эхэд ойлгогдоно. 1940 оны Үндсэн хуулийн 50 дугаар зүйлд “Аливаа шүүх таслах газруудаас хэргийг таслахдаа хэрэв хуульд зориуд заасан хэрэг биш бол байнга суух шүүн таслагчаас ардын төлөөлөгчийг оролцуулан гүйцэтгэж байх” гээд 1960 оны Үндсэн хуулийн

64 дүгээр зүйлд “Бүх шатны шүүхэд хэрэг шүүн таслах явдлыг хэрэв хуульд тусгайлан заагаагүй бол ардын төлөөлөгчдийг оролцуулан байнгын шүүгч нар гүйцэтгэнэ”² гэсэн заалтууд нь Монгол улс шүүн таслах ажиллагаанд иргэдийг оролцуулж байсны баталгаа.

Шүүх эрх мэдлийн шинэчлэлийн ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Шүүхийн тухай багц хуулиудыг баталсны нэг нь “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай” юм. Энэ хуулиар шүүх засаглал дахь нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүх хуралдаанд иргэдийн төлөөллийг оролцуулах, тэдний санаа бодлыг тусгах зорилгоор эрх зүйн хэрэг маргааныг анхан шатны журмаар, гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах, түүнтэй холбоотой харилцааг зохицуулсан. Энэ хуулийн зорилгс нь “шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох” бөгөөд гол агуулга нь эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар

¹ Б.Баярсайхан., Монгол улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Хоёрдугаар боть, УБ., 2010. 611 дэх тал

² Б.Баярсайхан., Монгол улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Тавдугаар боть, УБ., 2010. 164 дэх тал

хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд иргэдийн нэг төлөөлөгчийг таслах эрхтэй оролцуулахаар болсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанад оролцуулна” гэсэн байдаг. Тэнд зөвхөн иргэдийн төлөөлөгчийн эрхийг тусгасан бөгөөд үүргийг орхигдуулсан. Ингэхдээ шүүгдэгчийн гэм буруугийн талаар санал бичих, уншиж сонсох эрхтэй байхаар хязгаарласан, тиймээс ч эсрэг тэсрэг санал гаргасан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тусгаагүй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад иргэдийн төлөөлөгчдийг шүүх хуралдаанд оролцогч хэмээн томъёолж³ эрх, үүргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаас нэлээд тодорхой томъёолжээ. Тухайлбал, иргэдийн төлөөлөгч нь шүүх бүрэлдэхүүнээс шүүгчийг татгалзах хүсэлт тавих эрхтэй болохыг хуульчилж өгснөөрөө хэрэг шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих боломжийг нэмэгдүүлсэн.

Тулгамдаж буй асуудлууд:

1. Монгол улсын Үндсэн хуульд хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэж байх журмыг шударга ёсны шаардлагыг хангах гол шалгуур хэмээн үздэг. Гэвч энэ чухал зарчмыг салбар хуулиудад тусгахдаа хэлбэр төдий хандсанаас

Үндсэн хуулийн дээрх зарчим бүрэн утгаараа хэрэгжих боломжгүйд хүрч байна. Энэхүү зарчмыг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд иргэдийн төлөөлөгчдийн ажиллах зарчим, эрх үүрэг зэргийг салбар хуулиудад тодруулж өгөх шаардлагатай

2. Шүүхийн бүх үйл ажиллагаа олон нийтэд ил тод, ойлгомжтой, тэдний санаа бодолд түшиглэсэн байх учиртай ч хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаанд оролцсон иргэдийн төлөөлөгчдийн шүүгдэгч болон зохигчийн гэм буруугийн талаар гаргасан саналыг шүүхийн шийдвэрт хэрхэн тусгах талаар хуульчлагдаагүй учраас тодорхойгүй байна.
3. Холбогдох хуулиудад Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулга, хэлбэрийг тодорхой заагаагүй зөвхөн дүгнэлтийг бичгээр үйлдсэн байх, агуулгын шаардлагад гэм буруугийн талаар тусгасан байхаар оруулжээ. Энэхүү шаардлагыг хангаагүй буюу бүрэн бус хангасан дүгнэлтийг шүүх хэрхэн үнэлэх, засвар оруулахыг шаардах эсэх асуудал нээлттэй үлджээ.⁴
4. Иргэдийн төлөөлөгчийн ажилласан цагийг тооцохдоо шүүх хуралдааны талаар мэдээлэл өгсөн, тангараг өргөсөн, хэргийн материалтай танилцсан, шүүх хуралдаанд оролцсон байхыг шаарддаг билээ. Иргэдийн төлөөлөгчөөр иргэний шүүхэд сонгогдон ажилласан хөлсийг

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 85 дугаар зүйл

⁴ Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог оновчтой бүрдүүлэх нь. Судалгааны тайлангийн эмхэтгэл - 2015. УБ., 2016. 111 дэх тал.

нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, шүүх хуралдаан дууссаны дараа бэлнээр болон бэлэн бусаар олгохоор журамд заасан. Өнөөгийн практикт нэг цагийн хөлс ойролцоогоор 1500 төгрөгөөр үнэлэгдэж байгаа бөгөөд нэг шүүх хуралд оролцоход ойролцоогоор 7-8 цаг шаардагдаж, 10000 төгрөгийн хөлс авдаг. Тэгээд ч бусад зардлыг олгодоггүй байдал нь ажлын үнэлгээ бараг байхгүйтэй адил хөдөө орон нутагт, сум дамжин шүүхэд ирэх иргэдэд ихээхэн чирэгдэл учирдаг.

Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцохын ач холбогдлыг дэлхийн ихэнх улс орнуудад “маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд олон янзын мэдлэг, туршлага бүхий иргэн оролцооноор илүү сайн хянан шийдвэрлэх ажиллагаа явагдахаас гадна иргэн, шүүгч хоёрын эрх мэдлийн хуваарилалтыг сайн хийж өгсөнөөр хамтын шийдвэр гаргах зарчим илүү үр дүнтэй хэрэгжинэ” гэж үздэгийг энд дурьдах нь зүйтэй биз. Тухайлбал:

А. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид гэм буруугийн асуудлаар шийдвэр гаргах чиг үүрэгтэй бөгөөд ингэхдээ хуралдаан даргалагчаар дамжуулан асуулт тавих хэлбэрээр хуралдаанд оролцоно. Хуралдаан даргалагчийн зүгээс асуултыг “хэрэгт хамааралгүй, шаардлаггүй, ач холбогдолгүй” гэж дүгнэснээс бусад тохиолдолд оролцогчид иргэдийн төлөөлөгчийн асуултад хариулах үүрэгтэй.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид дүгнэлт гаргахдаа шүүх хуралдаан даргалагчийн тусгайлан тавьсан бүх асуултад хариулна. Ингэхдээ “тийм”, “үгүй” хэмээж тодорхой хариулсан байна. Гэм буруугийн талаарх дүгнэлтийг иргэдийн төлөөлөгчийн ахлагч-илтгэгч өөрийн гараар бичсэн байх бөгөөд хариултыг асуулт бүрт өгч гарын үсгээ зурна. Иргэдийн төлөөлөгчид гэм буруугийн талаарх дүгнэлтийг тайлбарлах, нэмэлт нотлох баримт шаардах эрхгүй.⁵ Цаазаар авах ял шийтгэх талаарх дүгнэлтэд дийлэнх олохчийн, эсхүл 2/3-ын санал заавалчгүй шаардлагдана. Тэд дүгнэлтээ “иргэдийн төлөөлөгчдийн тасалгаа”-нд бэлтгэнэ. Ингэхдээ хууль болон эрх зүйн ном, бүтээлийг ашиглах боломжтой. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүхийн харьяалан шийдвэрлэх эрүүгийн хэрэг хязгаарлагдмал бөгөөд ердийн шүүхийн адил бүх төрлийн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх эрх хэмжээгүй байдаг. Тус шүүх нь төрийн эсрэг гэмт хэргээс бусад хүнд гэмт хэргүүдийг шүүн шийдвэрлэдэг.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажиллах этгээд дараах нөхцөлийг хангасан байх ёстой.

1. Оролцогчидтой хамааралгүй этгээд байх
2. Эрх зүйн чадвар, чадамжтай байх
3. Эрх зүйн мэдлэгтэй байх⁶

⁵ Gerhard Casper and Hans Zeisel, *The Journal of Legal Studies*

Vol. 1, No. 1 (Jan., 1972), pp. 135-191, Lay Judges in the German Criminal Courts

⁶ Trial by Jury in Germany, Author(s): Burt Estes Howard

Source: *Political Science Quarterly*, Vol. 19, No. 4

Иргэдийн төлөөлөгчийг томилохдоо тухайн муж улсын засаг захиргааны нэгж шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх этгээдийн жагсаалтыг бэлтгэх үүрэгтэй. Тэрхүү жагсаалтыг олон нийтийн хяналт, ил тод байдлыг хангах зорилгоор 7 хоногийн туршид нээлттэй байлгадаг. Сонирхогч этгээд хэн боловч жагсаалтад багтсан этгээдийг шүүхийн шүүхийн иргэдийн төлөөлөгч байхад тохиромжгүй гэж үзэх, гомдол гаргах эрхтэй. Үүний дараа жагсаалт гаргасан муж улсын засаг захиргааны нэгжийн дарга жагсаалт болон гомдлыг тухайн нэгжийх харьяалах тойргийн шүүхэд хүргүүлнэ.

Б. Япон Улс

Япон улсын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, шийдвэр гаргаж буй иргэдийг "Saiban-in" гэж нэрлэх бөгөөд Saiban-in болохын тулд тухайн дүүргийн оршин суугч байна. Тэрбээр заавал бүрэн дунд боловсролтой байх шаардлагагүй, харин ял шийтгэлгүй, бие махбодын болон сэтгэцийн хувьд эрүүл байх ёстой. Нийт бүртгүүлсэн иргэдээс тохиолдлын журмаар сонгож 6 долоо хоногийн өмнө мэдэгдэх хуудсаар шүүх хуралдаанд дуудан ирүүлнэ. Маргааныг хянан шийдвэрлэхэд 6 иргэдийн төлөөлөгч, 3 мэргэжлийн шүүгч оролцох бөгөөд тангарагтны хувьд 20-с дээш насны хүн бүр оролцох боломжтой.⁷

(Dec., 1904), pp. 650-672

Published by: The Academy of Political Science
Stable URL: <http://www.jstor.org/stable/2140326>

⁷ Citizen participation in criminal Trials in Japan: the Saiban-in system and victim participation in Japan, International Journal of Law, Crime and Justice, 2014

Түүнээс гадна Saiban-in шүүх хуралдаанд оролцсон талуудын нууцыг чанд хадгалах үүрэгтэй бөгөөд хэрэв иргэд, байгууллагын нууцыг задруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Шийдвэр гаргахдаа шүүгчтэй хамтран гэм буруутай эсэх талаар дүгнэлт гаргах боловч шүүхийн эцсийн шийдвэрийг шүүгч гаргана.⁸

В. Оросын Холбооны Улс

Шүүх хуралдаан даргалагч дүгнэлт гаргах цаг болсыг мэдэгдсэнээр иргэдийн төлөөлөгчид дүгнэлт гаргахаар тусгай тасалгаанд орно. Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг ахлах төлөөлөгч удирдан явуулна. Иргэдийн төлөөлөгчид тавигдсан асуултад хариулж, санал нэгтэй дүгнэлт гаргахыг эрмэлзэнэ. Ийнхүү санал нэгдээгүй тохиолдолд гар өргөж, илээр санал хурааж ахлах төлөөлөгч хамгийн сүүлд саналаа өгнө. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт нь хоёрдмол утгагүй, нэг мөр ойлгогдохоор байх ёстой бөгөөд тавигдсан асуултад "Тийм, гэм буруутай", "Үгүй, гэм буруугүй" гэх байдлаар хариулна. Тавигдсан асуулт, өгсөн хариулт бүхий дүгнэлтийн төгсгөлд ахлах төлөөлөгч гарын үсэг зурна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг ахлах төлөөлөгч уншиж танилцуулан бөгөөд дүгнэлтийг даргалагч шүүгчид гардуулж хэргийн материалд хавсаргана.⁹

⁸ Act on Criminal Trials with Participation of Saiban-in, Act NO 63 of May 26.

⁹ Barry, Ellen (November 15, 2010). "In Russia, Jury Is Something to Work Around". The New York Times.

Г. Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын тангарагтныг 2 аргаар сонгодог.

1. Тангарагтан болохыг хүссэн иргэдээс тохиолдолын аргаар сонголт хийнэ. Уг жагсаалтад иргэд өөрсдөө бүртгүүлж болохоос гадна сонгогчдын нэрсийн жагсаалт, жолооны үнэмлэхтэй болон ажилгүйдлийн тэтгэмж авдаг иргэдийг шууд оруулж болно.
2. Шүүх болон өмгөөлөгчийн зүгээс тусгай шалгуурын үндсэн дээр нөөцөөс 2 тангарагтанг сонгож хэрэг хянан шийдвэрлэхэд оролцуулдаг.

Тангарагтнаас 6-12 хүнийг сонгож шүүх хуралдаанд оролцуулна. Муж улсын онцлогоос хамаарч тангарагтнуудын шүүх хуралдаанд оролцох хэлбэр янз бүр байна. Нийтлэг гэдэгт дараах ойлголтууд багтана¹⁰.

Үүнд:

- 6 тангарагтан байх ба шаардлагатай тохиолдолд нэмж болно

Хөнгөн хэргийн шийдвэрлэхэд 12-с доошгүй тангарагтанг оролцуулдаг бол хүнд, онц хүнд хэрэгт 12 тангарагтан оролцуулах ёстой.¹¹

Д. Бүгд найрамдах Солонгос улс

Иргэдийн төлөөлөгч нь гэм буруугийн талаарх дүгнэлтээ өөрөө бие даан гаргана. Харин иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн дүгнэлтийг тэдний дийлэнх олонхын саналаар гаргана. Нэгдсэн дүгнэлтээр яллагдагчийг гэм буруутай

гэж үзвэл шүүгч ял ногдуулах бөгөөд иргэдийн төлөөлөгч бүр ял шийтгэлийн талаар саналаа хэлэх боломжтой. Харин яллагдагчийн гэм буруу, ял шийтгэлийн асуудлыг шүүгч бие даан дангаараа шийдвэрлэх бөгөөд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт, саналыг заавал дагахгүй байж болно.

Мөн өөр нэг онцлох зүйл бол, иргэдийн төлөөлөгчийн оролцостой шүүн таслах үйл ажиллагаа нь яллагдагчийн зөвшөөрлийг авсан байх шаардлагатай. Тодруулбал, шүүх нь иргэдийн төлөөлөгч оролцох боломжтой эрүүгийн хэрэгт яллагдаж буй этгээдээс тухайн шүүн таслах ажиллагааг иргэдийн төлөөлөгчийн оролцоотой явуулах хүсэлт байгаа эсэхийг асуух ёстой. Яллагдагчид нь тухайн эрүүгийн хэрэг шүүхэд шилжсэнээс хойш 7 хоногийн дотор шүүхэд хандаж шүүн таслах үйл ажиллагааг иргэдийн төлөөлөгчийн оролцоотой явуулах эсэхийг бичгээр мэдэгддэг.¹²

Эрүүгийн хэргийн хүнд, хөнгөн байдлаас хамааран 5, 7, 9 зэрэг сондгой тооны иргэдийн төлөөлөгчийг шүүн таслах үйл ажиллагаанд оролцуулдаг.

Жил бүр тойргийн шүүхийн тэргүүн нь Нийтийн удирдлага, аюулгүй байдлын сайдад иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтын асуудлаар хандаж тухайн шүүхийн харьяалалд буй 20, түүнээс дээш насны иргэний бүртгэлийн мэдээллийг цахим хэлбэрээр ирүүлэхийг хүсдэг. Ийнхүү тухайн хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тойргийн шүүхэд хүргүүлнэ. Жил бүр

¹⁰ "The Constitution of the United States of America". Gpoaccess.gov. Archived from the original on 2008-09-19. Retrieved 2008-09-06.

¹¹ "Jury Service". United States Courts. Retrieved 2012-12-16.

¹² Ss 24 and 33A, High Court Ordinance

тойргийн шүүхийн тэргүүн нь иргэдийн төлөөлөгчөөр ажиллах боломжтой иргэний анхдагч жагсаалтыг гаргана. Энэ жагсаалтаас шаардлагатай тооны иргэдийн төлөөлөгчийг шүүхээс санамсаргүй тохиолдлоор сонгоно. Энэхүү үйл ажиллагаа нь олон нийтэд нээлттэй байдаггүй. Учир нь тухайн иргэдийн төлөөлөгчийн аюулгүй байдалтай холбоотой байдаг.

Е. Тайван Улс

Иргэдийн төлөөлөгчийн шийдвэрийг шүүгч харгалзан үзэж болно. Гэхдээ тухайн хэрэгт ял оногдуулах эсэх болон эцсийн шийдвэр гаргах эрх нь шүүгчид хадгалагдана. Хэрэв шүүгч иргэдийн төлөөлөгчдийн шийдвэрийг эс зөвшөөрвөл, тайлбараа амаар болон бичгээр гаргана. Шүүгч нь иргэдийн саналыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзвэл, шийдвэртээ тусгадаг ба санал зөрсөн тохиолдолд Үндсэн хуульд тусгасан зарчмын дагуу бие дааж хэргийг шийдвэрлэдэг.

Эндээс товч дүгнэлт хийвэл:

Манай Улсын болон гадаад орнуудад шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцох эсэх дээр маргаан байхгүй. Харин хэрхэн үр нөлөөтэй оролцуулах талаар хууль тогтоомждоо харилцан адилгүй зохицуулжээ. Зарим улсууд шүүхийн иргэдийн төлөөлөгчтэй холбоотой асуудлыг бие даасан хуулиар шийдвэрлэж байна. Энэ зохицуулалтаар иргэдийн төлөөлөгчид боловсрол, мэргэшил, нийгмийн байдлын хувьд харилцан адилгүй байдагтай холбоотойгоор тэдний үйл ажиллагаанд нэгдсэн стандарт тогтоох, иргэдийн

төлөөлөгч дүгнэлт хэрхэн гаргах, танилцуулах үе шат, дэгийг тодорхой байдлаар хуульчилсан байна

Санал

1. Монгол Улсад шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч хэрхэн оролцох, ямар байдлаар дүгнэлтээ илэрхийлэх, дүгнэлтийг шүүхийн шийдвэр, шийтгэх ба цагаатгах тогтоолд хэрхэн тусгах талаарх эрх зүйн нэгдмэл зохицуулалт дутагдалтай байна. Тэдний гаргасан дүгнэлтийг шүүхийн шийдвэр, тогтоолд тусгах талаар тодорхой зохицуулалтгүй. Тиймээс ч гаргасан дүгнэлтийг шүүх шийдвэртээ тусгах явдал хангалтгүй байна;
2. Хэрэг хянан шийдвэрлэх хуулиуд дахь иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэр /дүгнэлт, санал/ ялгаатай нэрлэгдэж байгааг нэг мөр болгох;
3. Иргэдийн төлөөлөгчид олгох хөлсийг орчин цагийн үнэлэмжтэй болгох
4. Хөдөө орон нутгаас иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон оролцож байгаа иргэнд шаардлагатай зардлыг олгох зохицуулалтыг бий болгох нь чухал байна.

КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Г.БАТНАСАН

(Шихихутуг Их Сургуулийн төр,
захиргааны эрх зүйн тэнхимийн багш)

Аливаа Улс орон төсөл арга хэмжээг гүйцэтгэхдээ дараах аргаар санхүүжүүлдэг:

- Тухайн улсын төсвийн хөрөнгөөр
- Гадаад улс орны хөнгөлттэй болон буцалтгүй тусламжаар
- Засгийн газар Зээллэг/Бонд/-оор
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар
- Концесс, Төр хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжүүлдэг байна.

Эдгээр 5 аргаас тухайн төсөл хөтөлбөрт тохирсон аргыг хэрэглэдэг. Гэтэл төсвийн санхүүжилт, хөрөнгө дутуу үед Концессын гэрээг хэрэгжүүлдэг хэмээх буруу ойлголт байдаг.

Монгол Улс бол хөгжиж буй орны нэг бөгөөд нийгмийн зарим суурь үйлчилгээг концессын гэрээгээр гүйцэтгэж байна. Тухайн улс орны нийгмийн суурь үйлчилгээг хүргэхэд төр хувийн хэвшлийн хоорондын гэрээ байх ёстой ба тэрхүү гэрээ нь Концессын гэрээ мөн.

Нэг. Концессын гэрээний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал

Түүх судлаачдын үзэж байгаагаар хамгийн анхны концессын гэрээ нь 1438 оны үед Францын язгууртан Луйс дэ Бэрнам Райн мөрнийг гатлах завьны

үйлчилгээ гаргаж, тээвэрлэж буй бараанаас татвар авах гэрээ нь байжээ.

Түүнчлэн ТХХТ¹ нэг хэлбэрийн уран зохиолд үлдсэн томоохон ул мөр нь 1792 Парисын ус түгээдэг хөвгүүдийн тухай түүх юм. Үүний дарзагаар Францад² концессын гэрээг зохицуулах хуулийг боловсруулан нэвтрүүлсэн нь хувийн хэвшил болон төрийн байгууллагын түншлэлд томоохон үүрэг гүйцэтгэж XVII зууны эхэн үеэс Европ даяар тархжээ. Тухай үед түгээмэл хийгдэж байсан концессын гэрээ:

1. Усны суваг
2. Зам
3. Төмөр зам салбарт гэрээ хийгдэж байв.³

Монгол Улс 2009 оны 10 сард УИХ-аас “Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого” хэмээх 64 дүгээр тогтоол улмаар 2010 оны 01 сард Концессын тухай хуулийг батлан гаргасан байна.

“Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого” хэмээх 64 дүгээр тогтоолын зорилго

¹ Төр хувийн хэвшлийн түншлэл

² concession de travaux publics

³ Европын сэргээн засалт хөгжлийн банкны ахлах зөвлөх Алексей Зверев European Bank-Хөгжиж буй орнуудын төр болон хувийн хэвшлийн түншлэлийн хууль зүйн орчны судалгаа...

нь: Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах, бүх талын түншлэлийг дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд түлхэц болоход оршиж байсан.⁴

Төрийн зарим чиг үүргийг улсын бус секторт шилжүүлэх үйл ажиллагааг захиргааны журмаар (ихэвчлэн тусгайлан байгуулсан бүтцээр дамжуулан) ба гэрээний үндсэн дээр шилжүүлэх гэсэн замаар хэрэгжүүлдэг.

Төрийн зарим үүргийг төрийн бус байгууллага, хувийн секторт шилжүүлэх үйл явцын үндсэн шалгуурууд нь шилжүүлсэн үүргийг хэрэгжүүлэх үр ашиг нэмэгдэх, үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх зэрэг үзүүлэлтийг шалгуур болгодог байна.

Төрийн үйлчилгээний чиг үүргийг улсын бус салбарт шилжүүлэхийн тулд дараах нөхцөлүүдийг бүрдүүлнэ. **Үүнд:**

- Нийтийн үйлчилгээг улсын бус салбарт шилжүүлэх шалгуурыг тодорхойлох;
- Нийтийн үйлчилгээг шилжүүлэн гүйцэтгэх гэж буй төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагыг тодруулах шалгуурыг тодорхойлох;
- Нийтийн үйлчилгээг дээрх байгууллагуудаар шилжүүлэн гүйцэтгүүлэх нөхцөлийг тодорхойлох зэрэг болно.

⁴ Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын газрын дарга Б.Заяабал., "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль эрх зүйн орчны танилцуулга"...

Мөн төрийн зарим чиг үүргийг шилжүүлж байгаа тодорхой тохиолдол бүрт ямар зорилтод хүрэх гэж буй, ийнхүү шилжүүлэхийн нийгмийн ач холбогдол бүхий үр дүн, урьд нь ямар сөрөг үр дүн гарч байсан, түүнийг хэрхэн арилгах арга зам зэргийг нарийн тооцож тодруулсан байх шаардлагатай байдаг байна.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудад шилжүүлэх нэг чухал нөхцөл нь төрийн зүгээс эдгээр байгууллагын үзүүлж буй үйлчилгээний чанарт хяналт тавих явдал юм. Ихэнх улс оронд энэхүү хяналтыг "Төрийн үйлчилгээний стандарт"-ын (*Public Service Standarts*)⁵ дагуу явуулдаг байна. Энэхүү стандартыг боловсруулахын тулд төрийн үйлчилгээний албан ёсны жагсаалтыг (*The register of Public Service*)⁶ гаргадаг.

Концесс нь ТХХТ нэг хэлбэр бөгөөд төр, концесс эзэмшигчид байгалийн баялаг, газар, дэд бүтцийн объектууд, үйлдвэрийн газар бусад аж ахуйн объектууд, тоног төхөөрөмжийг гэрээний үндсэн дээр харилцан ашигтай нөхцөлөөр ашиглуулахаар шилжүүлэх хэлбэр юм. Концессын гэрээний зүйл буюу объект нь гол төлөв нийтийн шинж чанартай объектууд байдаг, тухайлбал, нисэх буудал, төмөр зам, барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжууд мөн нийтийн тээврийн тогтолцоо, эрүүл мэнд, боловсрол, соёл, спортын объектууд зэрэг болно.

⁵ Public Service Standards 2007-2008. www.nationalarchives.gov.uk

⁶ National Register of Public Service. www.nrpsi.co.uk

Түүнчлэн концессын олон хэлбэр байдаг ба төсөл боловсруулах, барих ажлыг хувийн байгууллагад зөвшөөрч мөнгө, цаг хэмнэхийн зэрэгцээ гүйцэтгэлийн баталгаатай байдлыг хангах болон төслийн нэмэлт эрсдэлийг хувийн хэвшилд шилжүүлэх, хувийн хэвшлийн байгууллага үндэсний болон орон нутгийн засаг захиргааны захиалгаар тодорхой нэг үйлчилгээг (барилга байгууламж, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээ) хүргэх, түүнтэй холбогдох засвар үйлчилгээ зэрэг өдөр тутмын үйл ажиллагаа, ашиглалтыг гэрээгээр гүйцэтгэн төрийн эрх бүхий байгууллага тухайн барилга байгууламж, системийг өмчилж ерөнхий удирдлагаар хангах зэрэг хэд хэдэн хэлбэртэй.

Эдгээр хэлбэрүүд нь эрсдэл шилжүүлэх хэмжээ болон хувийн салбарын оролцооны хувьд харилцан адилгүй. Жишээ нь, Канад улс гэхэд урд нь төрийн хариуцаж байсан ажил үйлчилгээг хувийн хэвшилд бүхэлд нь концессоор гүйцэтгүүлэхийг түншлэлийн дээд хэлбэр гэж үздэг байна.⁷

Концессын гэрээ олноор байгуулагдаж буй үед тулгамдаж буй асуудлууд байна. **Үүнд:**

1. Улс төрийн тогтворгүй байдлаас болж Засгийн газар солигдох бүрд Концессын асуудал эрхлэх төрийн захиргааны байгууллага өөрчлөгдөж байна. Улс төрийн насжилтаас болж урт хугацааны төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байна.

⁷ Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь. Захиалгат судалгааны тайлан. УБ., 2010, 14 дэх тал

2. Яамд хоорондын уялдаа холбоо муу байна. Учир нь Концессын гэрээгээр хийх ажлын жагсаалтад оруулах төслийн саналыг салбарын яамдууд Концесс, ТХХТ-ийн асуудал эрхэлсэн байгууллага руу явуулдаг хэдий ч санал оруулсан төсөл Концессын жагсаалтад ордоггүй яамны санал болгоогүй төслийг Концессын жагсаалтад оруулсан байдаг нь яам хоорондын уялдаа холбоо муу байгаагийн илрэл юм.
3. Концессын гэрээгээр хэрэгжих төсөлд тавигдах шаардлага тодорхой байх нь чухал. Учир нь Концессын гэрээ нь нийгмийн суурь үйлчилгээг хүргэх урт хугацааны төсөл байх ёстой атал амьдрал дээр богино хугацаанд гүйцэтгэж болохгүй төсөлд бага хугацаа тогтоон хэрэгжүүлэх нь ихсэж байна.

Үүнээс дүгнэвэл: Концессын гэрээ түүний эрх зүйн зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Концессын хуулийн хэрэгжилт үйл ажиллагааг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах төрийн захиргааны нэгжийг тодорхой болгох, судалгаа шинжилгээг сайн хийж, техник эдийн засгийн үндэслэл бүхий төсөл хөтөлбөрийг дэмжиж яамд хоорондын уялдаа холбоо сайжруулах нь чухал юм.

Хоёр. Концессын гэрээний талаарх гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалт

1. ИХ БРИТАНИ УЛС

Их Британи улсад XVI зуунаас анх эхлэн орон нутгийн баян хүмүүс зээлийн сан бий болгон хувийн хөрөнгө оруулагчдаас

хөрөнгө мөнгө зээлж, эвдэрч муудсан зам засаж түүнийгээ ашиглуулахдаа хэрэглэгчийн хураамжийн шимтгэл авч зээлсэн өрөө буцаан төлдөг байжээ.

XIX зууны дунд үед Лондон хотын гүүр барих засварлах ажлын санхүүжилтийг дээрх журмаар хийж байжээ. Анх Лейборист намын засгийн газар 1997 онд иргэдэд өндөр чанартай төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хамтран ажиллах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх стратеги зорилт дэвшүүлэхдээ ТХХТ-ийг санаачилж, улмаар 2000 онд Их Британи улсын ТХХТ-ийн төв болсон Их Британи Түншлэл⁸ байгууллага бий болж үйл ажиллагаагаа эхэлжээ.

Хууль эрх зүй орчин: Их Британийн Төрийн үйлчилгээний тухай хууль 2009 онд шинэчлэгдсэн, Захиргааны байгууллагын шинэчлэлийн тухай хууль 2001, Төрийн зохицуулалтыг шинэчлэх болон харилцан тохиролцох гэрээ хийх тухай хууль 1994 он, Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 2000 он, Төрийн үйлчилгээний гомдол шийдвэрлэх тухай хууль 2005 он⁹, Иргэний түншлэлийн тухай хууль¹⁰ 2004 онд тус тус батлагдан гарсан байдаг.

Бодлогын баримт бичиг: Их Британи Түншлэл байгууллага нь 2000 он, Засгийн газар болон иргэний секторын хоорондын хамтын ажиллагааны гэрээ Их Британийн дотоод хэргийн яам

"2004 он, Иргэний Харти¹² 1991 онд батлагдсан баримт бичиг байдаг.

ИХ БРИТАНЫ ТҮНШЛЭЛ байгууллага нь ашгийн бус статустай бөгөөд анх тус улсын Сангийн яамны бүтцийн¹³ нэг хэсэг байсан бөгөөд 51 хувь нь хувийн салбарын пүүс компаниуд, үлдсэн 49 хувийн хувьцааг Сангийн Яам¹⁴ болон **Scottish Executive** эзэмшиж байна. Түүнийг Сангийн Яам болон төрийн салбарын бусад байгууллагууд бодлогын хүрээнд дэмжих үүрэгтэй ажилладаг байна. PUK хөрөнгөө хувь эзэмшигчдээс зээлийн хувьцаа хэлбэрээр босгож, зөвхөн шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих болон төрөөс баримтлах ТХХТ-ийн зорилтын хүрээнд шинэ бизнес хэрэгжүүлэхэд зориулж ашигладаг, илүүдэл ашгийг буцаан хөрөнгө оруулдаг ба хувь эзэмшигч нарт олгодоггүй байна.¹⁵

PUK улсын салбарт гагцхүү доорх 5 үндсэн салбарт ажлаа явуулахаар тогтжээ. Үүнд:

1. Цогц худалдан авалтын төслүүдийг дэмжих
2. Хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын бодлогыг хөгжүүлэх
3. Бие даасан дэд бүтцийн төслүүдийг боловсруулах
4. Төрийн үйлчилгээ ханган нийлүүлэгчийн загварыг боловсруулах
5. Төсөл болон компаниудад хөрөнгө оруулах

¹¹ Memorandum the civil partnership..., Орчуулга

¹² Cimiziens charter..., Орчуулга

¹³ Treasury Taskforce..., Орчуулга

¹⁴ HM Treasury..., Орчуулга

¹⁵ United Kingdom Treasury - Public Private Partnership policy and guidance... орчуулга

⁸ Partnerships UK-PUK..., Орчуулга

⁹ Public Services Ombudsman /Wales/ Act..., Орчуулга

¹⁰ Civil Partnership Act..., Орчуулга

Боловсролын салбарт хийгдсэн ажил нь:

Энэ салбарт хийгдсэн ТХХТ-ийн томоохон төслийн нэг болох New Deal for Schools (**NDS**) нь тус улсын 220 сургуулийн PFI аргачлалын дор хувийн хэвшил нь сургуулийн барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг гэрээгээр нийлүүлэн үйл ажиллагааг нь хариуцаж, бизнесийн ашиг орлого бий болгох чадвартайгаар орон нутгийн боловсролын байгууллага болон сургуультай хамтарч ажилладаг байна.¹⁶

2. КАНАД УЛС

Канад нь арван муж, гурван нутаг дэвсгэрээс тогтсон холбооны улс бөгөөд парламентын засаглалтай ардчилсан, үндсэн хуульт хаант улс юм. Канад нь технологийн хувьд хөгжсөн, аж үйлдвэржсэн орон.

Хууль эрх зүйн орчин: Хууль эрх зүйн хувьд Канадын холбооны болон мужийн хуулиудаар зохицуулагддаг.

Голлох хуулиудад:

1. Канадын стратегийн дэд бүтцийн санхүүгийн тухай хууль¹⁷

Хуульд стратегийн дэд бүтцийг тодорхойлж өгсөн. **Үүнд:**

1. Авто зам болон төмөр зам
2. Орон нутгийн тээврийн харилцаа
3. Аялал жуулчлал болон хотын хөгжил
4. Бохир ус цэвэршүүлэх
5. Цэвэр ус салбарыг хуульчилсан байна.

¹⁶ United Kingdom - PPPs in Infrastructure..., Орчуулга

¹⁷ Canada Strategic Infrastructure Fund Act..., Орчуулга

Энэхүү хуулиар хувийн хэвшлийг хэрхэн оролцуулах болон гэрээ байгуулах талаар хуульчилсан байна. Төсөл хөтөлбөрийг шалгаруулах болон гэрээ байгуулах асуудлыг Канадын хатан хааны хувийн зөвлөлийн гишүүн сайд хариуцдаг.¹⁸

2. Зам тээвэр, дэд бүтцийн түншлэлийн акт¹⁹

Хуулиар гэрээ байгуулахтай холбогдсон бүхий л харилцааг зохицуулж өгсөн бөгөөд гэрээг дараах байдлаар тодорхойлсон байна. Түншлэлийн гэрээ гэж барилга байгууламж болон дэд бүтэц, зам тээврийн ажил болон завсар үйлчилгээ үзүүлэх зорилгоор Засгийн газар болон хувийн хэвшлийн хооронд түншлэлийн урт хугацааны хүсэлт гаргахыг хэлнэ. Гэрээнд оролцогч нь Засгийн газар болон сайд, эсвэл хотын захиргаа байж болно гэж заасан байна. Мөн түүнчлэн хуульд төсөл хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болон гэрээнд өөрчлөлт оруулах, эзэмшил, хариуцлагын талаар зохицуулсан байна.²⁰

Канад нь гадаадын хөрөнгө оруулагчидтай зарим томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ Концессын гэрээ байгуулан ажилладаг байна. Дэ Чо гүүрийг концессын гэрээ байгуулсан байна. Канад улсад төрийн зарим чиг үүргийг гэрээгээр болон хуулийн дагуу шилжүүлэн хэрэгжүүлдэг

¹⁸ Canada establishment of a PPP unit and powers of PPP..., Орчуулга

¹⁹ Act respecting transport infrastructure partnerships..., Орчуулга

²⁰ Canada establishment of a PPP unit and powers of PPP..., Орчуулга

мэргэжлийн холбоод байдаг бөгөөд тэдгээр холбоод нь тухай салбарын харилцааг удирдах, зохицуулах, хяналт тавих бүхий л харилцааг хууль болон дүрэм, журмаар зохицуулдаг байна.

3. АМЕРИКЫН НЭГДСЭН УЛС

АНУ-д дэд бүтцийг ханган нийлүүлэхэд хувийн салбарын оролцоо бусад орнуудтай харьцуулахад харьцангуй голлох байр суурь эзэлж байна. Холбооны мужийн болон орон нутгийн засаг захиргааны нэгжийн хэмжээнд дараах ажил үүргүүдийг гэрээгээр гүйцэтгүүлдэг байна. **Тухайлбал:**

1. Цэвэр болон бохир ус
2. Хог хаягдлын үйлчилгээ
3. Нийтийн аж ахуйн үйлчилгээ
4. Барилгын засвар үйлчилгээ
5. Архитектур ба инженерийн үйлчилгээ
6. Түргэн тусламжийн үйлчилгээ
7. Барилга, байгууламжийн менежментийн удирдлага ба ашиглалт гэх мэт.²¹

Мөн хувийн хэвшил дангаараа эсхүл улсын салбартай хамтарсан хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төлбөрт авто замын барилгын ажлууд орно. Хувийн салбарын пүүс компаниуд бас нийгмийн салбар болох сургууль, халамжийн үйлчилгээний хөтөлбөр, хотын дотоод хөгжлийн дахин сайжруулалт болон төрийн барилга байшин барих зэрэг ажил үүргийг Төр хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтаар хийдэг.

²¹ Public-Private Partnerships in Transportation - a Toolkit for Legislators developed by the National Conference of State Legislators (2010 with updates from 2014) - includes links to PPP enabling legislation in the transport sector in different states of the United States..., Орчуулга

Хууль, эрх зүйн орчин: АНУ-ын хувьд Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн үйлчилгээний тухай хууль болон бусад салбарын хуулиудаар зохицуулагддаг байна. Харин өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагуудын хувьд Канадаас нэлээд туршлага солилцож эрчимтэй хөгжүүлж байгаа улсуудын нэг юм. Тухайлбал: АНУ-ын хувьд мэргэжлийн томоохон холбоо, нэгдлүүдээр болон өөрөө өөрийгөө зохицуулагч холбоодоор энэхүү үүргийг гүйцэтгүүлдэг жишиг байдаг байна.²²

4. БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР УЛС

Хууль эрх зүйн орчин: Төрийн болон орон нутгийн онцгой объект газруудад Концессын хууль нөхцөл журманд заасны дагуу Хувийн хэвшлийн аж ахуй нэгжтэй Концессын гэрээ байгуулан ажилладаг.²³ Концессын гэрээ байгуулсан хувийн хэвшлийн аж ахуй нэгжид төр тодорхой хөнгөлөлтүүдийг үзүүлдэг. Концессын гэрээ байгуулах шийдвэрийг төрийн өмчийн газрууд, орон нутгийн концессын гэрээ байгуулах шийдвэрийг тухайн орон нутгийн өмчийн газраас гаргадаг байна. Концессын гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн хувьд 35 жилийн хугацаагаар олгож болно. Энэ хугацаа нь концессын нийт хугацаа нь 50 жилээс хэтрэхгүй байна гэдгийг анхаарч сунгаж болно.²⁴

²² Public-Private Partnerships for Public Facilities - Legislative Resource Guide, American Institute of Architects (AIA), November 2014. The Legislative Resource Guide was developed for jurisdictions in the United States. It provides important elements in a successful PPP law..., Орчуулга

²³ PPP Legislation..., Орчуулга

²⁴ Article on Bulgarian Concession Law ..., Орчуулга

Дээрхээс дүгнэн үзвэл:

XVIII-зууны үеэс анхны концессын гэрээний үйл ажиллагаа эхэлсэн улс юм. Мөн Төр хувийн хэвшлийн түншлэл, Концесс хариуцсан **ИХ БРИТАНЫ ТҮНШЛЭЛ** байгууллага нь тодорхой салбаруудад хөрөнгө оруулалт хийдэг төр, хувийн хэвшлийн хамтарсан байгууллага юм. **Канад Улс** нь Канадын стратегийн дэд бүтцийн санхүүгийн тухай хуулиар²⁵ тухайн төсөл хөтөлбөрт хувийн хэвшлийг хэрхэн оролцуулах болон гэрээ байгуулах талаар хуульчилсан байна. Төсөл хөтөлбөрийг шалгаруулах болон гэрээ байгуулах асуудлыг Канадын хатан хааны хувийн зөвлөлийн гишүүн сайд хариуцдаг байна. **АНУ-ын** хувьд Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн үйлчилгээний тухай хууль болон бусад салбарын хуулиудаар зохицуулагддаг байна. Харин **Бүгд Найрамдах Болгар Улс** нь Концесс, ТХХТ-ийн гэрээг 35-50 жилийн хугацаатай байгуулдаг байна. Мөн **Бүгд Найрамдах Солонгос Улс** нь Дэд бүтцийн олон нийтийн, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуультай ба уг хуулиар Концессын харилцаагаа зохицуулдаг байна.

ДҮГНЭЛТ/САНАЛ/

Концесс нь ТХХТ-ийн нэг хэлбэр бөгөөд төр, концесс эзэмшигчид байгалийн баялаг, газар, дэд бүтцийн объектууд, үйлдвэрийн газар бусад аж ахуйн объектууд, тоног төхөөрөмжийг гэрээний үндсэн дээр харилцан ашигтай нөхцөлөөр ашиглуулахаар шилжүүлэх хэлбэр юм. Концессын гэрээний зүйл

буюу объект нь гол төлөв нийтийн шинж чанартай объектууд байдаг, тухайлбал, нисэх буудал, төмөр зам, барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжууд мөн нийтийн тээврийн тогтолцоо, эрүүл мэнд, боловсрол, соёл, спортын объектууд зэрэг болно.

Гадаадын зарим орны туршлагаас харахад төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төрийн зарим үүргийг улсын бус секторт шилжүүлэн гүйцэтгүүлэх үйл ажиллагааг олон янзын хэлбэрээр нэвтрүүлсэн нь үр дүнтэй болжээ. Үүнийг улс бүрээр нь **НЭГТГЭН АВЧ ҮЗЬЕ:**

1. Их Британи Түншлэл байгууллага²⁶ нь 51 хувь нь хувийн салбарын пүүс компанууд, үлдсэн 49 хувийн хувьцааг Сангийн Яам болон Scottish Executive эзэмшдэг ба хөрөнгөө хувь эзэмшигчдээс зээлийн хувьцаа хэлбэрээр босгож, зөвхөн шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих болон төрөөс баримтлах ТХХТ-ийн зорилтын хүрээнд шинэ бизнес хэрэгжүүлэхэд зориулж ашигладаг, илүүдэл ашгийг буцаан хөрөнгө оруулдаг ба хувь эзэмшигч нарт олгодоггүй байна. Энэхүү байгууллага нь Төр – Хувийн хэвшлийн хамтарсан байгууллага юм.

2. Канад улсын хувьд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх эрх зүйн эрчин нь нэлээн боловсронгуй ба Төрийн үйлчилгээний тухай хууль, Төрийн үйлчилгээг өөрчлөх болон үүргийг шилжүүлэх тухай акт, Зам тээвэр, дэд бүтцийн түншлэлийн акт зэрэг гол хуулиуд нь төрийн

²⁵ Canada Strategic Infrastructure Fund Act ... Орчуулга

²⁶ Partnerships UK-PUK..., Орчуулга

зарим үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, гэрээ байгуулахтай холбогдсон бүхий л харилцааг зохицуулж өгсөн. Мөн дэд бүтэц, нийтийн тээвэр, ус болон хог хаягдлын байгууламж, эмнэлэг, сургууль, халамжийн байгууллага, олон нийтийн амралт соёлын төвийн үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог өргөн ашиглаж байна.

3. АНУ-д дэд бүтцийг ханган нийлүүлэхэд хувийн салбарын оролцоо бусад орнуудтай харьцуулахад харьцангуй голлох байр суурь эзэлж байна. Холбооны мужийн болон орон нутгийн засаг захиргааны нэгжийн хэмжээнд цэвэр болон муу ус, хог хаягдлын үйлчилгээ, нийтийн аж ахуйн үйлчилгээ, барилгын засвар үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээ, түргэн тусламжийн үйлчилгээ болон барилга байгууламжийн менежментийн удирдлага, ашиглалтыг голчлон гэрээгээр гүйцэтгүүлдэг нийтлэг жишиг эртнээс тогтжээ. **Эндээс дүгнэн үзвэл:**

1.ТХХТ, Концессын хуулийн хэрэгжилт үйл ажиллагааг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах төрийн захиргааны нэгжийг тодорхой болгох: Улс төрийн тогтворгүй байдлаас болж ТХХТ, Концесс хариуцсан байгууллагууд өөр яам, агентлагуудад харьяалагдаж ирсэн. Үүнийг зогсоохын тулд төрийн захиргааны нэгжийг бий болгох хэрэгтэй юм. Учир концессын гэрээ нь 20-30 жилээр хийгдэх урт хугацааны гэрээ байдаг. Улмаар аливаа

Засгийн газар, Их хурлын бүрэн эрхийн хугацаанаас урт хугацаатай гэрээнүүд байгуулагдана. Тиймээс гэрээг улс төрийн болон тодорхой эрсдэлүүдээс хамгаалах асуудал гарч байгаа юм. Эдгээр эрсдэлээс ангид байлгах үүднээс бие даасан төрийн захиргааны нэгж байгуулах нь зүйтэй юм.

2. Яам хоорондын уялдаа холбоог сайжруулах: ТХХТ, Концессын гэрээг байгуулахдаа тухайн салбарын яам, агентлагийн санал дүгнэлтийг авч салбар хоорондын мэргэжилтнүүдээс бүрдүүлсэн ажлын хэсгийг байгуулах, түүний ажилд хяналт тавих тогтолцоог бий болгох.

3. Судалгаа, Шинжилгээний тусгай байгууллагыг ТХХТ, Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны нэгжид байгуулах: ТХХТ, Концессын гэрээг байгуулахдаа тухайн салбарын дүгнэлтийг сайн авч, техник эдийн засгийн үндэслэл, тухайн гэрээний үр дүн дэд бүтцийн асуудлыг судлан мэдэх, судалгаа шинжилгээний байгууллага байгуулах.

4. ТХХТ, Концессын гэрээгээр мэргэшсэн боловсон хүчинг бэлтгэх: ТХХТ, Концессын гэрээний ойлголт Монгол Улсад шинэд зүй ёсоор тооцогдоно. Энэхүү гэрээний талаарх мэдлэгтэй боловсон хүчинг бэлтгэх нь Концессын гэрээний цаашдын хөгжилд тусгай хэрэг мөн.

ХУУЛИЙН ТАЙЛБАР

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЙЛБАР (ЦУВРАЛ НИЙТЛЭЛ)

А.ДОРЖГОТОВ

(Шихихутуг их сургуулийн иргэн,
бизнесийн эрх зүйн тэнхимийн багш)

8 дугаар зүйл. Компанийн үйл ажиллагааны чиглэл, байгуулах хугацаа

8.1 Компани нь хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд компани нь үйл ажиллагаагаа эрхлэхэд шаардагдах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

8.2 Компани эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээг дүрмээрээ хязгаарлаж болно.

8.3 Энэ хуулийн 8.2-т заасны дагуу компани эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээг хязгаарласан нь уг хязгаарлалтыг мэдэхгүйгээр хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа гуравдагч этгээдийн өмнө уг компанийн хүлээсэн үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.4 Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

8.5 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийг тодорхой бус хугацаагаар үүсгэн байгуулна.

ТАЙЛБАР

Компанийн үйл ажиллагааны чиглэл, байгуулах хугацааг тодорхойлсон 8 дугаар зүйл нь компанийн эрхэлж болох үйл ажиллагаа, түүний хязгаарлалт, зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх зэрэг асуудлыг хамааруулан зохицуулсан байна.

Компани хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлж болно. Компани үйл ажиллагаагаа эрхлэн явуулахдаа хуулиар тогтоосон эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Компанийн үйл ажиллагааны агуулга нь түүний эрх, үүргийн нэгдлээр тодорхойлогдоно.

Компанийн үйл ажиллагааны хүрээг:

- a) Хууль тогтоомжсор хязгаарлаж болно.
- b) Тухайн компани өөрийн эрхлэх үйл ажиллагааг дүрмээрээ хязгаарлах эрх зүйн боломжийг хуульчилж тогтоожээ. (8.2)

Хуулийн энэ зсхицуулалт нь компани дүрмээрээ хязгаарласан үйл ажиллагаанд оролцохгүй байх, уг үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хариуцлага хүлээхгүй байх эрх зүйн нөхцөл байдлыг бүрдүүлнэ. Гэвч энэ нь тухайн компанийн хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй байх тохиолдол

бий. Энэ үндэслэл дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

1/Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа гуравдагч этгээдэд хамаарч байна.

2/Эрхлэх үйл ажиллагаагаа хязгаарласан компани хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа гуравдагч компанийн өмнө үүрэг хүлээсэн байх нөхцөл байдлаар тодорхойлогдох болно.

Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа гэдэг ойлголтод тухайн гуравдагч компани хууль зөрчсөн ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй, хууль бус гэрээ хэлцэлд оролцоогүй зэрэг нөхцөл байдлыг хамааруулан ойлгох хэрэгтэй.

-Эрхлэх үйл ажиллагаагаа хязгаарласан компаниас хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрх бүхий гуравдагч компани нь тус компани эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээг дүрмээрээ хязгаарласан болохыг мэдээгүй байж болох нөхцөл байдлыг хуулиар тогтоосон байна.

Эдгээр нөхцөл тогтоогдож байвал компани эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээг хязгаарласан байлаа ч уг *хязгаарлалтыг мэдэхгүйгээр* харилцсан гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээс тухайн компани чөлөөлөгдөхгүй.

Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл. Компанийн тухай хуулиар (8.4) компанийн үйл ажиллагаа эрхлэхэд:

- a. Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа
- b. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөл гэсэн ойлголтыг томъёолсон байна.

с. Эдгээр ойлголтын холбох үндсэн зохицуулалт бол "хуульд заасны дагуу", "бичгээр олгосон зөвшөөрөл" байх ба тухайн зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх эрхтэй болно гэсэн санааг илэрхийлжээ.

Энэ асуудлаар "Компанийн эрх зүй" (гарын авлага) номонд тэмдэглэхдээ: "Компани нь хуулиар хориглоогүй үйл ажиллагаа эрхлэх чадвартай. Гэвч тодорхой төрлийн үйл ажиллагааг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх тухай Иргэний хуульд болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан журам нь хуулийн этгээд болох компанийн эрх зүйн чадамжийг тодорхойлж байгаа хэрэг юм"¹ гэжээ.

"Хувьцаа эзэмшигчийн эрх" номонд Компанийн үйл ажиллагааны хязгаарлалт, түүний агуулгын талаар "Компанийн тухай хуульд зааснаар компани хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад хуулиар тогтоосон эрх эдэлж, үүрэг хүлээдэг ... компанийн үйл ажиллагааны хүрээг А. хуулиар хязгаарлаж болно, Б. тухайн компани дүрмээрээ хязгаарлаж боломжтой. Гэхдээ энэ хязгаарлалтыг мэдээгүй тухайн компанитай харилцсан гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх эрх зүйн үндэслэл болдоггүй"² гэж тэмдэглэжээ.

¹ Д.Дүгэржав, Ж.Дашдорж. Компанийн эрх зүй (гарын авлага) УБ.2003 он. Хуудас 4

² А.Доржготов, Б.Амарсанаа, Л.Ганзориг. Хувьцаа эзэмшигчийн эрх. (Шүүгчдийн сургалтын гарын авлага) УБ.2014 он. 2017 он.

Тусгай зөвшөөрөл. Компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх зүйн эх сурвалжид Иргэний хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол улсын хууль хамаарна. Хуулийн зарим зүйл заалт Иргэний хуулийн 26 дугаар зүйлд "Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй." (ИХ 26.7)

Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс эхлэн тухайн үйл ажиллагааг явуулах эрх үүснэ. (ИХ 26.8) Хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг гагцхүү хуульд заасан үндэслэл журмаар хязгаарлана. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулдаг.

Компанийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл" гэж тодорхой төрлийн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг, эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг хэлдэг. Жишээлбэл: Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг

Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас олгодог, хуульд заасан бол хүнсний чиглэлийн үйл ажиллагааг зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ гэх мэт.

Тусгай зөвшөөрөл шаардах аж ахуйн үйл ажиллагааг тусгайлан заасан бол тухайн нутаг дэвсгэрт явуулах ёстой. Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.

Хориглох аж ахуйн үйл ажиллагаа. Компани Монгол улсын нутаг дэвсгэрийн хуулиар хориглосон аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрхгүй. Тухайлбал:

- Хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах үйл ажиллагаа эрхлэх;
- Казиногийн үйл ажиллагаа эрхлэх (чөлөөт бүсийн хууль тогтоомжид хамаарахгүй);
- Олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа эрхлэх; Энэ үйл ажиллагаа манай оронд гол төлөв санхүүгийн үйл ажиллагааны сүлжээний хэлбэрээр илэрхийлэгддэг.
- Садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих, эдгээр үйл ажиллагааг компани эрхлэн явуулж болохгүй. Эдгээр нь компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан компанийн үйл ажиллагааны

чиглэлд шууд хамааралтай юм.

Компанийг тодорхой бус хугацаагаар үүсгэн байгуулна. Компанийн тухай хуулийн 8.5-д дүрэмдээ өөрөөр заагаагүй бол тодорхой бус хугацаагаар үүсгэн байгуулах тухай заажээ. Иргэний хуульд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээдийг иргэн, хуулийн этгээд байгуулж болно. Хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулна. Тэр чиг үүргээ хэрэгжүүлэх, нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа эсхүл хамтран хуулийн этгээд байгуулж болохоор заасан нь компанийн хуулийн зохих заалтад хамааралтай юм.

Компани байгуулах хугацааны талаар

тухайн компанийн дүрэмд өөрөөр зааж болох бөгөөд тодорхой хугацаагаар байгуулах боломжтой. Жишээ:

Компанийн тухай дүрэмд хугацаа заасан бол Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3-д зааснаар түүнийг үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан буюу зорилгодоо хүрсэн, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэж тус компанийн шийдвэр гарах, түүнийг татан буулгах үндэслэл болох магадлалтай.

Компанийн тухай хуулийн 12-17 дугаар зүйлд Компанийн үүсгэн байгуулах, бүртгүүлэх зэргийг тодруулан зохицуулжээ.



9 дүгээр зүйл. Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага

9.1 Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

9.2 Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

9.3 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

9.4 Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

9.5 Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

ТАЙЛБАР

Хариуцлага: Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хүлээх хариуцлага, компанид өөрийн хөрөнгөөр хариуцах эрх зүйн үндэслэл, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх зааглагдаагүй бол өр төлбөрийг давхар хариуцах тухай зохицуулалтыг 9 дүгээр зүйлд тодорхойлон зохицуулсан байна.

Хуулийн этгээдийн хариуцлагын онцлог нь гэвэл өмчлөгч, хувьцаа эзэмшигч, гишүүн нь хязгаарлагдмал хариуцлага хүлээх эсэх тухай асуудал байдаг. Энэ нь хөрөнгө оруулагч этгээдийн бусдын өмнө хүлээх хариуцлагыг хязгаарлах хууль зүйн боломж бий эсэх чухал.

Хязгаарлагдмал хариуцлагатай хуулийн этгээдийн хувьд түүнд хөрөнгө оруулсан хувьцаа эзэмшигч нь оруулсан хөрөнгө эсхүл санхүүгийн сонирхлоо худалдан авахад зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр л хуулийн этгээдийн бусдын өмнө хүлээх хариуцлага нь хязгаарлагддаг.³

Энэ нь хуулийн этгээдийн бусдад учруулсан хохирлыг түүний хөрөнгө оруулагч төлөхгүй, хуулийн этгээд бүрэн хариуцах ёстой болдог. Харин *бүрэн хариуцлагатай* хуулийн этгээдийн хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд хэтэрсэн хэмжээгээр гишүүн, хувьцаа эзэмшигч (хөрөнгө оруулагч) өөрийн хувийн хөрөнгөөс нөхөн төлөх хариуцлага хүлээдэг.

Компани эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ. Компанийн эд хөрөнгө нь хувь

³ Б.Амарсанаа компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал. УБ.2012 он. Хуудас 1-12 дахь тал

нийлүүлэгчийн оруулсан хөрөнгөөс бүрдэж, компанийн дүрэмд заасны дагуу тодорхой тооны хувьцаанд хуваагддаг. Иргэний хуульд компанийн үндсэн шинжийг тодорхойлохдоо “хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ” гэжээ. Хуулийн этгээд нь:

- a) Өөрийн тусгайлсан эд хөрөнгийг өмчилдөг
- b) Өөрийн тусгайлсан эд хөрөнгийг эзэмшиж ашиглах замаар эрхээ хэрэгжүүлдэг хоёр хувилбарт ангилан үзэж болох юм.

Энэ үзэл санаанд тулгуурлан эрхзүйн зарим ном, бүтээлд сан, шашны байгууллага зэрэг хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, гишүүн хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд эд хөрөнгийн аливаа эрх эдэлдэггүй, хуулийн этгээд тусгайлсан эд хөрөнгөө өмчилдөг.

Компани, нөхөрлөлийн гишүүн, хувьцаа эзэмшигч нь тухайн хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийг удирдах этгээдэд санал өгөх замаар эрх олгож, өөрийн хүсэл зоригийг илэрхийлэн оролцдог. Ногдол ашиг авдаг, татан буугдах үед үлдсэн хөрөнгөөс өөрт ногдох хэсгээс хувь хүртдэг зэргээр эд хөрөнгийн эрх эдэлдэг гэдэг утгаараа тусгайлсан эд хөрөнгийн өмчлөгч нь гишүүн буюу хувьцаа эзэмшигч байна. Компани бол эзэмшсэн хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах

эрхтэй⁴ гэх үзэл санааг илэрхийлжээ.

Гэвч “компанийн өөрийн хөрөнгө” гэх ойлголтод тулгуурлан, хувьцаа эзэмшигч компанийн тодорхой эд хөрөнгийг өмчлөх, захиран зарцуулах эрхгүй гэдгийг ойлгох ёстой. Компанийн тухай хууль (9.1)-д компанийн эд хөрөнгө бүрдэхдээ:

- a) Түүний эзэмшиж байгаа эд хөрөнгө
- b) Компанийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн эрхээс бүрдэнэ гэх утга санааг илэрхийлжээ.

Компани эзэмшиж байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, “эдгээр бүх эд хөрөнгөөрөө” хариуцлага хүлээнэ. Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх хариуцлагыг хүлээхгүй. Энэ бол компанийн хариуцлага хүлээх хууль зүйн зохицуулалтын онцлог, компанийн эд хөрөнгийг хувьцаа эзэмшигч шууд утгаараа өмчилдөггүй, хувьцаа эзэмшигч зөвхөн өмчлөл, эзэмшлийн саналын эрхээр компанийн зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцдог зэрэгтэй холбоотой.

Хувьцаа эзэмшигчийн хариуцлага. Хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Тэрээр компанийн хүлээх үүргийг хариуцахгүй. Өөрөөр хэлбэл, компанийн үйл ажиллагаа бий болсон үүрэг биелүүлэх, түүний төлбөл зохих өр төлбөрийг хувьцаа эзэмшигч хариуцахгүй, нөхөн төлбөр хүлээлгэх хууль эрх зүйн үндэслэл байхгүй. Иймээс компаниа харилцах, гэрээ хэлцэл байгуулахдаа болгоомжтой

* Д.Дүгэржав, Ж.Дашдорж. Компанийн эрх зүй. УБ. 2003 он. Хуудас-4

хандах, түүний үйл ажиллагаа, өөрийн хөрөнгийн хэмжээг зайлшгүй харгалзан үзэх хэрэгтэй болдог. Учир нь компанийн бусдад учруулсан хохирлыг хөрөнгө оруулагч төлөхгүй, хувьцаа эзэмшигч хариуцахгүй, харин компани хуулийн этгээдийн хувьд бүрэн хариуцах ёстой. Анхаарах асуудал бол компанийн хариуцлага, хязгаарлагдмал хариуцлагыг хүлээх эрх зүйн ойлголтыг буруугаар ашиглах, хуурамчаар дампуурал зарлах зэргээс бас сэргийлэх асуудал чухал гэж хэлж болно.⁵

Хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцах. Компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг хохирол учруулсан этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцах эрх зүйн үндэслэлийг хуулийн 9.4-т заасан байна. Компанийн өмнө өөрийн эд хөрөнгөөр хариуцлага хүлээвэл зохих буруутай этгээдэд:

1. Компанийн хувьцаанаас 10-аас дээш хувийг эзэмшигч
2. Компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээд тус тус хамаатай байна.

Компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь:

- a) Уг хувьцааг дангаараа эзэмшиж байгаа
- b) Хувьцааг нэгдмэл сонирхолтой этгээд хамтран эзэмшиж байгаа

Эдгээр тохиолдолд түүний явуулсан

5 Хязгаарлагдмал хариуцлага хүлээх хуулийн этгээд болохыг үл хэрэгсэх. Pibcing corporate veil гэх ойлголт байдаг ажээ. Энэ нь хязгаарлагдмал хариуцлагыг эрхзүйн ойлголтыг буруугаар ашиглахаас сэргийлэх зорилготой.

үйл ажиллагаа буруу байсны улмаас компанид эд хөрөнгийн хохирол учирсан бол тэрээр өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцлага хүлээх болно. Хувьцаа эзэмшигчийн буруутай үйл ажиллагаа нь хэлцэлд оролцсон, шийдвэр гаргахад зохих ёсоор нөлөөлсөн, компанийн эд хөрөнгийг эзэмшиж, ашиглах, захиран зарцуулах, бусдад шилжүүлэх, данснаас хасахад оролцсон гэх мэт ямар ч арга хэлбэрээр илэрч болох юм. Гагцхүү түүний явуулсан үйл ажиллагаа хууль тогтоомж, компанийн дүрэм, журам зөрчсөн, гэм буруутай байх, түүний үйл ажиллагааны улмаас компанид эд хөрөнгийн хохирол учирсан байх ёстой.

Компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээд. Хуульд заасан энэ ойлголтод хамаарагч нь өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцлага хүлээнэ.Түүний хариуцлага хүлээх үндэслэл дараах байдлаар ойлгогдож байна.

1-рт: Компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч энэ ойлголтод хамааралгүй ;

2-рт: Компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох гэдгийг компанийн үйл ажиллагаанд саналын эрхээр нөлөөлөхөөс бусад хэлбэрээр оролцож, нөлөөлөх бэллолцоотой этгээд гэх агуулгыг илэрхийлжээ.

3-рт: Тэрээр компанийн үйл ажиллагааг тодорхойлох эрх бүхий этгээд байх нь;

4-рт: Түүний явуулсан үйл ажиллагаа буруу байсан; Тухайлбал, компанийн дүрэм, журам зөрчсөн, хувьцаа

эзэмшигчийн хурал, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, түүний явуулсан буруутай үйл ажиллагааны улмаас компанид хохиролтой шийдвэр гаргасан гэх мэт.

5-рт: Компанийн үйл ажиллагааг тодорхойлохдоо алдаа, дутагдал гаргасны улмаас компанид эд хөрөнгийн хохирол учирсан, улмаар тэрээр түүнд буруутай байсан, үйлдэл, гэм буруу шалтгаант холбоотой байх гэх мэт нь хариуцлага хүлээх эрх зүйн үндэслэл бий болсон байх ёстой.

Тухайлбал, компанид зөвлөх үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаанд нь хязгаарлалт тавих чиглэл өгөх гэх мэт эрх бүхий этгээд байж болох юм. Эдгээр компанийн нэрийн өмнөөс хариуцлага хүлээх асуудалд хамааралгүй. Харин компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг хариуцах ойлголт юм. Мөн тэдгээр нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.

Компанийн өр төлбөрийг давхар хариуцах. Компанийн тухай хуулийн 9.5-д энэ ойлголтыг тодорхойлжээ. Хувьцаа эзэмшигч компанид оруулсан хөрөнгөө хувийн эд хөрөнгөөс зааглах тул тус тусад нь тодорхойлж, компани өөрийн хөрөнгөө санхүүгийн бүртгэл, тайлан тэнцэлд тусгасан байх ёстой.

Энэ ажиллагаа зохих ёсоор хийгдсэн, хувийн болон компанийн эд хөрөнгө тодорхой зааглагдсан байх нь "хувьцаа эзэмшигч гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр" хариуцлага хүлээх үндэслэл болно. Ийнхүү зааглагдах шаардлагатай хөрөнгөд

а) Хувийн эд хөрөнгө

б) Эд хөрөнгийн эрх тус тус хамаарна. Компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх зааглагдсан тохиолдолд компанийн өөрийн хөрөнгө гэсэн ойлголтод хувьцаа эзэмшигчийн хөрөнгө хамаардаггүй. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хувийн эд хөрөнгөөс зааглаагүй, зохих ёсоор санхүүгийн бүртгэл, тайлан тэнцэлд тусгаагүй, компанийн үүрэгтэй холбоотой өр төлбөрийг хувийн эд хөрөнгөөр хариуцах эрх зүйн үндэслэлийг энд тогтоосон байна.

Компани өөрийн үүрэгтэй холбоотой өр төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, түүний өөрийн хөрөнгө төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй зэрэг тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр, түүний бүх хөрөнгөөр компанийн өр төлбөрийг хариуцан барагдуулах болно. Компанийн өр төлбөрийг түүний хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгөөр хариуцахыг хуульд **компанийн өр төлбөрийг давхар хариуцна** хэмээн томъёолон тусгажээ.

Ийм тохиолдол нэг хувьцаа эзэмшигчтэй компани, гэр бүлийн жижиг компаниудын үйл ажиллагаанд ажиглагддаг. Ийм компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн өр төлбөрийг давхар хариуцах магадлал өндөр байдаг.

Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх хувийн эд хөрөнгөөс бүрэн зааглагдсан ердийн нөхцөлд компани хариуцлага хүлээх эрх зүйн зохицуулалт дараах

байдлаар илэрхийлэгдэнэ.

- Компанийн эд хөрөнгө нь түүний эзэмшилд байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс бүрдэнэ. Энэ нь компанийн хариуцлага хүлээх эд хөрөнгийн хязгаарыг тодорхойлдог. Компани бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээдэг.
- Компани хувьцаа эзэмшигчдийнхээ хүлээх үүргийг хариуцахгүй.
- Хувьцаа эзэмшигч компанийн хүлээх үүргийг хариуцахгүй
- Хувьцаа эзэмшигч зөвхөн өөрийн эзэмшсэн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээдэг.

Эдгээр нь компанийн хариуцлага хүлээдэг ердийн зарчим юм. Хариуцлагын энэ зарчим бол компанид хөрөнгө оруулагч этгээдийн бусдын өмнө хүлээх хариуцлагыг хязгаарлах хууль зүйн боломжийг олгодог байна.

10 дугаар зүйл. Компанийн оноосон нэр, оршин байгаа газар

10.1 Компани оноосон нэртэй байх бөгөөд түүнийг хэрэглэх бүрд уг нэрийн ард компанийн хэлбэрийг тодорхойлсон хувьцаат компани буюу "ХК", хязгаарлагдмал хариуцлагатай компани "ХХК" гэсэн ялгах тэмдэглэгээ заасан байна.

10.2 Компанийн оноосон нэр нь бусад компани, өөр хуулийн этгээдийн оноосон нэртэй давхардаагүй байх бөгөөд компани оноосон нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлснээр түүнийг хэрэглэх онцгой эрхтэй

болно.

10.3 Компани нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн өөрийн бэлгэдэл болон барааны тэмдэгтэй байж болно.

10.4 Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлно.

10.5 Компанийн хаягийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

ТАЙЛБАР

Компанийн нэр. Компани нь хуулийн этгээд болохын хувьд өөрийн нэртэй байна. Иргэний хуулийн 27 дугаар зүйлд зааснаар хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийн тусгасан байхын хамт хуульд заасан бол хуулийн этгээдийн төрлийг заасан нэртэй байхаар Иргэний хуулиар зохицуулсан байдаг. Компанийн тухай хуульд зааснаар компани оноосон нэртэй байх, оноосон нэрийг хэрэглэх тохиолдол бүрд уг нэрийн ард компанийн хэлбэрийг тодорхойлсон хувьцаат компани "ХК", хязгаарлагдмал хариуцлагатай компани "ХХК" гэсэн ялгах тэмдэглэгээ заана.

Иргэний хуульд хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан байж болохгүй, мөн хуулийн этгээдийн нэр бусдыг төөрөгдүүлэхээр бусад хуулийн этгээдийн нэртэй ижил төстэй байж болохгүй. Иргэний

хуулийн энэ шаардлага бол эрх зүйн ач холбогдолтой. Учир нь тухайн компанийн нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага, шударга өрсөлдөөн гэх мэт олон зүйлээр тайлбарлагдана.

Компанийн тухай хуульд зааснаар компанийн оноосон нэр бусад компани, өөр хуулийн этгээдийн оноосон нэртэй давхардаагүй байхаар зохицуулжээ.

Түүнчлэн компани оноосон нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлснээр түүнийг хэрэглэх онцгой эрхтэй болно. Компани улсын бүртгэлд бүртгүүлэх, нэр олгох, баталгаажуулах журмыг "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай" Монгол Улсын хуулиар тодорхойлжээ.⁶ Түүнчлэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталсан хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам мөрдөгдөнө. (4.5) Иргэний хуульд мөн хуулийн этгээд нэрээ хуульд заасан журмын дагуу бүртгүүлэхээр заасан байдаг. (ИХ 27.5)

Компанийн нэрээ хэрэглэх онцгой эрх. Компани оноосон нэрээ улсын бүртгэлд бүртгүүлснээр тухайн нэрээр үйл ажиллагаа явуулах, компанийн дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулах, зорилгоо хэрэгжүүлэхийн тулд эдлэх эрх, үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Компани өөрийн оноосон нэрээ хуульд заасан журмын дагуу чөлөөтэй хэрэглэх онцгой эрхийг эдэлдэг. Компанийн оноосон нэрийг бусад хуулийн этгээд хууль бусаар ашиглахыг Иргэний хуулиар хориглодог.

⁶ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай (шинэчилсэн найруулга) Монгол улсын хууль 2015.01.29-ний өдөр батлагдсан.

Хэрэв компанийн оноосон нэрийг хууль бусаар ашигласан тохиолдолд тухайн компанид учруулсан гэм хорыг нөхөн төлөх эрх зүйн хариуцлага хүлээнэ.

Түүнчлэн компанийн оноосон нэрийг хууль бусаар ашигласны улмаас өөр бусад этгээдэд хохирол учруулсан бол гэм хорыг нэгэн адил арилгах үүрэг бий болно. Компанийн нэрийг хууль бусаар ашигласны улмаас гэм хор учруулсанд хариуцлага хүлээх үндэслэлийг Иргэний хуулийн 497 дугаар зүйлд тодорхойлсон гэж хэлж болно.

Энд зааснаар бол компанийн нэр хууль бусаар ашиглах санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэг хүлээнэ. Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцна. Энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээдээс гадна түүнийг уруу татсан, дэмжсэн, тусалсан, гэм хор учруулсаны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээх эрх зүйн үр дагавар бий болно.

Компанийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалах. Компанийн нэр, ажил хэргийн нэр хүнд иргэний эрх зүйгээр хамгаалагдсан байдаг. Хуулийн этгээд болон компанийн нэр, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу иргэний нэгэн адил түүнийг няцаах, бий болсон үр дагаврыг хариуцах, учирсан гэм хорыг арилгах үндэслэл бий болно.

Компани оноосон нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлэх, түүнийг

хэрэглэх онцгой эрх эдлэх нь дээр дурдсан ойлголтуудтай шууд уялдана. Компанийн өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байж болно. Эдгээр нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэнээр өөрөө эзэмших, ашиглах онцгой эрхийг бий болгоно.

Барааны тэмдэг. “Барааны тэмдэг” гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх, ялгагдах чадвартай илэрхийллийг хэлдэг. Барааны тэмдэг нь үг, дүрс, үсэг, тоо гурван хэмжээний дүрс, өнгө, дуу авиа, үнэр, тэдгээрийг хосолсон хэлбэрээр илэрхийлэгдэж болно.

Компани бараа, үйлчилгээний тэмдэг, газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах, барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, газар зүйн заалтыг ашиглахтай холбогдсон харилцааг “Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай” Монгол улсын хуулиар зохицуулагдана⁷.

Компанийн ерөнхий захиргаа. Компанийн тухай хуульд Компанийн ерөнхий захиргаа байгаа газар, түүний оршин байгаа газар, шуудангийн хаяг тодорхойлогдоно. (10.4) гэж заасан байна.

Иргэний хуульд хуулийн этгээдийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ гэж тодорхойлогджээ.

⁷ Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай (шинэчилсэн найруулга) Монгол улсын хууль (2010.06.10-ны өдрийн)-ийг үзэх

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг, хэрэв байнгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээд (компани)-ийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлд тусгагдана, түүний бүртгэлийн баримт бичигт авагдана.

Компанийн тухай хуульд “Компанийн удирдлага” гэсэн ойлголтод хувьцаа эзэмшигчдийн хурал, хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байхаар зохицуулсан.

Улмаар компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан кохион байгуулах эрх, үүрэг гүйцэтгэх удирдлагатай байна. Тэгэхээр компанийн өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлж, байнгын үйл ажиллагаатай гүйцэтгэх удирдлага, мөн ТУЗ-ыг оруулан “Компанийн ерөнхий захиргаа” гэсэн ойлголтод хамааруулан ойлгож болох юм. Компанийн ерөнхий захиргааы гол үндсэн шинж бол компанийг үйл ажиллагааг эрхлэн удирдах байнгын ажиллагаагаар тодорхойлогдоно. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ үйл ажиллагаагаа эрхлэн явуулах албан ажлын байр байгаа газар бол компанийн оршин байгаа газар болно.

Компанид хаягласан шуудангийн илгээмжийг шуудангийн сүлжээ⁸ ашиглан түүнд хүргэх газрыг шуудангийн

⁸ Уг ойлголтыг нарийвчлан үзэх бол Шуудангийн тухай Монгол улсын хуулиас үзэж болно. 2003.05.15-ны өдөр батлагдсан.

хаяг гэнэ. Орчин үед шуудангаар үйлчлүүлэгч салбар, цэгийн байршлыг “шуудангийн код”-той болгож үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх болжээ. Компанийн хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагад бүртгүүлнэ. Компанийн хаяг гэдэгт компанийн оршин байгаа газар, шуудангийн хаяг хамаарах бөгөөд өөрчлөгдсөн тохиолдолд тухайн өөрчлөлтийг компанийн ерөнхий захиргаа, гүйцэтгэх удирдлага улсын бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй. Өөрчлөлтийг бүртгүүлэхдээ хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ (Компанийн тухай хуулийн 10.5, Бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийг тус тус үзэх).

Гуравдугаар бүлэг. Компани байгуулах

11 дүгээр зүйл. Компани байгуулах

11.1 Компанийг шинээр, эсхүл хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах /нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ замаар байгуулж болно.

11.2 Компанийг хувьчлах замаар үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчийн үүргийг төр хүлээх бөгөөд хувьцааг худалдах, шилжүүлэх ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

ТАЙЛБАР

Компани нь бизнесийн эрх зүйн хамгийн голлох субъект буюу бизнесийг өргөн хүрээнд хийх боломжийг олгодог хуулийн этгээд юм. Компанийг Монгол улсад хууль тогтоомжид заасны дагуу үүсгэн байгуулж болох ба компанийн үйл ажиллагаа бизнес эрхлэх зорилгоор хуулиар хориглосноос бусад ямар ч түвшинд хэрэгжих боломжтой байдаг.



Компани байгуулах нийтлэг үндэслэлийг энэ зүйлд тусгажээ.

Үүнд:

1. Компанийг шинээр байгуулах (энэ талаар хуулийн 13 дугаар зүйлийн тайлбараас үзэх)
2. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар компани байгуулах (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх) энэ талаар хуулийн дөрөвдүгээр бүлгийн тайлбараас үзэх.
3. Компанийг хувьчлах замаар үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчийн үүргийг төр хүлээнэ. Манай улсад БНМАУ-ын өмч хувьчлах тухай хууль 1991 оны 05 дугаар сарын 22-нд батлагджээ. Энэ хуулиар БНМАУ-ын төрийн өмчид байгаа эд хөрөнгийн тодорхой хэсгийг иргэд болон хуульд заасан хуулийн этгээдийн өмчид шилжүүлэх (хувьчлах)-тэй холбоотой харилцааг зохицуулах, улмаар хөдөө аж ахуйн нэгдлийн өмчийг хувьчлах зарчмын онцлогийг тодорхойлжээ.

Хувьчлах зарчим нь өмч хувьчлахдаа ил тод, төр олон нийтийн хяналттай байх, хувьчлагдаж байгаа үйлдвэрийн газар байгууллагын ажилтан, үйлдвэрийн газар, байгууллагынхаа хувьцаа, эд хөрөнгийг шилжүүлэн авах талаар давуу эрх эдлэх зарчмыг удирдлага болгохоор хуульчилж байжээ. Түүнчлэн төрийн хувьчлагдах эд хөрөнгийг иргэн бүр хуульд заасан арга хэлбэрийн дагуу өмчлөх адил тэгш эрхтэй байхаар тогтоосон байв. Гадаадын иргэн харьяалалгүй хүмүүс төрийн өмчийн эд

хөрөнгийг гагцхүү үнэ төлбөртэйгөөр хувьд шилжүүлэхэд /худалдах, барьцаалах зэрэг хуульд заасан бусад үндэслэлээр/ өмчлөгч болон оролцож болно.

Өмч хувьчлалын ажлыг улсын хэмжээнд Засгийн газар, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжид АДХ-ын хурал, түүний гүйцэтгэх захиргаа нэгдсэн удирдлагаар хангаж, улсын хяналт шалтгалтыг хэрэгжүүлж байжээ. Энэ үеэс Монголд компаниуд үүсч хөгжсөн байх бөгөөд өмч хувьчлах замаар компанийг үүсгэн байгуулж байсан түүхэн зурвас үеийн эрх зүйн зохицуулалтыг цухас дурдав.

Харин компанийн хуулийн 11.2-ийн заалтад "Компанийг хувьчлах" замаар үүсгэн байгуулах тохиолдолд төр үүсгэн байгуулагчийн үүргийг хүлээх, улмаар хувьцааг худалдах, шилжүүлэх ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлэхээр тогтоожээ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай Монгол улсын хууль 1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлагдан гарснаар төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах ойлголт, хувьчлалын хөтөлбөрийн талаар заажээ.

Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан арга хэлбэр, нөхцөлийн дагуу хувийн өмчид шилжүүлэхийг төрийн өмчийг хувьчлах гэнэ.

"Компанийг хувьчлах замаар үүсгэн байгуулах" үүсгэн байгуулагчийн үүргийг төр хүлээж тухайн компанийн хуулийн

зохицуулалт нь төрийн өмчийг хувьчлах аргатай шууд уялдаатай гэж ойлгож болно. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд “Компанийг хувьчлах замаар үүсгэн байгуулах арга зүйг тодорхойлохдоо:

1. Дуудлагаар худалдах.
2. Уралдаант шалгаруулалт /төсөл сонгон шалгаруулах/.
3. Төрийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг худалдах.
4. Төрийн өмчит хуулийн этгээдийг хамтарсан хэлбэрээр өөрчлөн байгуулах.
5. Татан буулгах замаар эд хөрөнгийг хувьчлах.
6. Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
7. Давуу эрхтэй тусгай төрлийн хувьцаа гаргах
8. Төсвийн санхүүжилтийг төлсөн хэмжээгээр төрийн эзэмшлийг тодорхой хувиар буруулах аргаар хувьчлах.

Эдгээр аргыг дангаар буюу хослуулан хэрэглэж болно. Аль ч аргыг хэрэглэсэн хувьчлахад бэлтгэх, хувьчлах хөрөнгийн талаар мэдээлэх, хувьчлах эд хөрөнгийг үнэлэх үйл ажиллагаа маш чухал ач холбогдолтой бөгөөд ялангуяа хувьчилсан эд хөрөнгийн үнийн асуудлаар маргаан гарсан тохиолдолд “Компанийн үүсгэн байгуулагчийн үүргийг төр хүлээх” гол нөхцөлийг тодорхойлно.

Хувьцаат компанийг үүсгэн байгуулах, өөрчлөх. 1990 оны нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлт, шинэчлэлттэй холбоотойгоор төрийн мэдэлд байсан аж ахуй нэгжүүдийг хувьчлахдаа

уг байгууллагын өмчийг тодорхой тооны хувьцаанд хувааж, улмаар хувьчилсан нь хувьцаат компани үүсэх үндсэн нөхцөл болно. Мөн шинээр үүсгэн байгуулагдаж буй компаниуд ч өөрийн хувьцаагаа нийтэд чөлөөтэй арилжаалдаг хэлбэртэйгээр ч байгуулагдаж болно. Гэхдээ хувьцаат компани нь ихэвчлан томоохон аж ахуйд яригддаг бас хүндрэлтэй байдаг.

Иймд өнөө үед ХК байгуулах бус ХХК буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах нь түгээмэл байна. ХХК нь хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хаалттай буюу ХХК компани гэдэг.

Хязгаарлагдмал хариуцлагатай буюу хаалттай компани өөрийн хувьцааг үүсгэн байгуулагчид болон хаалттай захиалгын үндсэн дээр борлуулдаг. Ийм учраас оролцогчдын тоо өөрийн хөрөнгийн хэмжээ нь хязгаарлагдмал байдаг. Мөн тайлан балансыг нийтэд мэдээллэж хэвлэх шаардлага байдаггүй. Үүсгэн байгуулагчдын тоо 50-аас илүүгүй байна. Харин үүсгэн байгуулсаны дараа хувьцаа эзэмшигчдийн тоог хязгаарладаггүй.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаа, тэдгээрийг худалдаж авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргана. ХК болон ХХК нь ашгийн төлөө хуулийн этгээдийн зохион байгуулалт- эрх зүйн онцлог төрлүүд бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааны эрх

зүйн зохицуулалт нь ялгаатай боловч олон талаар адил төстэй байна.

Хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани дараах онцлог ялгаатай.

1. ХК нь хувьцаа эзэмшигчдийн тоог компанийн дүрмээр хязгаарладаггүй бол ХХК үүсгэн байгуулагчдын тоо хязгаартай байдаг.
2. ХК нь өөрийн хөрөнгө бүхий хувьцаанаас бүрддэг ба хувьцаа эзэмшигч өөрийн хувьцаагаа чөлөөтэй зарцуулах эрхтэй бол ХХК-ийн гишүүд/хувьцаа эзэмшигч/-дэд ийм эрх байдаггүй бөгөөд үүнийгээ дүрмээрээ хязгаарлаж болдог.
3. Үүсгэн байгуулагдах хэлбэрээрээ ялгаатай.

ХК нь төрийн өмчийг хувьчлах болон энгийн аргаар байгуулагддаг бол ХК нь анхнаасаа хувийн өмчид тулгуурлаж байгуулагддагаараа ялгаатай. Харин адил төстэй гол шинж бол хоёул ашиг олох эцсийн зорилготой. Монгол улсад байгаа ХК-иудын ихэнх нь төрийн өмчийг хувьчилсны үр дүнд бий болсон байна. ХК үүсгэн байгуулагчдын шийдвэрээр үүсгэн байгуулагдах бөгөөд тэдний хуульд нийцүүлж баталсан дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулдаг. Хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах компани нь холбогдох эрх бүхий байгууллагаас бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна. Хугацааны хувьд компанийг дүрэмд өөрөөр заагаагүй бол тодорхой бус хугацаатайгаар байгуулна. Компани нь заавал хуулийн

этгээд болох тул оноосон нэр, бэлгэдэл, барааны тэмдэгтэй байна. Компани оршин байх газар, шуудангийн хаягийг түүний тэргүүлэх байгууллагын оршин байгаа газраар тодорхойлно. Компани нь салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй байна.

Компанийг:

1. Шинээр үүсгэн байгуулах
2. Өөрчлөн байгуулах гэсэн хэлбэрээр байгуулна.

Компанийг үүсгэн байгуулагч нь: Монгол улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн байж болох бөгөөд эдгээр нь мөн компаниас гаргасан хувьцааны эзэмшигч байж болдог. Компанийг үүсгэн байгуулагч нь тухайн компанийн хувьцаа эзэмшигч байх албагүй байна.

Хуульд заасан бол төр, түүний байгууллага нь: Компанийн үүсгэн байгуулах боломжтой байх ба компанийн үүсгэн байгуулагч байж болох юм.

Компанийг үүсгэн байгуулагчдын боловсруулсан төслийг нийтэд санал болгож хувьцааны захиалга авах, эсхүл хязгаарлагдмал хүрээнд цөөн тооны этгээдээс захиалга авч, шинээр үүсгэн байгуулагддаг.

А. Иргэний хуульд зааснаар **хуулийн этгээд** нь өөрийн **нэртэй** байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлтэрийг тусгасан байна. Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил төстэй байж болохгүй. Жишээлбэл:

Монгол транс ХХК-ийн зэрэгцээ МГЛ транс ХХК гэсэн нэртэй компани буй болсон нь бусдыг төөрөгдүүлэхээр шинжтэй байна гэж шүүхэд гомдол гаргажээ. Шүүх. МГЛ (MGL)- транс ХХК компанийн нэр нь англи хэлээрх товчлон бичсэн гэж тайлбарласан, хууль зөрчөөгүй гэж үзжээ.

Хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хориглодог. Хуулийн этгээдийн нэрийг хууль бусаар ашиглавал гэм хорыг арилгах үүрэг хүлээнэ. **Хуулийн этгээд** (фирм) **-ийн нэр** гэдэг нь зохих журмын дагуу байгуулагдсан хуулийн этгээд өөрийн үйл ажиллагаа явуулахад ашиглах оноосон бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлсэн нэрийг хэлдэг. Ийм учраас тухайн аж ахуй нэгжийн нэр нь түүний ажил хэргийн нэр хүнд, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоотой. Тухайн хуулийн этгээд өөрийн нэрээр гэрээ, хэлцэл хийх зэргээр хууль цаазын ач холбогдол бүхий үйлдлийг гүйцэтгэж эрх эдэлж, үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээж, реклам сурталчилгаагаа явуулж, бүтээгдэхүүнээ борлуулж ажил үйлчилгээ гүйцэтгэдэг. Ийм учраас аж ахуй нэгж өөрийн нэрээр түншлэгчдийнхээ өмнө итгэл хүндэтгэл олж, нийгэмд нэрд гарч хүлээн зөвшөөрөгддөг. Ийнхүү хуулийн этгээдийн нэр нь тухайн аж ахуй нэгжийн чухал эдийн бус баялгийн эрх мөн.

Компанийг байгуулахдаа: Үүсгэх аргаар нь нээлттэй ба хаалттай гэж ангилдаг.

Компанийн үүсгэн байгуулагчдын төслийг нийтэд санал болгож хувьцааны захиалга авах, эсхүл хязгаарлагдмал

хүрээнд цөөн тооны этгээдээс захиалга авч шинээр үүсгэн байгуулагддаг.

Төсөлд дараах зүйлийг тусгасан байх ёстой.

- Эрхлэх үйл ажиллагааны чиглэл
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн төвлөрсөн хэмжээ
- Зарлах хувьцааны тоо нэрлэсэн үнэ
- Шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаа явуулах хугацаа
- Төлөвлөсөн ашгийн хэмжээ
- Захиалга эхлэх дуусах хугацаа зэргийг тусгана.

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг үүсгэн байгуулахад хувьцааны захиалга хаалттай авах замаар шууд байгуулагддаг бөгөөд хувьцааны төлбөр хийгдсэн үнийн дүн нь хуулиар тогтоосон өөрийн хөрөнгийн доод хэмжээнд хүрсэн байх ёстой.

Өөрийн хөрөнгө: Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн өр төлбөрийг хасаад үлдсэн хөрөнгийг хэлдэг.

Компанийг бүртгэх өдөр ХК 10 сая төгрөг, ХХК 1 сая төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байх ёстой. Хувьцаат компани ХХК-иас ялгаатай нэг зохицуулалт бол компанийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаас гадна үнэт цаасны хороо, хөрөнгийн биржид бүртгүүлэхтэй холбогдсон журмууд давхар үйлчилнэ.

Харин ХХК-д эдгээр шаардлагууд тавигдахгүй ба компанийн хууль бусад хууль тогтоомжийн хүрээнд л ажиллах шаардлагатай. Компанийг үүсгэн

байгуулахад тавигдах гол шаардлага бол үүсгэн байгуулах эрх зүйн баримт бичиг юм. Үүнд: Компанийг үүсгэн байгуулах тухай хурлын шийдвэр, компанийн дүрэм орно. Компанийн дүрэм компанийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг юм.

Компанийн дүрэмд дараах зүйлийг тусгана.

- Компанийн бүрэн болон товчилсон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ
- Компанийн оршин байгаа газар, хаяг
- Компанийн зарласан энгийн хувьцааны нэрлэсэн үнэ
- Компанийн үйл ажиллагааны чиглэл
- Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ
- ТУЗ байх бол гишүүдийн тоо /ХХК-д хамаарна/
- ХЭХ, ТУЗ, хяналтын зөвлөлийн эрхийг тус тус тусгасан байна.

Компани дараах хэлбэрээр санхүүжинэ.

Компанийг үүсгэн байгуулахад гишүүдийн оруулсан хувь хөрөнгө болон түүнд орсон гишүүний хувь хөрөнгө

- Хуваарилагдаагүй ашиг
- Зээлдэгчээс урьдчилан авсан зээл орох бөгөөд зээлээр ашиг үйлчилгээ барааг бэлтгэн нийлүүлсэн

Өөрийн хөрөнгө нь бизнес эрхлэгчдэд дараах боломжуудыг өгнө.

- Аж ахуйн эрхлэх суурь хөрөнгө болно.
- Баталгаа болно.

Компанийн хөрөнгө хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн үндсэн дээр бүрдэх бөгөөд дараах хэлбэрээр хөрөнгө оруулна.

- Мөнгөн хөрөнгө
- Эд хөрөнгө
- Оюуны өмч хэлбэрээр хөрөнгө оруулж болно. Энэ нь нөхөрлөлийн ажиллах хүчээрээ хөрөнгө оруулах ойголтоос арай ялгаатай.

Компани дараах давуу болон сул талтай.

Давуу тал нь: Хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг учир бусад өмч хамгаалагдана гэсэн үг.

Компанийг удирдах бүрэлдэхүүн анх үүсгэн байгуулсан этгээд өөрчлөгдсөн ч компани татан буугдах үндэслэл болохгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг.

Компани нь: Хувьцаа гаргах замаар олон тооны хөрөнгө оруулагчдыг өөртөө багтааж, ингэснээрээ өргөн хүрээнд бизнес хийх боломжийг олгодог.

Сул тал нь: Хөрөнгө оруулагч нар өмчлөлөөсөө холддог. Өөрөөр хэлбэл, ХК-ийн жижиг хөрөнгө оруулагч нар компанийн үйл ажиллагаанд байнга оролцох боломжгүй бсддог. Компанийг байгуулах татан буулгах түүнийг удирдах удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг олон асуудлаар төрийн зүгээс зохицуулалт ихтэй байдаг нь компанийн сул тал ом.

Хараат болон охин компани

Компанийн нийт хувьцааны 20-51 хувийг өөр толгой компани дангаараа буюу өөр нэгдмэл сонирхолтой этгээд

эзэмшиж байвал уг компанийг хараат компани гэнэ. Тухайн компанийн хувьцааг эзэмшиж байгаа компанийг толгой компани гэнэ. Компанийн нийт энгийн хувьцааны 51-100 хувийг өөр толгой компани дангаараа эзэмшдэг бол түүнийг охин компани гэнэ. Хараат болон охин компаниуд бүгд хуулийн этгээдийн эрхийг эдэлдэг. Харин хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газар хуулийн этгээдийн эрхгүй байна. 1994 оны Иргэний хуулийг хуулийн этгээдийн салбар нь хуулийн этгээдийн эрхтэй бие даасан аж ахуйн хэлбэртэй байсан бол 2002 оны Иргэний хуулиар хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газар нь Хуулийн этгээдийн эрхгүй байхаар зохицуулсан .

Нөхөрлөл, компани, ялгаатай болон төсөөтэй талууд Нөхөрлөл, компанийн төсөөтэй зохицуулалт бол хёул ашиг орлого олох зорилго, чиглэлтэй, тодорхой зохион байгуулалтад ордог байна.

Харинялгаатай тал нь: Нөхөрлөл компани нь бүтэц, зохион байгуулалтын хувьд өөр өөр байна. Тухайлбал, нөхөрлөлд зарим гишүүд бүрэн хариуцлага хүлээдэг, бүх гишүүд хариуцлага хүлээдэг зэргээс шалтгаалан үүсэх болон дуусгавар болдог бол компанид ийм зохицуулалт үйлчилдэггүй. Компанийн өөрийн хөрөнгө компанийн дүрмийн сангаар хэмжигддэг.

- Компани нь гишүүдийн оруулсан хөрөнгийг хувьцаагаар үнэлдэг бол нөхөрлөлд энэ шаардлага тавигддаггүй.
- компанид хөрөнгө оруулагч нь:

Мөнгө, эд хөрөнгө, оюуны үнэт зүйл оруулдаг бол нөхөрлөлд дээрх зүйлүүдээр хөрөнгө оруулахаас гадна ажиллах хүчээрээ хөрөнгө оруулж болдог. Компани нь арай илүү өргөн хүрээнд олон хүнийг хамарсан үйл ажиллагаа явуулдагаараа нөхөрлөлөөс ялгаатай байна.

12 дугаар зүйл. Компанийн үүсгэн байгуулагч

12.1 Компанийн үүсгэн байгуулагч нь Монгол улсын иргэн, хуулийн этгээд, хуульд заасан бол гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн байж болно.

12.2 Компаниас гаргасан хувьцааг Монгол улсын болон гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн эзэмшиж болно.

12.3 Компани нэг үүсгэн байгуулагчтай байж болно.

12.4 Компанийн үүсгэн байгуулагч нь тухайн компанийн хувьцааг эзэмшихгүй байж болно.

12.5 Төр, түүний байгууллага нь дараах тохиолдолд компанийн үүсгэн байгуулагч нь болон түүний хувьцаа эзэмшигч байж болно.

12.5.1 Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон компанийн

12.5.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах

- замаар үүссэн төрийн өмчит компанийн
- 12.5.3 Хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар нь сольж авсан компанийн/ энэ тохиолдолд төр тухайн хувьцааг гурван жилийн дотор бусад этгээдэд худалдах үүрэгтэй. /
- 12.5.4 Гадаад улсын хуулийн этгээдтэй хамтран байгуулсан компанийн
- 12.5.5 Хуульд заасан бусад
- 12.6 Компанийг үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг компанийн үүсгэн байгуулагчид хамтран хариуцна.
- 12.7 Компани үүсгэн байгуулах хурлын буюу төлөөлөн удирдах зөвлөл /хэрэв нэг үүсгэн байгуулагчтай бол үүсгэн байгуулагч/-ийн шийдвэрээр энэ хуулийн 12.6-д заасан зардлыг компани хариуцаж болно.
- 12.8 Энэ хуулийн 12.6, 12.7-д заасны дагуу компанийг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг төлсөн этгээд нь бусад үүсгэн байгуулагч, түүний эзэмшиж байгаа болон эзэмшихээр захиалсан хувьцааны тоотой нь хувь тэнцүүлэн уг зардлыг компани нэхэмжлэн авах,
- эсхүл гаргасан зардлынхаа хэмжээнд хувьцаа эзэмших эрхтэй.
- 12.9 Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь бусад компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байж болно.

ТАЙЛБАР

Компанийн үүсгэн байгуулагч.

Энэ ойлголтын эрх зүйн шинжийг тодорхойлох, агуулгыг тайлбарлах талаар эрх зүйн тайлбар толь бичгүүдэд зохих ёсоор тусгагдсан байна. Тухайлбал, “Эрх зүйн эх толь бичигт компани үүсгэн байгуулагч этгээдүүдийг нэрлэн заах байдлаар товч тайлбарласан”.

“Иргэний эрх зүй” тайлбар тольд “Компанийн үүсгэн байгуулагч Монгол улсын иргэний хуулийн этгээд, түүнчлэн хуульд заасан бол гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн байх бөгөөд бусад компанийн хувьцаа эзэмшигч байж болно.

Үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэрээр компанийг үүсгэн байгуулна. Компанийг нэг этгээд байгуулж байгаа тохиолдолд тухайн этгээд нь үүсгэн байгуулах шийдвэр гаргана. Компанийн нэг үүсгэн байгуулагчтай байж болохоос гадна уг этгээд нь тухайн компанийн хувьцааг эзэмшихгүй байж болно.

Төр, түүний байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар цинээр бий болсон компанийн, төрийн өмчит компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах

⁹ С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008 он. X-248

замаар үүссэн төрийн өмчит компанийн, хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар нь сольж авсан компанийн үүсгэн байгуулагч болон түүний хувь нийлүүлэгч байж болно¹⁰. гэж тодорхойлжээ.

Одоо дагаж мөрдөж буй компанийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн заалтуудыг эрх зүйн онол, хуулийн заалтыг тайлбарлан хэрэглэх арга зүйн талаас нь задлан шинжлэх хэрэгтэй болно. Монгол улсад компанийг Монгол улсын иргэн, хуулийн этгээд, хуульд заасан бол гадаад улсын иргэн, хуулийн этгээд байгуулж болно. Монгол улсын иргэн, хуулийн этгээдийг хүн бүхэн мэднэ, ойлгоно. Харин “хуульд заасан бол гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн” гэдэгт анхаарал хандуулах зүйтэй гэж үзэв.

Гадаадын иргэн гэж Монгол улсын иргэний харьяалалгүй хүнийг, *харьяалалгүй хүн* гэж аль ч улсын харьяат бус хүнийг томъёолон нэрлэдэг. Үүнээс гадна компани үүсгэн байгуулах компаниас гаргасан хувьцааг авч эзэмших магадлал Монгол улсад хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэн, цагаач нарт өндөр байдаг.

Эдгээр нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэсэн ойлголтод хамаарах боловч Монгол улсын хуулиар тусад нь томъёолсон байдаг.

Тухайлбал, *Түр ирэгч* гадаадын иргэн гэж Монгол улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг

хэлдэг бол *хувийн хэргээр оршиг суугч* гэж суралцах, хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, гэр бүлийн шалтгаанаар болон хувийн бусад ажлаар Монгол улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг томъёолон нэрлэдэг. *Цагаач* гэх томъёололд Монгол улсын эрх бүхий байгууллагаас цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамааруулан ойлгоно.

Түүнчлэн *албан хэргээр оршин суугч* энд бол хамаатай байж болно. Төрийн байгууллагын урилгаар болон Монгол улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, засгийн газар хоорондын эрх бүхий байгууллага, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчдийн газар, түүнчлэн гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдийн газар ажиллахаар Монгол улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг албан хэргээр оршин суугч гэнэ. Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг тухайн иргэний харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчмыг баримтлан Монгол улсын хуулиар тодорхойлно.

Гадаадын иргэний эрх, үүргийн хязгаарлалтыг тогтоож болох онцлогтой. Тухайлбал, Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэ журмыг хамгаалах зорилгоор хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд гадаадын иргэний эрх, эрх чөлөөнд хуулиар хамгаалалт тогтоож болно.


¹⁰ Б.Улаанбаатар. Иргэний эрх зүйн тайлбар толь. УБ. 2005 он

Түүнчлэн гадаадын иргэн, компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, эзэлдүүлэгч, хөрөнгө оруулагчийн аль нь байгаа ч Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг сахин биелүүлэх, Монголын ард түмний уламжлал, зан заншлыг хүндэтгэн сахих, хуульд заасан журмын дагуу 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн хийгээд, хаягийн бүртгэлд бүртгүүлэх, татварын хууль тогтоомжид заасан татвар хураамж төлөх зэрэг үүргийг сахин биелүүлнэ.

Гадаадын иргэн, (харьяалалгүй хүн адил) Монгол улсын эрх ашиг, тус улсын иргэний болон бусад хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд харш үйлдэл хийхийг хуулиар хориглодог. Мөн Монгол улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах, түүнд элсэн орох, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр аливаа улс төрийн үйл ажиллагаа явуулж болохгүй. Монгол улсын үндэсний эв нэгдлийн эсрэг сурталчилгаа явуулах, үндэсний зан заншилд хохирол учруулж болох хүмүүнлэг бус шашны урсгал, хүчирхийллийн аливаа хэлбэр, садар самуун, мансууруулах бодис сурталчлах,

түгээн дэлгэрүүлэх, хэрэглэхийг мөн хориглодог.

Мөн тэдгээр нь зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг зөвшөөрөлгүй явуулах, тус улсад оршин суух журам зөрчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхлэх, шилжин суурьшихыг хориглодог. Хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хуульд “Гадаадын хөрөнгө оруулагч” гэж гадаадын хуулийн этгээд, хувь хүн, Монгол улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн, харьяалалгүй хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол улсын иргэнийг хамааруулж томъёолжээ. Мөн хуульд “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж” гэдэгт Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх эж ахуй нэгжийг хамааруулсан байна.



Компанийн гаргасан хувьцааг эдгээр хүмүүс, хуулийн этгээд эзэмшиж болно. Хувьцааг эзэмшиж байгаа хүмүүсийг хувьцаа эзэмшигч гэж нэрлэнэ. *Хувьцаа эзэмшигч* бол компанийн хувьцааг өмчлөгч мөн¹¹.

Хуулийн 12.3, 12.4 дэх заалтад компани нэг үүсгэн байгуулагчтай байж болох тухай, 12.4 компанийн үүсгэн байгуулагч нь тухайн компанийн хувьцааг эзэмшихгүй байж болох тухай заажээ. Хуулийн 12.5 дахь заалтаар компанийн үүсгэн байгуулагч, түүний хувьцааг эзэмшигч нь төр, түүний байгууллага байж болно гэж заажээ.



1. Төрийн өмчит үйлдвэрийн газар
2. Төрийн өмчит компани
3. Дампуурч байгаа компани
4. Өрийг хувьцаагаар солих
5. Гадаад улсын хуулийн этгээдтэй хамтран байгуулсан

Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан төрийн өмчид үндэслэсэн, улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийн эд хөрөнгийн эрхийн байдлаар нь:

- a) аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
- b) улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилдаг байна.

Өөрийн эзэмшдэг эд хөрөнгийн үндсэн дээр санхүүжих зарчмаар ажилладаг,

¹¹ С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг". Хуудас 517

бие даан иргэний гүйлгээнд ордог, бусад иргэний эрх зүйн харилцаанд оролцдог хуулийн этгээдийг **аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар** гэнэ.

Өөрт ногдсон эд хөрөнгийн үндсэн дээр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулагдсан үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар** гэдэг.

Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (компани) гэж төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгө оруулсан байхыг хэлдэг. Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5.3-т хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар сольж авсан компанийн үүсгэн байгуулагч, төр, түүний байгууллага байхаар зохицуулсан нь ойлгомжгүй болсон гэж үзнэ.

“Хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа компани” гэж үзвэл дампуурлын тухай Монгол улсын хуулийн дагуу дампуурч байгаа гэж ойлгогдоно. Энэ хуулиар “төлбөрийн чадваргүйд тооцох” гэсэн эрх зүйн зохицуулалт байх бөгөөд өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлээгүй бол төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэл болно. Энэ нь шүүх дампуурлын хэрэг үүсгэх нөхцөлийг бий болгодог.

Шүүх дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл нь:

а) үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч тал дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл

гаргасан

б) хариуцагч үүргээ биелүүлж чадахгүй болсныг өөрөө мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан байж болно.

Ийнхүү нэхэмжлэл, хүсэлтэд үндэслэн шүүх дампуурлын хэрэг үүсгэж болно. Дампуурлын хэрэг үүсгэсэн тохиолдолд нэхэмжлэгчдийн хурлаар асуудал шийдвэрлэгдэх, түүнд зээлдүүлэгч нэхэмжлэгчид оролцох асуудал яригдана. Хэрэг гүйцэтгэгчдийг томилно. Харин хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх, үйл ажиллагааг нь цаашид үргэлжлүүлэх нь татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах асуудал тавигдах учиртай. Хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа компанийг энд компанийн төлөх өрийг хувьцаагаар сольж болох бөгөөд, үүнийг өрийг хувьцаагаар солих гэнэ гэж томьёолон заасан байх боловч энд хувьцаа нэмж гаргах тухай яригдана.

Хуулийн 12.5.3 дах заалтын энэ зохицуулалттай холбон ойлговол хэрэглэхэд илүү дөхөм болох боловч дампууралтай холбоотойгоор дахин хөрөнгөжүүлэх хүсэлт, төлөвлөгөөтэй холбон авч үзэх бэрхшээл гарах болно.

Компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар сольж авсан гэх ойлголтыг ердийн журмаар ойлговол тухайн хувьцааг гурван жилийн дотор бусдад худалдах үүрэгтэй байна.

Төр, гадаад улсын хуулийн этгээдтэй хамтран байгуулсан компанийн үүсгэн

байгуулагч болно. Энэ мэт хуульд заасан бусад үндэслэл байж болно.

Зардлыг хамтран хариуцна. Хуулийн 12.6 дахь заалтад компанийг үүсгэн байгуулах үйл ажиллагааны зардал, түүнийг улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдох зардлыг компанийг үүсгэн байгуулагчид хамтран хариуцахаар тогтоосон байна.

Компанийн үүсгэн байгуулагчид хамтран хариуцна гэдэг нийт зардлыг адил тэнцүү хуваан хариуцах, эсхүл хоорондоо тохиролцох замаар тэнцүү биш хуваарилах буюу хэн нэг нь хариуцан төлөх бололцоотой. Хуульд харилцан тохиролцохыг хориглоогүй. Харин компани үүсгэн байгуулах, түүнийг улсын бүртгэлд бүртгүүлэх хоёр үйл ажиллагаатай холбогдсон зардлыг компани үүсгэн байгуулагчид хамтран хариуцна гэж тогтоожээ.

Улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд Улсын бүртгэлд бүртгүүлэх, лавлагаа, мэдээлэл өгөхөд үйлчилгээний хөлс төлнө. Үйлчилгээний хөлсний хэмжээг Засгийн газар тогтооно гэжээ. Улсын тэмдэгтийн тухай хуульд /5.1 заалтад/ хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгоход тус тус хураамж авна. Хуулийн 15 дугаар зүйлд бүртгэлийн үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоосон байдаг.

Компани үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг *нэхэмжлэн авах, хувьцаа эзэмших* эрх зүйн боломжийг хуулийн 12.8 дахь заалтаар олгож байна. Тэгэхээр үүсгэн байгуулах зардлыг төлсөн этгээд нь:

а) бусад үүсгэн байгуулагчаас гарсан зардлаа нэхэмжлэн авч болно.

б) Бусад үүсгэн байгуулагчаас нэхэмжлэхдээ түүний үүсгэн байгуулсан компанийн хувьцаанаас түүний эзэмшиж байгаа болон эзэмшихээр захиалсан хувьцааны тоотой нь хувь тэнцүүлэн компани үүсгэн байгуулахтай холбогдсон, өөрийн төлсөн зардлыг нэхэмжлэн авах эрхтэй байна.

с) Компани үүсгэн байгуулахтай холбоотой зардлыг төлсөн этгээд бусад үүсгэн байгуулагчаас уг зардлыг нэхэмжлэхгүйгээр харин гарсан зардлынхаа хэмжээнд тухайн үүсгэн байгуулсан компанийн хувьцаа эзэмших эрхтэй болно.

Зардлыг компани хариуцах. Зардлыг компани хариуцах тохиолдлыг /12.7/ компанийн удирдах байгууллагаас гаргаж болно. Зардлыг компани хариуцах шийдвэрийг гаргах эрх бүхий субъект нь:

1. Компани үүсгэн байгуулах хурлын шийдвэрээр гаргана.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр зардлыг компани хариуцахаар тогтоож болно.
3. Нэг үүсгэн байгуулагчтай бол тухайн үүсгэн байгуулагчийн шийдвэрээр зардлыг компани хариуцна.

Үүсгэн байгуулах, хувьцаа эзэмшихийг хязгаарлахгүй. Компанийн тухай хуулийн 12.9 дэх заалт бол компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн бусад компанийн үйл ажиллагаанд оролцохыг хязгаарлахгүй. Хуулийн заалтад дараах агуулгыг илэрхийлж байна. Үүнд:

а) Компанийн үүсгэн байгуулагч

бусад компанийн үүсгэн байгуулагч байж болно. Бас бусад компанийн хувьцаа эзэмшигч байж болно.

- b) Компанийн хувьцаа эзэмшигч бусад компанийн үүсгэн байгуулагч байж болно. Бас тэрээр өөр бусад компанийн хувьцаа эзэмшиж болно.

13 дугаар зүйл. Шинээр компани үүсгэн байгуулах.

- 13.1 Үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэрээр компанийг үүсгэн байгуулна.
- 13.2 Компанийг нэг этгээд үүсгэн байгуулж байгаа тохиолдолд тухайн этгээд нь үүсгэн байгуулах шийдвэр гаргана.
- 13.3 Компанийг нэгээс дээш этгээд үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчид нь компани үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулж болох бөгөөд уг гэрээнд үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах журам, үүсгэн байгуулагч тус бүрийн хүлээх үүрэг, тэдгээрийн худалдан авах хувьцаа болон хувьцаа бусад үнэт цаасны ангилал, төрөл тус бүрийн тоо, үнэ, худалдан авах хугацаа зэрэг шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг тусгана.
- 13.4 Энэ хуулийн 13.3-т заасан гэрээ нь компанийг үүсгэн байгуулах баримт бичигт хамаарахгүй.
- 13.5 Цөөн тооны этгээдээс захиалга авах арга /цаашид "хаалттай захиалга" гэх/ -аар шинээр

хаалттай хувьцаат компанийг үүсгэн байгуулахад дараах журмыг баримтална.

13.5.1 хаалттай захиалгыг захиалгын хуудсаар авах бөгөөд түүнд захиалагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, захиалсан хувьцааны төрөл, ангилал, тоо, үнийн дүн, захиалсан он, сар, өдрийг тусгах бөгөөд захиалагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурснаар захиалга хийгдэнд тооцох.

13.5.2 Захиалсан нийт хувьцааны төлбөрийг захиалгын хугацаа дууссанаас хойш ажлын 30 өдрийн дотор хийх.

13.6 Тодорхой шалтгаанаар компани байгуулагдаагүй бол компани үүсгэн байгуулах хурал товлосон өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор захиалагчийн урьдчилан хийсэн төлбөрийг буцаан олгох үүргийг үүсгэн байгуулагч хүлээнэ.

ТАЙЛБАР

Шинээр компани үүсгэн байгуулах эрх зүйн үндсэн асуудлыг хуулийн энэ зүйлээр тодорхойлжээ. Компанийг үүсгэн байгуулах шийдвэрийг:

Нэгдүгээрт: Компани үүсгэн байгуулагчдын хурал гаргана.

Хоёрдугаарт: Компанийг нэг этгээд үүсгэн байгуулж байгаа тохиолдолд тухайн этгээд компани үүсгэн байгуулах шийдвэр гаргана. Тэгэхлээр компанийг нэг этгээд болон нэгээс дээш этгээд

үүсгэн байгуулж болно гэсэн ойлголт хуулийн заалтад тодорхой харагдана.

Компанийг олон этгээд үүсгэн байгуулсан тохиолдолд тэдгээр нь хүсэл зориг, санаа бодлоо нэгтгэх, нэгдмэл зорилготой болсноор компани үүсгэн байгуулагчид хамтран оролцох боломж бий болно. Тиймээс хуулийн 13.3 дахь заалтын зохицуулалтыг нэг мөр зөв ойлгон хэрэглэх шаардлагатай.

Хамтран ажиллах гэрээ. Компанийг нэгээс дээш этгээд үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчид компани үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулж болно. Компани үүсгэн байгуулах тухай хамтран ажиллах гэрээний агуулга, нөхцөлд тусгагдвал зохих үзүүлэлтүүдийг компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т тусгагдсан байна. Уг хамтран ажиллах гэрээнд:

- үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах журам
- үүсгэн байгуулагч тус бүрийн хүлээх үүрэг
- үүсгэн байгуулагчдын худалдан авах хувьцаа болон үнэт цаасны ангилал, төрөл
- худалдан авах хувьцаа, бусад үнэт цаасны ангилал тус бүрийн тоо үнэ
- худалдан авах хугацаа
- мэдээж эдгээр үзүүлэлтийг үүсгэн байгуулагч нэг бүрээр гаргана гэж ойлгогдож байна.
- шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг тусгана.

Компани үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ компани үүсгэн

байгуулах баримт бичгийг биш юм.

Компанийг үүсгэн байгуулах баримт бичиг. “Үүсгэн байгуулах баримт бичиг” гэж эрх бүхий этгээдээс гаргасан хуулийн этгээд байгуулах шийдвэр, дүрэм, хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээ хамаарна.

Тэгэхлээр компанийн үүсгэн байгуулах баримт бичигт, үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, нэг үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр нэг үүсгэн байгуулагчтай бол түүний гаргасан шийдвэр, компанийн дүрмээс хамаарч байна. Харин үүсгэн байгуулагчдын “Компани үүсгэн байгуулах тухай гэрээ” бол “хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээ”-нд хамаарахгүй тул үүсгэн байгуулах баримт бичиг гэж үзэхгүй.

Харин компани улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйл, заалтын дагуу бүрдүүлэх шаардлагатай болно. Энд “үүсгэн байгуулах баримт бичиг” буюу компанийг үүсгэн байгуулах шийдвэр, компанийн дүрэм бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийн дотор чухал суурт эзэлнэ.

Бидний дээр дурдсан компани үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ иргэний хуулийн дөчин наймдугаар бүлэгт заасан хамтран ажиллах гэрээний эрх зүйд хэрхэн хамаарах, компани үүсгэн байгуулснаас хойш гэрээгээр тохиролцсон харилцаа, үүсгэн байгуулагчдын эрх, үүрэг үргэлжлэх, эсхүл дуусгавар болгох эсэхийг судлах, магадлан тодорхойлох хэрэгцээ,

шаардлага байгаа юм.

Хаалттай хувьцаат компани: Эрх зүйн харилцаанд “хаалттай” гэсэн нэр томъёо гол төлөв “тодорхой этгээдүүдийн хүрээнд”, “хязгаарлагмал” гэх утга санааг тодорхойлдог. Жишээлбэл: “хаалттай дуудлага худалдаа”, “хаалттай сонгон шалгаруулалт”, “хаалттай хувьчлах” гэх мэт.

Хаалттай компани гэх нэр томъёог хязгаарлагдмал хариуцлагатай компани гэх ойлголтоор хэрэглэдэг бол “хувьцаат компани” нь хувьцаагаа бие даан худалдах, бусад хэлбэрээр захиран зарцуулах, бусдад чөлөөтэй шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн өмчлөх эрхэд үндэслэсэн хамтарсан хөрөнгө бүхий ашгийн төлөө зохион байгуулалтын нэгдэл байдаг. Түүнийг нээлттэй компани гэж нэрлэдэг.

Хувьцаат компанийн ба түүний хувьцаа эзэмшигчдийн эрх зүйн байдлыг тогтоосон, эрх зүйн хэм хэмжээний нийлбэрийг *хувьцаат компанийн эрх зүй хэмээн* томъёолон бичих, нэрлэх нь бас бий. Түүний зохицуулалтын зүйл нь хувьцаа эзэмшигчдийн хооронд үүссэн харилцаа юм. Энэ ойлголтын хүрээнд бол хаалттай хувьцаат компани үүсгэн байгуулах, түүний эрх зүйн зохицуулалт хамаарна. “Хаалттай хувьцаат компани” үүсгэн байгуулах тухай ойлголтын гол агуулга нь цөөн тооны этгээдээс захиалга аах замаар шинээр хувьцаат компани байгуулах явдал юм. Ийм компани байгуулахад баримтлах журмыг хуулийн 13.5.1-д заажээ. Үүнд:

Хаалттай захиалга авах. Шинээр компани үүсгэн байгуулахдаа цөөн

тооны хувьцаа эзэмшигчтэй байхын тулд хаалттай захиалга авна. Хаалттай захиалга гэдэг нь хувьцаа эзэмших захиалгыг захиалгын хуудсаар авна гэсэн үг юм. Хувьцаа эзэмших тухай захиалгын хуудсанд:

- захиалагчийн эцэг, эхийн нэр
- өөрийн нэр
- захиалсан хувьцааны төрөл, ангилал, тоо
- захиалсан хувьцааны үнийн дүн
- хувьцаа захиалсан он, сар, өдөр тус тус тусгагдана.

Захиалгын хуудасны хууль, эрх зүйн дүрэм хангагдсан байх ёстой бөгөөд түүнд захиалагч гарын үсэг зурж, баталгаажуулсан байх ёстой. Эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нар гарын үсэг зурсан байх шаардлагатай. Гарын үсэг зурснаар захиалга хийгдсэнд тооцогдоно.

Хувьцааны төлбөр: Захиалгын хуудсаар авсан хувьцааны үнийг төлснөөр хувьцаа эзэмших эрхтэй болно. Захиалсан нийт хувьцааны төлбөрийг захиалга авах хугацаа дууссанаас хойш ажлын 30 хоногийн дотор төлөх ёстой байна.

Төлбөрийг буцаан олгох. Хувьцаа захиалагчийн төлсөн хувьцааны үнэ төлбөрийг буцаан олгох тохиолдолд байж болно. Энэ нь захиалга авсан хувьцаат компани байгуулагдаагүй бол үүсгэн байгуулагчаас түүнийг буцаан олгох үүрэг бий болно. Ийнхүү буцаан олгох үүрэг нь компани үүсгэн байгуулах тухай хурал товлэгдсон өдрөөс хойш 14 өдрийн дотор захиалагчийн урьдчилан хийсэн төлбөрийг түүнд

буцаан олгох ёстой. Хуульд “тодорхой шалтгаанаар компани байгуулагдаагүй бол” үүсгэн байгуулагчийн буцаан олгох үүрэг бий болно гэж заажээ. Гэхдээ тодорхой шалтгаан гэдгийг компани байгуулагдахгүй болсон ямар ч шалтгаан хамаарах учиртай. Жишээ нь захиалагчийн тоо хүрээгүй, эсхүл үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл эрх бүхий байгууллага олдоогүй, компани байгуулагдахгүй болох ямар нэгэн нөхцөл байдал бий болох гэх мэт.

Тэгэхлээр ямар ч шалтгаантай байсан компани ямар ч нэг шалтгаантай байсан компани байгуулагдаагүй тохиолдолд захиалагчийн урьдчилан хийсэн төлбөрийг буцаан олгоно гэж хуулийн заалтыг олгож хэрэглэх нь зүйтэй юм.

14 дүгээр зүйл. Компани үүсгэн байгуулах хурал

14.1 Компани үүсгэн байгуулах хурлыг үүсгэн байгуулагчид зарлан хуралдуулна.

14.2 Компани үүсгэн байгуулагчид санал нэгтгэйгээр өөрөөр шийдвэрлээгүй бол үүсгэн үүсгэн байгуулагч бүр компани үүсгэн байгуулах хуралд саналын тэнцүү эрхтэй оролцоно.

14.3 Компани үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

14.3.1 компани байгуулах тухай;

14.3.2 компанийн дүрэм;

14.3.3 зарласан болон гаргах хувьцаа, тэдгээрээс үүсгэн байгуулагчдын худалдан

авах үнэ;

14.3.4 төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

14.3.5 компани үүсгэн байгуулахад гаргасан зардлыг нөхөн олгох журам;

14.3.6 компанид хувь нийлүүлэх хөрөнгийг бүрэн оруулж дуусгах хугацаа.

14.4 Үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх үүсгэн байгуулагч оролцсоноор компани үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болох бөгөөд уг хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргана.

14.5 Компани үүсгэн байгуулах хурлын даргыг үүсгэн байгуулагчдаас сонгоно.

14.6 Үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд санал болгож байгаа эд хөрөнгийн үнийн талаар шаардлагатай гэж үзвэл үнэлгээний байгууллага болон холбогдох мэргэжлийн шинжээчийн дүгнэлт гаргуулан санал боловсруулж, компани үүсгэн байгуулах хуралд оруулна.

14.7 Үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд эд хөрөнгийн

**үнийг компани үүсгэн
байгуулах хуралд оролцогчид
санал нэгтэй шийдэрлэнэ.**

ТАЙЛБАР

Саналын тэнцүү эрхтэй оролцох. Үүсгэн байгуулагчдаас компани үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулна. Хуулийн заалтын агуулгаас харахад үүсгэн байгуулах тухай хурлыг зарлах, хийгээд хуралдаанд адил тэгш оролцох, улмаар компани үүсгэн байгуулах хуралд *саналын тэнцүү эрхтэй* байхаар зохицуулсан байна.

Энэ байдлаас өөрөөр шийдвэрлэх тухайлбал, үүсгэн байгуулагчид үүсгэн байгуулах хурал зарлах, хуралд үүсгэн байгуулагчид саналын тэнцүү биш эрхтэй оролцох нөхцөлийг тодорхойлсон бол компани үүсгэн байгуулагчид хэлэлцэж байгаа асуудлыг *санал нэгтэй* шийдвэрлэнэ. Компани үүсгэн байгуулагчдын хэн нэг нь санал зөрсөн, өөр саналтай байсан зэрэг тохиолдолд үүсгэн байгуулах хуралд саналын тэнцүү биш эрхтэй оролцсон бол үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлтэй.

Хэлэлцэж шийдвэрлэх асуудал. Компани үүсгэн байгуулах хурлаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлын хамгийн эхэнд компани байгуулах тухай асуудал хэлэлцэж шийдвэрлэнэ.

Нэгэнт компани байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд түүний дүрмийг хэлэлцэж батлах хэрэгтэй болно. Компанийн зарласан хувьцаа, нийт гаргах хувьцаа, түүний төрөл хэлбэрийг хэлэлцэн тодорхойлох шаардлагатай. Тэдгээр хувьцаанаас

үүсгэн байгуулагчдын худалдан авах хувьцааны үнэ, тоог тогтоох асуудал зайлшгүй тавигдана.

Компанийг төлөөлөн удирдах зөвлөлтэй эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ. Төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар тогтсон бол ТУЗ-ийн хэдэн гишүүнтэй байхыг тогтоож, түүний гишүүдийг сонгож, улмаар гишүүдийн цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоож өгнө.

Компанийн үүсгэн байгуулах хурлаар хэлэлцэж шийдвэрлэвэл зохих асуудлын нэг бол үүсгэн байгуулахад гарсан зардлын хэмжээг тогтоох, тухайн зардлыг нөхөн олгох журам, арга хэлбэрийг тогтоож батлах асуудал байдаг. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д зааснаас үзэхэд компани үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг хэн, хэрхэн төлсөн, тэрээр зардлыг бусад хувьцаа үүсгэн байгуулагчийн эзэмшихээр захиалсан хувьцааны тоотой хувь тэнцүүлэн нэхэмжлэх эсэх, гарсан зардлын хэмжээнд хувьцаа эзэмших зэргийг нэг бүрчлэн хэлэлцэн шийдвэрлэж, журамлан тогтооно. Түүнчлэн хувь нийлүүлэх хөрөнгийг бүрэн оруулж дуусах хугацааг нарийвчлан тогтооно.

Хувь нийлүүлсэн хөрөнгө, захиалсан, худалдан авах хувьцааны үнийг бүрэн төлөх хугацаа бол эрх зүйн чухал үр дагавартай байдаг. Энэ нь хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх, компанийн өөрийн хөрөнгийг тодорхойлох зэрэгт ач холбогдол нь илэрхийлэгдэнэ.

Үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болох. Компани үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болох нь компанийг

байгуулсан гэж үзэх, уг хурлаас баталсан шийдвэр, дүрэм, журам хүчин төгөлдөрт тооцогдох эрх зүйн чухал ач холбогдолтой байдаг.

Компани үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болох гол үндэслэл бол бүх үүсгэн байгуулагч хуралд оролцох явдал юм. Бүх үүсгэн байгуулагч оролцоогүй бол компани үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болж чадахгүй. Үүнээс өөр нөхцөлд компани үүсгэн байгуулах хурал хурал хүчин төгөлдөр болох нөхцөлийг *үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан гэрээнд* заасан байж болно. Уг гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх үүсгэн байгуулагч оролцсоноор компани үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болох шаардлагыг хуулиар тогтоожээ.

Энэ нь үүсгэн байгуулагчдын хуралд оролцогчдын гуравны хоёр буюу 66,6 хувийн саналаар шийдвэр гаргана гэсэн үг юм.

Дийлэнх олонхи. Компани байгуулах тухай хурал хүчин төгөлдөр болохоос гадна уг хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар шийдвэр гаргана. Тэгэхлээр компани үүсгэн байгуулах хурлаас гарах шийдвэр /тогтоол / хүчин төгөлдөр байх үндэслэл нь:

- a) хуралд бүх үүсгэн байгуулагч оролцсон байх, эсхүл үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан гэрээнд тохиролцсон хувь хэмжээнд хүрсэн байх шаардлагатай.
- b) хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар шийдвэр гарсан байх, хуулийн заалтын энэ хоёр

шаардлагыг хангасан шийдвэр хүчин төгөлдөр болно.

Хурлын дарга. Компани үүсгэн байгуулах хурлыг дарга удирдан явуулна. Хурлын даргыг үүсгэн байгуулагчдаас сонгоно. Хурлын дарга сонгох ажиллагааг “хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар шийдвэр гаргана” гэсэн заалтад хамаарах ойлголт гэж болно.

Учир нь компани үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болсноор, түүнийг удирдан явуулах, гарах шийдвэрт гарын үсэг зурах, шийдвэрийн бүрдлийг хангах зэрэг эрх, үүргийг хэрэгжүүлэх, тухайн хурлаас шийдвэр гаргах, шийдвэр хүчин төгөлдөр байх явцын бүх ажиллагааг тэрээр удирдах, зохицуулах этгээд мөн гэж үзэх ёстой.

Мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх. Компани үүсгэн байгуулагчид хөрөнгө оруулалтын төлбөрийг мөнгөн хэлбэрээр, бэлэн ба бэлэн бус байдлаар хийх ёстой байдаг. Компанид үүсгэн байгуулагчдаас мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх санал гаргасан бол дараах асуудлуудыг үүсгэн байгуулагчдын хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн байх учиртай. Үүнд:

- a) Үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдлыг тодорхойлох
- b) санал болгож байгаа эд хөрөнгийн үнэ цэнийг тогтоон тодорхойлох
- c) шаардлагатай гэж үзвэл тухайн эд хөрөнгийг үнэлгээний байгууллагаар үнэлүүлэх
- d) мөн эд хөрөнгийн үнийг холбогдох мэргэжлийн шинжээчийн дүгнэлт гаргуулж болно.

Эдгээр нөхцөл байдалд тулгуурлан тодорхой санал боловсруулж компани үүсгэн байгуулах хуралд оруулсан хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

Хуулийн 14.6-д “мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдол”-ын талаар заасан боловч зөвхөн эд хөрөнгийн үнийн талаар зохицуулсан байна.

Тэгэхлээр иргэний эрх зүйд “эд хөрөнгө” гэсэн ойлголтод аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмсад хамаарах ёстой. “Хөрөнгө” гэдэг ойлголтод эд юмс, оюуны үнэт зүйлс, эд хөрөнгийн эрх хамаардаг.

Мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд хуулийн зохицуулалтын томъёолол болох “эд хөрөнгө” гэдгийг дэлгэрүүлэн “хөрөнгө” гэдгээр үүсгэн байгуулах хурлаас шийдвэрлэж болох талтай.

Гэвч ойлголтыг дэлгэрүүлэн шийдвэрлэх нь эрх зүйн хувьд бас асуудал үүсч болохыг анхаарах ёстой. Хуульд “эд хөрөнгө” гэсэн ойлголтоор тодорхойлсон болно.

Эд хөрөнгийн үнэ. Энэ нь компани үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд эд хөрөнгийн үнэтэй холбоотой зохицуулалт хуулийн 14.7 заалтад эд хөрөнгийн үнийг компани үүсгэн байгуулах хуралд оролцогчид санал нэгтэй шийдвэрлэнэ гэжээ.

Компани үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр эд хөрөнгөөр төлбөр хийх тохиолдолд тухайн эд хөрөнгийг үнэлэх, үнийн өртөгийн хэмжээг тодорхойлсон шийдвэрийг компани үүсгэн байгуулагчдын хуралд

оролцогчдын хүсэл зоригт үндэслэсэн 100 хувийн нэгдмэл саналаар гаргана. Энэ нь шийдвэр хүчин төгөлдөр байх гол үндэслэл болно.

15 дугаар зүйл. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх.

15.1 Компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө.

15.2 Компанийг бүртгэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

ТАЙЛБАР

Компани байгуулах тухай шийдвэр гэдэгт компанийг шинээр байгуулж байгаа бол үүсгэн байгуулах хурлаас гарсан шийдвэр, нэг этгээд үүсгэн байгуулж байгаа тохиолдолд тухайн этгээдийн үүсгэн байгуулах тухай шийдвэр, компанийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар байгуулсан шийдвэр, компанийг хувьчлах замаар үүсгэн байгуулсан тухай шийдвэрүүдийг тус тус хамруулан ойлгоно.

Эдгээр шийдвэр нь тухайн компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх үндэслэл болно. Компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр бүртгэх байгууллагад хүргүүлэх ёстой.

Баримт бичиг. Хуульд холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө гэж заасан байх бөгөөд энэ нь компани

байгуулах тухай шийдвэр, түүнд хамаарал бүхий баримт бичиг хамаарна. Тухайлбал, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн /шинэчлэн найруулга/ 3.1.5-д “үүсгэн байгуулах баримт бичиг” гэж эрх бүхий этгээдээс гаргасан хуулийн этгээд байгуулах тухай шийдвэр, хуулийн этгээдийн дүрэм, хуульд заасан тохиолдолд үүсгэн байгуулах гэрээг хамруулан заасан байна.

Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхийн тулд бүртгэлийн байгууллагад хуульд заасны дагуу цахим хэлбэрээр болон бичгийн хэлбэрээр бүртгэлийн байгууллагад өгч болно¹².

Компанийг улсын бүртгэлд бүртгүүлснээр иргэний эрх зүйн чадвар үүсч, түүнийг хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болдог.

Компанийн эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэх тул улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглодог. Энэ хоригийг зөрчсөний улмаас бусдад гэм хор учирсан бол буруутай этгээд уг гэм хорыг хуульд заасан журмын дагуу арилгах үүрэгтэй.

Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхийн тулд өргөдөл гаргах бөгөөд өргөдөл гаргах эрх бүхий этгээдэд гүйцэтгэх удирдлага, үүсгэн байгуулагч, итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, итгэмжлэлээр эрх

¹² Улсын бүртгэлийн үйлчилгээ авах хэлбэрийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай Монгол улсын хуулийн 6 дугаар зүйлд заан зохицуулжээ. Хууль 2015.01.29-ний өдөр батлагдсан.

олгогдсон бусад этгээд хэрэгжүүлж болно. Эдгээрийн аль нэг нь бүртгэх байгууллагад өргөдөл гаргана .

Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах баримт бичиг гэж байдаг. Энэ талаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 17 дугаар зүйлд зохицуулжээ.

Компанийг бүртгэхтэй холбогдсон харилцааг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж¹³ хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай (шинэчилсэн найруулга).

16 дугаар зүйл. Компанийн дүрэм

16.1 Компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн.

16.2 Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана.

16.2.1 компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ.

16.2.2 компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ.

16.2.3 компанийн дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх

16.2.4 хэрэв төлөөлөн удирдах

¹³ Хуулийн 2 дугаар зүйлд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийн ойлголт, хүрээг тодорхойлж Монгол улсын хуулиар зохицуулна.

зөвлөлийн гишүүдийн тоо

16.2.5 хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулийн тодорхойлсноос бусад бүрэн эрх.

16.2.6 компанийн үйл ажиллагааны чиглэл

16.2.7 компанийн дүрэмд тусгахаар тусгахаар энэ хуульд заасан бусад зүйл.

16.3 Компанийн дүрэмд Иргэний хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зүйлийг тусгаж болно.

16.4 Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг түүнд танилцуулах үүрэгтэй.

ТАЙЛБАР


Үндсэн баримт бичиг. Компанийн дүрэм бол тухайн компанийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн. Компани үүсгэн байгуулах баримт бичиг. /15 дугаар зүйлийн тайлбараас үзэх/

Компанийн дүрэм. Компани үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг. Компанийн удирдлага, зохион

байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны үндсэн асуудлуудын зэрэг компанийн дотоодын эрх зүйн зохицуулалтыг компанийн дүрмээр тогтоодог.

Компанийн дүрмийг анхлан үүсгэн байгуулагч нар боловсруулна. Үүсгэн байгуулагч нарын хурлаас хэлэлцэн батална. Түүнийг улсын бүртгэлд бүртгүүлнэ. Дүрэмд тухайн компанийн онцлог тусгагдсан байдаг. Компанийн дотоод үйл ажиллагаатай холбогдох маргааныг шүүх шийдвэрлэхдээ компанийн тухай хууль, холбогдох бусад хуулийг баримтгаад зогсохгүй уг компанийн дүрмийн заалт нотлох баримт болгон үнэлэлт өгөх замаар маргааныг хянан шийдвэрлэдэг. Компанийн дүрэмд:

- Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн байх
- хувьцаа эзэмшигч, хувь хөрөнгө нийлүүлэгчид эрх зүйн хувьд эрх тэгш байх. Аль нэг нь давуу эрх олгох ёсгүй.
- Дүрмийн заалт ойлгомжтой хоёрдмол утга илэрхийлэхгүй байх зэрэг шаардлагыг хангасан хэл зүй, найруулгын хувьд зөв бичигдэх учиртай.



Компанийн тухай хуулийн 16.2-т компанийн дүрэмд заавал тусгавал зохих зүйлүүдийг тогтоон заасан. Үүнд:

1. Компанийн оноосон нэрийг бүрэн бичвэрээр нь бичнэ. Тухайлбал, Монголын алт компани "Хүннү Говь-Алтай" ХХК англи хэлээр "Hunnu GobiAltai" LLC, "APU", "МАК" гэх мэт.

Тухайн компанийн хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээг тухайлбал, хувьцаат компани (ХК), хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) зэргийг тодорхой тусгана.

2. Компанийн зарласан, гаргасан хувьцааны тус тусын тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус тусад дүрэмд тусгана.

Компанийн зарласан хувьцаа. Компаниас гаргах энгийн болон давуу эрхийн хувьцааны тоог үүсгэн байгуулагчдын компани байгуулах тухай хурал, хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоож, компанийн дүрэмд заах бөгөөд түүнийг зарласан хувьцаа гэнэ.

Компанийн гаргасан хувьцаа. Компанийн зарласан хувьцаанаас

хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн хэсгийг гаргасан хувьцаа гэнэ. Түүнийг бас эргэлтэд гаргасан хувьцаа гэж нэрлэж бичдэг. Дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй хувьцааг тухайн үнээс хямд үнээр гаргахыг хориглодог.

Хувь нийлүүлсэн хөрөнгө. Компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг хувь нийлүүлсэн хөрөнгө гэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан хувьцаа, компанийн эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа тус тус хамаарахгүй.

Хувьцааны төрөл. Компанийн хувьцаа нь энгийн ба давуу эрхийн гэсэн төрөлтэй байна. Эдгээр төрлийн хувьцаа нь тухайн компанид хөрөнгө оруулсан, түүнд үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компани татан буугдсаны дараа үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилнэ.

Давуу эрхийн хувьцааг зарлах. Компани давуу эрхийн хувьцаатай байх тухай асуудлыг компанийн дүрмээр тодорхойлно. Компани давуу эрхийн хувьцаатай байхаар дүрэмд тусгахыг хуульд "давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд" хэмээн томъёолжээ.

Ийнхүү давуу эрхийн хувьцаа зарласан нөхцөлд

- а) Давуу эрхийн хувьцааны зарласан тоо
- б) Давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг тус тус хамааруулах тул дүрэмд тодорхой тусгагдах зайлшгүй

шаардлагыг заан тогтоосон байна.

3. "Компанийн дүрэмд төлөөлөн удирдах зөвлөлтэй байх эсэхийг заавал тусгана. Хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар дүрэмд заасан бол тус зөвлөлийн гишүүний тоог дүрмээр тогтоон заана.

4. *Бусад бүрэн эрх.* "Бусад бүрэн эрх" гэсэн ойлголт хуулийн 16.2.5-д тусгагджээ. Энэ ойлголтод:

- а) Хувьцаа эзэмшигчдийн хурлын бусад бүрэн эрх
- б) төлөөлөн удирдах зөвлөлийн бусад бүрэн эрх гэсэн хоёр хэсэгт тус тусад компанийн дүрэмд тусгагдах ёстой гэж үзнэ.

Тэгэхлээр хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн "бусад бүрэн эрх" гэдэгт компанийн хуулиар заан тодорхойлсноос бусад бүрэн эрхийг дүрэмдээ тусгасан байхыг хамааруулан ойлгоно. Жишээ нь: Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.8.1-д энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаа эзэмшигчид ТУЗ-д өөрийн төлөөлөгчийг оруулж болохоор компанийн дүрэмд зааж болно.

Энэ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бусад бүрэн эрхэд хамаарах асуудал гэж үзэж болно.

5. *Компанийн үйл ажиллагааны чиглэл.* Компани ямар үйл ажиллагаа явуулах чиглэлийг компанийн дүрмээр тодорхойлно. Улмаар компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдэнэ. Жишээ нь: Компанийн дүрэмд үйл ажиллагааны чиглэл дараах байдлаар

дурдагдсан байна.

4.1 Компани нь дор дурдсан төрлийн үйл ажиллагаа явуулна.

- а) Гадаад худалдаа
- б) ашигт малтмалын хайгуул
- с) ашигт малтмалын ашиглалт

4.2 Компани нь бизнесийн бусад үйл ажиллагааг төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлын зөвшөөрөлтэйгөөр холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэх замаар эрхэлж болно” гэжээ.

6. *Хуульд заасан бусад зүйл.* гэдэг хуулийн 16 дугаар зүйлд тусгагдаагүй боловч хуулийн бусад зүйл заалтаар компани компанийн дүрэмд заавал тусгахаар заасан байхыг хэлнэ. Жишээ нь: “Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна”.¹⁴

Компанийн дүрэмд компанийн үйл ажиллагаа, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхтэй холбоотой ямар ч асуудлыг тусгаж болно. Гэхдээ компанийн дүрэм Монгол улсын хуульд нийцсэн, Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хууль, бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байх учиртай. Бүхэлд нь томъёолбол:

- а) Компанийн дүрэмд заавал тусгах зүйл /16.2/
- б) Компанийн дүрэмд тусгахаар компанийн тухай хуулийн бусад зүйлд заасан асуудлууд
- с) Иргэний хууль болон бусад хууль

¹⁴ Компанийн тухай Монгол улсын хуулийн 84 дүгээр зүйл. 84.2 дахь заалт.

тогтоомжтой зөрчилдөөгүй бусад зүйлүүд гэсэн үндсэн хэсгүүдийг компанийн дүрэм тусгах ёстой гэж ойлгож болох юм.

Компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, компанийн хувьцаа эзэмшигчдэд нээлттэй ил тод байх учиртай. Хувьцаа эзэмшигчид дүрэмд заасан эрхээ хэрэгжүүлж, үүргээ биелүүлж байх асуудал тухайн компанийн дүрмээр тавигдах гол шаардлагын нэг байдаг. Тиймээс хувьцаа эзэмшигчид компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг цаг тухайд нь мэдэж байх нь чухал ач холбогдолтой.

Энэ нь бас хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаа, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтны хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих бололцоо нөхцөлийг бүрдүүлнэ. Тиймээс хувьцаа эзэмшигч хэн боловч компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлттэй танилцахыг шаардах эрхтэй.

Хувьцаа эзэмшигч ийнхүү шаардсан тохиолдолд дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг түүнд танилцуулах үүрэгтэй.

17 дугаар зүйл. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, бүртгэх

17.1 Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын

- эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална.
- 17.2 Компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт, компанийн дүрмийн шинэчилсэн найруулга нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндсөн тохиолдолд эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч энэ хуулийн 53,54 дүгээр зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.
- 17.3 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.
- 17.3.1 Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэх тухай компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий өргөдөл
- 17.3.2 компанийн дүрэмд орж байгаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг бүрэн эрхийн хамтаар
- 17.3.3 бүртгэлийн хураамж төлсөн баримт.
- 17.4 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тухайн шийдвэр гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- 17.5 Бүртгэх байгууллага энэ хуулийн 17.3-т заасан баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын хоёр өдрийн дотор компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзсан үндэслэл бүхий шийдвэр гаргана. /энэ хэсэгт 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./
- 17.6 Энэ хуулийн 17.3-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд бүртгэх байгууллага компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэхээс татгалзана.
- 17.7 Бүртгэх байгууллага энэ хуулийн 17.6-д заасны дагуу бүртгэхээс татгалзсан бол энэ тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын хоёр өдрийн дотор татгалзсан үндэслэлээ тусгасан мэдэгдлийг өргөдөлд заасан шуудангийн хаягаар илгээнэ.
- 17.8 Энэ хуулийн 17.6-д заасан бүртгэх байгууллагын гаргасан шийдвэрийг компани эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.
- 17.9 Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн

найруулсан дүрэм нь улсын бүртгэлд бүртгэснээр хүчин төгөлдөр болно.

ТАЙЛБАР. Хуулийн заалтыг ойлголтын “Саналын дийлэнх олонхи” гэсэн ойлголтыг дараах байдлаар үзүүлье.



Саналын эрхтэй хувьцаа эзэмшигч. Хуулийн 17.1-д компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчийн тооноос үл хамааран компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж шийдвэрлэхэд зөвхөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид санал өгнө.

Саналын эрхгүй хувьцаа эзэмшигч гэдэгт компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлд зааснаар давуу эрхийн хувьцаа эзэмшигч саналын эрхтэй оролцохоор зааснаас бусад тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмшигч саналын эрхгүй байна. Түүнчлэн алтан хувьцаа эзэмшигч зөвхөн хориг тавих эрхтэй байдаг.

Саналын эрх. Нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна.¹⁵ (Хуульд өөрөөр заагаагүй бол) Саналын эрхтэй хувьцаа эзэмшигч

нь компанийн санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй.¹⁶ Энэ зарчмаар тодорхойлбол хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, түүнд дүйцүүлэн санал өгөх эрхийн хувиар саналын эрхийг тодорхойлж болно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд энгийн хувьцаа эзэмшигч компанийн тухай хуулийн 34,35 дугаар зүйлд заасан давуу эрхийн хувьцаа, саналын эрх эдлэнэ.

Саналын дийлэнх олонх. гэдэг саналын эрхийн гуравны хоёр буюу саналын эрхийн 66.6 хувийн санал авсан тохиолдолд компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгын төсөл батлагдаж, дүрмийн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга тус тус хүчинтэй болно. Эс бөгөөс төсөл батлагдахгүйд хүрнэ.

¹⁵ Компанийн тухай Монгол улсын хууль. 6.3.2 заалт.

¹⁶ Мөн хуулийн 63.3 заалт.

Хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах. Хуулийн 53, 54 дүгээр зүйлд хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн худалдан авах, энэхүү шаардлагыг хэрэгжүүлэх журмыг хуулийн 54 дүгээр зүйлд тус тус зохицуулсан. Хуулийн 17.2 дахь заалт бол компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт орсон, шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор дээр дурдсан шаардах эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эрх зүйн боломжийг тодорхойлно. Хуульд гурван тохиолдлыг заасан. Үүнд:

а) Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хөндсөн

б) Тухайн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцэж батлахад эсрэг саналтай байсан

с) Санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ. Ийнхүү бүртгүүлснээр дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болж, түүнийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

Бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

Компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий өргөдөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр /2015-01-29-ний өдрийн хуулиар хасагдсан

Дүрэмд орж байгаа нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгын бүрэн эх

Компанийн дүрмийн хуулбар

Бүртгэлийн хураамж төлсөн баримт

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэхэд дээрх баримт бичгийг бүртгүүлнэ.

Компанийн эрх бүхий этгээд. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1-д компанийн эрх бүхий этгээд өргөдөл гаргахаар заажээ. Хууль зүйн бүрдлийн хувьд эрх бүхий этгээдийн "гарын үсэг бүхий"

байх шаардлага тавьсан. Энэ нь тамга, тэмдгээр баталгаажуулах, баримт бичгийн хуудас хэрэглэх зэрэг баримт бичигт тавигдах шаардлага хангасан байх нь мэдээж юм.

Харин Компанийн хуульд Компанийн эрх бүхий албан тушаалтан гэх ойлголтыг тодорхойлсон байдаг. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл,

гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн даргын нарийн бичгийн дарга зэрэг албан ёсны шийдвэр гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. Эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг дүрэмдээ заах ёстой.¹⁷

Тэгэхлээр эдгээр эрх бүхий албан тушаалтнаас компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл гаргах, "компанийн эрх бүхий этгээд"-д ямар албан тушаалтан хамаарахыг дүрэмдээ заан тогтоож болно.

Бүртгүүлэх хугацаа. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлт, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор, хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

Компанийн дүрмийн өөрчлөлт, нэмэлт, дүрмийн өөрчлөн найруулгыг бүртгүүлэх "Компанийн эрх бүхий этгээд"-ийн үүрэг, хариуцлагын тухай тавигдах болно. Хэрэв ажлын 10 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол хууль зүйн ямар үр дагавар бий болох вэ ?

Бүртгүүлэх тухай өргөдөл, түүний хамтаар хүргүүлэх баримт бичгийг ажлын хэдэн хоногт багтаан бүртгэх байгууллагад өгөх талаар хугацаа

заагаагүй байна. Шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ гэжээ.

Бүртгэлийн байгууллага баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын хоёр өдрийн дотор бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргана. "Бүртгүүлнэ" гэдэг томъёоллын төгс агуулгаар нь үзвэл компани өргөдөл баримт бичгээ шийдвэр гарснаас хойш ажлын 7 өдрийн дотор бүртгэлийн байгууллагад хүргүүлэх болж байна.

Ажлын 10 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх ажиллагаа хугацаандаа зохих ёсоор хэрэгжээгүй, хуульд заасан хугацаа хэтэрсэн бол хуульзүйн хувьд шийдвэрлэх хоёр арга зам үлдэх болно.

Нэгдүгээрт: Улсын бүртгэлд хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй боловч компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулга хуульд нийцсэн гэж үзвэл бүртгэлийн байгууллага хянан үзэж бүртгэх. Мэдээж хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол хугацааг сэргээх тухай хууль зүйн асуудал яригдана.

Хоёрдугаарт: Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин хэлэлцэж шийдвэр гаргасны үндсэн дээр улсын бүртгэлд хуульд заасан хугацаанд бүртгүүлэх.

Энэ асуудлаар компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлд болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 6

¹⁷ Компанийн тухай Монгол улсын хуулийн 84 дүгээр зүйл. 84.1, 84.2

дугаар бүлэгт нарийвчлан зохицуулсан зүйл үгүй болно. Түүнчлэн бүртгэхээс татгалзах үндэслэлд компанийн тухай хуулийн 17.4-т заасан хугацааг зөрчсөн асуудал хамаарахгүй байна.

Улсын бүртгэлийн хуульд зааснаар хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд бүрдүүлэх баримт бичигт:

- нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт
- Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл¹⁸
- үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай шийдвэр
- үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлт
- шаардлагатай тохиолдолд итгэмжлэл
- улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт тус тус хамаарч байна.

Үндэслэл бүхий шийдвэр гаргана. Улсын бүртгэлийн байгууллага компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэх, бүртгэхээс татгалзсан үндэслэл бүхий шийдвэр гаргана. Хуулийн заалтын агуулгыг зөв ойлгож хэрэглэх, түүнийг хэрэгжүүлэхэд “үндэслэл бүхий шийдвэр гаргана” гэсэн хэсэг хууль хэрэглээний хувьд ач холбогдолтой байна.

Улсын бүртгэлийн байгууллага компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэсэн, бүртгэхээс татгалзсан аль ч тохиолдолд

¹⁸ Энд өргөдөл бол “Компанийн эрх бүхий этгээд” (Компанийн тухай хууль. 17.3.1 заалтад хамааралтай.)

үндэслэлийг шийдвэртээ тодорхой зааж байх шаардлагыг хуулиар тогтоосон гэж тайлбарлаж хэрэглэх нь зүйтэй юм.

Бүртгэхээс татгалзах. Компанийн дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах эрх зүйн үндэслэлийг тодорхойлохдоо зөвхөн хуулийн 17.3 дахь заалтаар хязгаарлаж байна. Татгалзах үндэслэл бол бүртгүүлэхийн тулд бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлтэй холбоотой байна. Тухайлбал, өргөдөл, түүнд тавигдах шаардлага нь:

- a) Компанийн эрх бүхий этгээд өргөдөл гаргасан байх
- b) өргөдөлд түүний гарын үсэг зурагдсан байхөд оршино.

Өргөдөлд дараах хоёр баримт бичиг хавсаргагдсан байх ёстой. Үүнд:

- a) Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр
- b) орж байгаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгын бүрэн эхийг хүргүүлнэ.

Компанийн дүрмийн хуулбар. Энэ нь шинэчилсэн дүрмийн хуулбарыг бүрэн хүргүүлэх шаардлага гэж ойлгогдохоор байна.

Бүртгэлийн хураамж төлсөн баримт.

Мэдэгдэл. Дээр дурдсан шаардлагыг / бүрдүүлбэрийг/ хангаагүй тохиолдолд бүртгэх байгууллага бүртгэхээс татгалзана. Ийнхүү бүртгэхээс татгалзсан бол бүртгэлийн байгууллагын шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор мэдэгдэнэ.¹⁹

¹⁹ "Ажлын гурван өдөр" гэснийг 2015 оны 09

Мэдэгдлийн агуулгад бүртгэхээс татгалзсан үндэслэлээ тусгасан байх шаардлагыг хуульд заан тогтоосон байна. Шийдвэр, мэдэгдэлд татгалзсан үндэслэлээ заах тухай хуулийн шаардлага нь компани эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах, түүний тулд шүүхэд гомдол гаргах эрхтэй холбоотой.

Шүүхэд гомдол гаргах. Хуулийн 17.3-т заасан шаардлагыг хангаагүй гэж бүртгэлийн байгууллага үзвэл компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэхээс татгалзах эрхтэй.

Бүртгэх байгууллагын гаргасан шийдвэрийг компани эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно. Шүүхэд гомдол гаргахдаа улсын бүртгэлийн байгууллага нь захиргааны хэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд хамаарах тул тухайн хуульд заасан журмын дагуу захиргааны хэргийн шүүхэд хандана.

Хүчин төгөлдөр болох. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноор түүнийг компанийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх, хувьцаа эзэмшигч, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, компанийн эрх бүхий албан тушаалтнаас дүрмийн нэмэлт өөрчлөлт шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх эрх зүйн боломж бий болно. Учир нь түүнийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга

хүчин төгөлдөр болоогүй, түүнийг улсын бүртгэлд бүртгүүлээгүй үед болон бүртгэхээс татгалзсан байхад явуулсан аливаа үйл ажиллагаа хийгээд нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгын дагуу хэрэгжүүлсэн шийдвэр, гэрээ хэлцэл, хүчин төгөлдөр бус байх эрх зүйн үр дагавартай гэж ойлгож болно.

Дөрөвдүгээр бүлэг.

Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах Өрийг хувьцаагаар солих

18 дугаар зүйл. Компанийг өөрчлөн байгуулах

18.1 Компанийг энэ хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

18.2 Хуульд заасан тохиолдолд шүүх компанийг хуваах, тусгаарлах шийдэр гаргаж болно.

18.3 Компанийг нэгтгэхээс бусад хэлбэрээр өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд нэгдэж байгаа компанийг улсын бүртгэлээс хассанаар, хэрэв нэгтгэсэн компанийн дүрэмд өөрчлөлт орсон бол түүнийг улсын бүртгэлд бүртгэснээр тэдгээрийг өөрчлөн байгуулсанд тооцно.

18.4 Компанийг нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд нэгдэж байгаа

сарын 29-ний өдрийн хуулиар ажлын хоёр өдөр” гэж өөрчилсөн.

компанийг улсын бүртгэлээс хассанаар, хэрэв нэгтгэсэн компанийн дүрэмд өөрчлөлт орсон бол түүнийг улсын бүртгэлд бүртгэснээр тэдгээрийг өөрчлөн байгуулагдсанд тооцно.

18.5 Компанийг өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор байгуулагдсан компани нь зээлдүүлэгч болон бусад харилцагчид, өөрчлөн байгуулагдсан тухайгаа бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд дараах зүйлийг тусгана.

18.5.1 өөрчлөн байгуулсан арга, хэлбэр ;

18.5.2 өөрчлөн байгуулагдсан болон түүний үр дүнд шинээр үүссэн компани тус бүрийн оноосон нэр болон байршил

18.5.3 өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарсан он, сар, өдөр

18.5.4 хуваах болон тусгаарлах замаар өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд хуваах баланс

18.6 Хувьцаат компани нь өөрчлөн байгуулагдах, татан буулгах тухай шийдвэр гаргаснаас

хойш энэ тухайгаа Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад ажлын гурван өдрийн дотор мэдэгдэнэ.


ТАЙЛБАР

Компанийг өөрчлөн байгуулах.

Компанийг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх гэсэн хэлбэрээр өөрчлөн байгуулж болдог. Эдгээр нь тодорхой төрлийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж дуусгавар болгодог хууль зүйн факт юм. Компанийг өөрчлөн байгуулах үед хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх, ашгийг хамгаалахад чиглэгдсэн нэг зүйл бол өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувь нийлүүлэгч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол өөрийн эзэмшиж байсан хувьцааг компанид эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй байдгаар илэрнэ.

Компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийг:

- a) Хувьцаа эзэмшигчдийн хурлаас
- b) шүүхийн шийдвэрээр тус тус гаргаж болно.



Компанийн хуулийн зохицуулалтаар компанийг нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах, компанийг бусад хэлбэрээр өөрчлөн байгуулах нэгэн ерөнхийд нь хоёр хэсэгт ангилан үзэх боломжтой. Энэ нь компани өөрчлөн байгуулагдсанд тооцох эрх зүйн үндэслэлтэй холбогдоно.

Компани өөрчлөн байгуулагдсанд тооцох. Компанийг нийлүүлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд шинээр бий болж байгаа компанийг улсын бүртгэлд бүртгэснээр өөрчлөн байгуулагдсанд тооцно.

Шинээр бий болж байгаа компанийг улсын бүртгэлд бүртгэснээр түүний хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар үүснэ. Түүнийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөлд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан мэдээллийг тусгахаас гадна үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээдийн мэдээллийг тусгах ёстой.


Компанийг нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд:

- а) Нэгдэж байгаа компанийг улсын бүртгэлээс хасна
- б) Нэгтгэсэн компанийн дүрэмд өөрчлөлт орсон бол түүнийг улсын бүртгэлд бүртгэнэ.

Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлснээр өөрчлөн байгуулагдсанд тооцогдоно.

Мэдэгдэл гаргах. Компанийг өөрчлөн байгуулах үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг нь харилцагчдад мэдэгдэх асуудал байдаг. Энэ нь өөрчлөн байгуулагдсан компани нь дараах үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

- а) Зээлдүүлэгч болон бусад харилцагчид өөрчлөн байгуулагдсан тухай бичгээр мэдэгдэнэ.
- б) Энэхүү мэдэгдлийг шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор хийх ёстой.




“Байршил” гэдэг нь шинээр байгуулагдсан компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягаар тодорхойлогдоно.

“Хуваах баланс” тухайн компанийн тайлан тэнцэл, түүний хуваарилалтын асуудалд хамаарна.

Хувьцаат компанийн онцлог нь: Санхүүгийн зохицуулах хороо, үнэт

цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэх явдал юм. Хувьцаат компани өөрчлөн байгуулагдах татан буулгах тухай шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор мэдэгдэнэ.

Хуульд заасан тохиолдолд компанийг шүүх өөрчлөн байгуулах шийдвэр гаргаж болно.



Өрсөлдөөний тухай Монгол улсын хууль (шинэчилсэн найруулга)-ийн 10 дугаар зүйлд Давамгай байдалтай хуулийн этгээдийг хуваах, тусгаарлах талаар заасан байдаг.

Тухайн заалт ёсоор бол ноёлох үйл ажиллагааг жилд хоёр ба түүнээс дээш удаа явуулах хуулийн хариуцлага хүлээж байсан ч дахин ийм үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол тухайн давамгай байдалтай хуулийн этгээдийг хуваах, тусгаарлах замаар өөрчлөх байгуулах шийдвэрийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас гаргасан нэхэмжлэлийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

“Ноёлох үйл ажиллагаа” гэж компани давамгай байдлаа хууль бусаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор зах зээлд борлуулж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээ, үнэ зэргийг хязгаарлан өрсөлдөөнийг

бодитоор хязгаарлах, хэрэглэгчийг хясан боогдуулахыг хэлнэ.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас гаргасан давамгай байдалтай компанийг хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай нэхэмжлэлийг иргэний хэргийн шүүх хүлээн авч, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу хянан шийдвэрлэнэ²⁰.

Компанийг өөрчлөн байгуулах эрх зүйн эх сурвалжийн нэг болох Иргэний хуулийн 31 дүгээр зүйлд хуулийн этгээдийн хөрөнгийг өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллага, үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэрээр, хуульд

²⁰ Өрсөлдөөний эрх зүй (гарын авлага). М.Батсуурь, Э.Лхагвасүрэн, 5.Цолмонбаатар. 2014 он. Дөрөвдүгээр бүлэгт “Өрсөлдөөний эрх зүй ба шүүхийн хэсэгт х-97-116 талыг үзэх.” Ноёлох үйл ажиллагаа” гэж Өрсөлдөөний тухай хууль (шинэчилсэн найруулга) 4.1.5, 7.1 заалтуудаас үзнэ үү.

заасан журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно гэж заажээ.

Энэ заалтаас үзэхэд компанийн хөрөнгийг өмчлөгч (нэг гишүүнтэй бол тухайн компанийн гишүүн өөрөө), үүсгэн байгуулах эрх олгосон байгууллага, компанийн тухай хууль, компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гаргана.

19 дүгээр зүйл. Компанийг нийлүүлэх


- 19.1 Хоёр буюу хэд хэдэн компанийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон компанид шилжүүлэхийг компанийг нийлүүлэх гэнэ.
- 19.2 Нийлж байгаа компани тус бүрийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийг нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийн төсөл болон өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээ, шинээр бий болсон компанийн дүрэм, компани тус бүрийн үнэт цаасыг шинээр бий болсон компанийн үнэт цаас буюу эд хөрөнгөд хөрвүүлэх журмыг тодорхойлсон саналаа компани тус бүрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж

шийдвэрлүүлнэ.

- 19.3 Компаниудыг нийлүүлэх тухай шийдвэр, гэрээг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнхи олонхоор батална.
- 19.4 Гэрээнд шинээр үүссэн компанийн хувьцаа, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хугацаа, товыг заана.
- 19.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрмийг батлах бөгөөд хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно.
- 19.6 Хувьцаа эзэмшигчдийн хуралд байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын эрх нь энэ хуулийн 19.2-т заасан гэрээгээр тодорхойлсон хөрвөсөн саналын эрхтэй тэнцүү байна.

ТАЙЛБАР

Компанийг нийлүүлэх. Хоёр буюу хэд хэдэн компанийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон компанид шилжүүлэхийг компанийг нийлүүлэх гэнэ” гэж хуульд тодорхойлжээ. Ойлголтыг хялбаршуулан үзүүлбэл:



Тэгэхлээр А,Б,В,Д компани тус бүрийн үйл ажиллагааг зогсоон тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлага “С” компанид шилжих болно. Эрх, үүрэг, хариуцлага, шинээр бий болсон компанид шилжинэ гэдгийг дараах байдлаар жишээ авч босох юм. А компани бусдад 10 сая төгрөгийн төлбөр төлөх үүрэгтэй байсан. Харин Б компани 15 сая төгрөгийн авлагатай байсан, В компани харилцагчдаа гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн алданги 5 сая төгрөг төлөх ёстой. Д компани татварт 2 сая төгрөг төлөх өртэй боловч буцаан олголтоор 3 сая төгрөг шаардсан авах шаардан авах эрхтэй байсан гэх мэт.

Эдгээр компанийн үйл ажиллагаа дуусгавар болсон тул гүйцэтгэх үүрэг, шаардах эрх, хүлээх үүрэг хариуцлага нь С компанид шилжинэ.

Хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэнэ. Компанийг нийлүүлэх тухай шийдвэрийг нийлж байгаа компани тус бүрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ. Шийдвэр гаргуулахын тулд компанийг нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах санал, шийдвэрийн төсөл боловсруулна. Үүнд:

- шийдвэрийн төсөл
- өөрчлөн байгуулах нөхцөл журмыг тодорхойлсон гэрээ

- шинээр бий болох компанийн дүрэм
- компани тус бүрийн үнэт цаасыг хөрвүүлэх журам.

Үнэт цаасыг хөрвүүлэхдээ шинээр бий болсон компанийн үнэт цаас буюу эд хөрөнгөд хөрвүүлэх тухай яригдана.

Эдгээр саналыг нийлж байгаа компани бүрийн төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрийн төсөл санал боловсруулна. ТУЗ байхгүй бол энэ ажиллагааг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

Саналын дийлэнх олонхоор батална. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнхи олонхоор компаниудыг нийлүүлэх тухай шийдвэр, өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээг батлана. Уг гэрээнд: шинээр үүссэн компанийн хувьцаа, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хугацаа, товыг тус тус заана.

Шинээр үүссэн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар:

- а) компанийн дүрмийг батална.
- б) Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх эсэхийг шийдвэрлэнэ
- в) Хэрэв ТУЗ байхаар шийдвэрлэсэн бол гишүүдийн тоог тогтоож, гишүүдийг сонгоно.

Саналын эрх нь компани тус бүрийн үнэт цаасыг шинээр бий болох компанийн үнэт цаас, эд хөрөнгийг шилжүүлэх журмыг тодорхойлсон, өөрчлөн байгуулах гэрээнд заасан хөрвөсөн саналын эрхтэй тэнцүү байх зарчмыг баримтална.

Компанийг нийлүүлэх замаар өөрчлөн байгуулсан тохиолдолд нийлсэн компани тус бүрийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож, улсын бүртгэлээс хасна. Шинээр бий болсон компанийг түүний мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулна.

20 дугаар зүйл. Компанийг нэгтгэх

20.1 Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр компанид шилжүүлэхийг компанийг нэгтгэх гэнэ.

20.2 Нэгдэж байгаа болон нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /хэрэв байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийг нэгтгэх тухай шийдвэрийн төсөл болон компанийг нэгтгэх гэрээг компани тус бүрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

20.3 Энэ хуулийн 20.2-т заасан гэрээнд компанийг нэгтгэх нөхцөл, журмыг тодорхойлохоос гадна нэгдэж байгаа компанийн үнэт цаас, бусад хөрөнгөд хөрвүүлэх журмыг тусгасан байна.

20.4 Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах тухай

шийдвэрийг энэ хуулийн 20.2-т заасан хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор гаргана.

20.5 Нэгдэж байгаа компанийн нийт энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа бөгөөд компанийг нэгтгэснээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-аар компанийг нэгтгэх тухай шийдвэр гаргаж, нэгтгэх журмыг баталж болно.

ТАЙЛБАР

Компани нэгдэх. Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр компанид шилжүүлэхийг компани нэгдэх гэнэ. Компани нэгдэх ажиллагаанд нэгдсэн, нэгтгэсэн гэх хоёр субъект оролцох бөгөөд шинээр компани бий болдоггүй, харин нэгдсэн компанийн үйл ажиллагаа нь дуусгавар болж, эрх үүрэг нь нэгтгэсэн компанид шилждэг зэргээрээ нийлэхээс ялгагддаг онцлогтой.

Компанийг нэгдэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн дийлэнх олонхын саналын эрхээр гаргадаг. Нэгдэж байгаа компанийн нийт энгийн хувьцааны 75-аас илүү хувийг эзэмшиж байгаа бөгөөд нэгдсэнээр

компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар нэгдэх тухай шийдвэр гаргаж, нэгдэх журмыг баталж болно.

Компанийг нэгтгэх гэж компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр компанид шилжүүлэхийг хэлнэ. Иргэний хуулийн 32 дүгээр зүйлийн 31.3-т зааснаар бол "Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлага өөр этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг нэгтгэх гэнэ. Нэгтгэх замаар өөр компанийг өөрчлөн байгуулах тохилдолд нэгдэж байгаа хуулийн этгээд тус бүрийн үйл ажиллагааг дуусгавар болсонд тооцож, улсын бүртгэлээс хасна.

Нэгтгэж байгаа компанийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэх ажиллагаа явагдана.

Компанийг нэгтгэх тухай шийдвэрийн төсөл, компани нэгтгэх гэрээний хоёр баримт бичиг үйлдэнэ. Эдгээр төсөл баримт бичгийг

- a) Нэгдэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ байхгүй бол Гүйцэтгэх удирдлага боловсруулж бэлтгэнэ.
- b) Нөгөө талаас мөн нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ байхгүй бол Гүйцэтгэх удирдлага боловсруулж бэлтгэнэ.

Компанийг нэгтгэх тухай шийдвэрийн төсөл, компанийг нэгтгэх гэрээг нэгдсэн гэж байгаа компани бүрийн тус

тусын хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Шийдвэрийг нэгдэх, нэгтгэх гэж байгаа компани тус бүрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

Хуульд зааснаар нэгдэж байгаа компанийн нийт энгийн хувьцааны 75, түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд эрх зүйн дараах нөхцлийг харгалзах хэрэгтэй болно. Үүнд: Тухайн компанийг нэгтгэснээр дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй хэмээн нэгтгэж байгаа компани үзэх явдал юм. Жишээ нь компанийн өөрийн хөрөнгөө ихсэх, багасгах, хувьцааны тэнд өөрчлөлт орох, саналын эрх эерчлөх зэрэг асуудалд анхаарах учиртай.

Дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй гэвэл нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, компанийг нэгтгэх тухай шийдвэр гаргах, нэгтгэх журмыг батлах боломжтой. Төлөөлөн удирдах зөвлөлгүй бол асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

21 дүгээр зүйл. Компанийг хуваах

21.1 Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш компанид шилжүүлэхийг компанийг хуваах гэнэ.

21.2 Компанийг хуваах тухай шийдвэрт өөрөөр заагаагүй бол хуваагдаж байгаа компанийн

энгийн хувьцаа эзэмшигч нь компанийн хөрөнгийн хуваагдсан хэмжээтэй хувь тэнцүүлэн шинээр бий болсон компани тус бүрийн энгийн хувьцааны эзэмшигч болно.

21.3 Компанийг хуваах замаар өөрчлөн байгуулах, шинээр компани байгуулах, хуваах балансыг батлах асуудал болон тухайн компанийн үнэт цаасыг шинээр байгуулагдсан компанийн үнэт цаас буюу эд хөрөнгөд хөрвүүлэх журмыг хуваагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралдоролцожбайгаасаналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

21.4 Шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрмийг батлах бөгөөд хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно.

21.5 Энэ хуулийн 21.4-т заасан хурлыг хуралдуулах тусгайлсан журмыг хуваах замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрт заана.

21.6 Компанийг хуваахад түүний эрх, үүрэг, хариуцлага шинээр байгуулагдсан компаниудад хуваах балансын дагуу

шилжинэ.

21.7 Компанийг хуваах тухай гэрээнд өөрөөр заагаагүй бол шинээр үүссэн компани бүр бусад компанийнхаа өмнөөс давхар хариуцлага хүлээнэ.

ТАЙЛБАР

Компанийг хуваах. Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүргийг шинээр үүсэх компаниудад бүрэн шилжүүлэхийг компанийг хуваах гэнэ. Компанийг хуваах тухай шийдвэрт өөрөөр заагаагүй бол хуваагдаж байгаа компанийн энгийн хувьцаа эзэмшигчид нь компанийн хөрөнгийн хуваагдсан хэмжээтэй хувь тэнцүүлэн шинээр буй болсон компани тус бүрийн энгийн хувьцаа эзэмшигч болно.

Шинээр байгуулагдсан компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаар компанийн дүрмийг баталж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгодог.

Компанийг хуваах тухай гэрээгээр талууд тохиролцоогүй бол шинээр үүссэн компани бүр бусад компанийнхаа өмнөөс давхар хариуцлага хүлээнэ. Давхар хариуцлага гэж юу болох талаар иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заалт байхгүй. Иймд давхар хариуцлага гэдгийг хуваагдсан компаниудын хүлээх хамтын хариуцлага гэж ойлгож болно. Гэхдээ хамтын хариуцлага нь зөвхөн компани хуваагдахаас өмнөх ажиллагааны эрх, үүрэгтэй холбоотой үүсдэг болохоос хуваагдсан компани болгон нэг нэгнийхээ өмнөөс хариуцлага хүлээнэ гэж ойлгож болохгүй.

Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш компанид шилжүүлэхийг компанийг хуваах гэнэ.

Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг хариуцлагыг шинээр үүсэх хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийг хуваах гэнэ.

Эдгээр тодорхойлолт “хуваах” тухай ойлголтын шинжийг ижил түвшинд илэрхийлнэ. Компанийг хуваах замаар өөрчлөн байгуулах тохиолдлоор:

1. Хуваагдаж байгаа компанийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцно.
2. Түүнийг улсын бүртгэлээс хасна.
3. Шинээр байгуулагдсан компани тус бүрийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ.

Компанийг хуваах тухай шийдвэрт хэрхэн хуваагдах арга, журмыг тодорхой тусгах ёстой байдаг. Тухайн шийдвэрт өөр байдлаар журамлан заагаагүй бол хуульд заасан дараах журмыг баримтална. Үүнд:

- а) Хуваагдаж байгаа компанийн хувьцаа эзэмшигч нь шинээр бий болсон компани тус бүрийн энгийн хувьцаа эзэмшигч болно.
- б) Энгийн хувьцаа эзэмшигч нь компанийн хөрөнгийн хуваагдсан хэмжээтэй хувь тэнцүүлэн шинээр бий болсон компанид хувь эзэмших эрхтэй болно.

Саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ. Хуваагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/

хувьцаа эзэмшигчдийн хуралд дараах зүйлийг оруулж хэлэлцүүлнэ. Үүнд:

1. Компанийг хуваах замаар өөрчлөн байгуулах
2. шинээр компани байгуулах,
3. хуваах тайлан тэнцлийн батлах
4. компанийн үнэт цаасыг шинээр байгуулагдсан компанийн үнэт цаас, эд хөрөнгөд хөрвүүлэх журам

Эдгээр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

Шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд:

- Компанийн дүрмийг хэлэлцэж батлана.
- Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх эсэхийг хэлэлцэж дүрэмд тусгана.
- Төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүний тоог тогтоож, гишүүдийг сонгоно.

Энэхүү хурлыг хуралдуулах журмыг компанийг хуваах журмаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрт тусгайлан заана. Компанийн хуваах замаар өөрчлөн байгуулахад дараах онцлогийг анхаарах учиртай.

1. *Хуваах балансын дагуу шилжинэ.* Энэ нь эрх, үүрэг, хариуцлага шилжих ажиллагаатай холбоотой. Компанийг хуваахад түүний эрх, үүрэг, хариуцлага шинээр байгуулагдсан компаниудад хуваах балансын дагуу шилжинэ. Тухайлбал, С компани А, Б, Д гурван компанид хуваагдсан гэж бодвол: Хуваах балансаар А компанид 40 хувийн, В, Д компанид тус бүр 30 хувь ногдсон бол эрх, үүрэг, хариуцлага 40, 30, 30 хувиар хуваан хэрэгжүүлнэ.
 2. *Давхар хариуцлага хүлээнэ.* гэдэг нь шинээр үүссэн компани бүр бусад компанийнхаа өмнөөс хариуцлага хүлээнэ. Хариуцлага хүлээх энэ хэлбэрийг давхар хариуцлага хүлээх гэдэг. Харин компанийг хуваах тухай гэрээнд өөрөөр заасан бол гэрээнд заасан хариуцлагаа хүлээх магадлалтай. Компанийг хуваах замаар өөрчлөн байгуулахад хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр, шүүхийн шийдвэрээр тус тус хийгдэж болно. Шүүхийн шийдвэрээр компанийг хуваасан бол шийдвэрийн заалтад үндэслэн зохион байгуулагдана. Иймээс шүүхийн шийдвэрт компанийг хуваахаар шийдвэрлэсэн эрх зүйн үндэслэлийг маш тодорхой тусгахаас гадна хуваах, тайлан тэнцэл /баланс/, шилжих хөрөнгийн хувь хэмжээ болон харьцаа, давхар хариуцлага хүлээх үндэслэл журмыг нэг бүрчлэн нарийн шийдвэрлэх, улмаар маргаангүй ойлгогдохоор шийдвэрт бичигдсэн байх учиртай.
- 22 дугаар зүйл. Компанийг тусгаарлах
 - 22.1 Компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан компанид шилжүүлэхийг компанийг тусгаарлах гэнэ.
 - 22.2 Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулахад өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигч байна.
 - 22.3 Компанийг тусгаарлах нөхцөл, журам, хуваах балансыг батлах болон шинэ компани байгуулах тухай шийдвэрийг өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ гаргана.
 - 22.4 энэ хуулийн 22.1-д заасны дагуу шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн дүрмээ батлах бөгөөд хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно.
 - 22.5 Компанийг тусгаарлахад өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь өөрийн бүх өрийг хариуцна.
 - 22.6 Өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн өмнөөс түүний өрийг энэ хуулийн 22.1-д заасны дагуу шинээр байгуулагдаж байгаа компаниар төлүүлэхийг

- хуваах балансаар тогтоож болно.
- 22.7 энэ хуулийн 22.6-д заасны дагуу өр төлөх тохиолдолд өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь шинээр байгуулагдсан компанид шилжүүлсэн үүргээ хамтран хүлээнэ.
- 22.8 Компанийг тусгаарлах замаар шинээр байгуулагдсан компаниас гаргасан үнэт цаасыг энэ хуулийн долдугаар бүлэгт заасныг үндэслэн бүгдийг нь, эсхүл түүний зарим хэсгийг ногдол ашиг хэлбэрээр өөрчлөн байгуудагдсан компанийн хувьцаа эзэмшигчид шилжүүлж болно.

ТАЙЛБАР

Компанийг тусгаарлах. Компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим хөрөнгө, эрхийг шинээр байгуулагдсан компанид шилжүүлэхийг тусгаарлах гэнэ. Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах компани нь шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигч болно. Иймд тусгаарлагдсан компани үндсэн компаниас үүсмэл байдаг. Шинээр байгуулагдсан компанийн хувь нийлүүлэгчдийн хурал нь энэ байгуулагдсан компанийн дүрмийг баталж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөл байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүнийг сонгсдог. Компанийг тусгаарлахад өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн өмнөөс түүний өрийг шинээр бий болж байгаа компаниар төлүүлэхээр хуваах балансаар тогтоож болно.

Компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан компанид шилжүүлэхийг компанийг тусгаарлах гэнэ.	Хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд шилжүүлэхийг хуулийн этгээдийн тусгаарлах гэнэ. (ИХ&З1.5)
--	--

Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тохиолдолд шинээр байгуулагдсан компани бүрийн бүртгэлийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэнэ. Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах ажиллагаа хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэрээр болон шүүхийн шийдвэрээр тус тус хэрэгжиж болно. Компанийг тусгаарлах аргаар өөрчлөн байгуулах тухай шүүхийн шийдвэр гарсан бол тухайн шүүхийн шийдвэрт заасны дагуу зохион байгуулагдах боловч компанийн

тухай хуульд тогтоосон журмын дагуу тусгаарлах ажиллагааг хэрэгжүүлнэ.

Компанийн тухай (шинэчилсэн найруулга) Монгол улсын хуулийн 22 дугаар зүйлд компанийг шүүхийн шийдвэрээр тусгаарлах, зохицуулалт тусгагдаагүй болно.

Шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчээр өөрчлөн байгуулагдаж байгаа компани байна гэж хуульд заажээ. Өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах

зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага дараах шийдвэрийг гаргана.) Үүнд:

1. Компанийг тусгаарлах нөхцөл журам батлах
2. Хуваагдах балансыг батлах
3. Шинэ компани байгуулах тухай шийдвэрийг тус тус гаргана.

Шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаараа дараах суудлыг шийдвэрлэнэ.

- a) компанийн дүрмээ батална.
- b) Төлөөлөн удирдах зөвлөл байх эсэхийг шийдвэрлэнэ.
- c) ТУЗ-тай байхаар тогтвол гишүүдийн тоог тогтооно. Гишүүдийг сонгож байгуулна.

Өр хөриуцах. Өөрчлөн байгуулагдаж байгаа компани өөрийн бүх өрийг хариуцан барагдуулна. Энэ бол компанийг тусгаарлахад баримтлах эрх зүйн ердийн нөхцөл гэж хэлж болно. Үүнээс өөр нөхцөл нь шинээр байгуулагдаж байгаа компанид шилжүүлсэн үүргээ хамтран хүлээх нөхцөл байдаг. Энэ нь өөрчлөн

байгуулагдаж байгаа компанийн өмнөөс түүний өрийг төлүүлэхээр зарим эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэх замаар хуваах балансээр тогтоох арга байдаг. Энэ тохиолдолд шинээр байгуулагдаж байгаа компани өөрт ногдох өрийг хариуцан төлөх үндэслэл бий болно.

Шинэ байгуулагдаж байгаа компани өр төлөх тохиолдолд түүнд шилжүүлсэн үүргээ өөрчлөн байгуулагдаж байгаа компани хамтран хүлээж, хамтран биелүүлэх эрх зүйн үр дагавар бий болно. Шинээр байгуулагдсан компани гаргасан үнэт цаасыг:

- a) бүхэлд нь
- b) зарим хэсгийг
- c) ногдол хувь, хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчид шилжүүлж болно.

Компаниудын хоорондын энэ харилцаа нь компани өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах талаарх компанийн хуулийн зохицуулалтад үндэслэнэ.

ОРЧУУЛГА

ӨНӨӨ ҮЕД МЭРГЭШСЭН ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД¹ (ӨГҮҮЛЛИЙН ОРЧУУЛГА)

Т.СҮХБААТАР

(Шихихутуг судалгааны хүрээлэнгийн
эрдэмтэн нарийн бичгийн дарга)

Өнөө үед мэргэшсэн гэмт явдалтай үр дүнтэй тэмцэх нийтлэг ерөнхий болон тусгай криминологийн (эрх зүйн, зохион байгуулалтын) арга хэмжээг тодорхойлох нь чухал байна. Мэргэшсэн гэмт явдал бол хаалттай, харьцангуй бага судлагдсан зүйлд тооцогддог. Зөвлөлт гүрний үед криминологичид мэргэшсэн гэмт явдлыг судлах оролдлого хийж байсан хэдий ч мэргэшсэн гэмт явдлыг бус ихэвчлэн онц аюултай гэмт хэрэгтэнтэй уялдуулан судладаг байсан.

Гэмт мэргэжил гэдэг талаас нь илүү ач холбогдол өгч, анхаарч хийгдсэн судалгаа бол А.И.Гуровын хийсэн судалгаа бөгөөд энэ нь одоо ч суурь ач холбогдлоо алдаагүй байна.

Харин өнгөрсөн хугацаанд бүхэлдээ энэ чиглэлээр эрдмийн цол зэрэг горилсон судалгаанууд цөөн хийгдэж байсан, тэгээд ч тэдгээр бүтээлүүдэд энэхүү үзэгдлийн мөн чанарыг илрүүлж гаргах талаар ямар нэгэн онцгой, шинэлэг зүйл ажиглагддаггүй.

Нийгмийн харилцаа ихээхэн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор зөвлөлтийн үеийн мэргэшсэн гэмт явдлын үндсэн шинжүүд нэлээдгүй

өөрчлөгджээ. Түүнээс гадна гэмт явдлын өөрийнх нь орчин, янз бүрийн түвшний гэмт этгээдийн хоорондын хамтын ажиллагаа, гэмт ертөнцийн тогтвортой байдал, хөгжлийг зохицуулдаг дотоод дэг журам ч эрс өөрчлөгдсөн байна. Ер нь мэргэшсэн гэмт явдлын мэргэшсэн байхыг тодорхойлдог шинж тэмдгүүд зарим нэг байдлаар “хуулбарлагдаж” ирсэн аж. Түүнчлэн гэмт үйл ажиллагаа олон талтай болж дагасан байдлын хүрээнд “дахин мэргэших” зэрэг тогтвортой чиг хандлагууд ажиглагдах болсон. Энэ үйл явц нь мэргэшсэн гэмт явдлын бүтцэд өмнө нь байгаагүй гэмт явдлын шинэ, ажил мэргэжил үүсч бий болсонтой нягт холбоотойгоор өрнөсөн. Тиймээс ч гэмт үйл ажиллагаа эрхэлдэг субъектуудын мэргэжлийн үр дагаврыг өвлөн авахад хүргэж байна.

Нэг талаас шинээр бий болж байгаа “эрүүгийн” гэх мэргэжлүүд зарим нэг этгээдүүдийн хувьд ур чадвар, арга ажиллагааг өвлөж авах үйл ажиллагаа байж байгаа хэдий ч тэдгээрийг хөгжүүлэхэд мэргэшсэн байдал нь ач холбогдлоо алдахад хүргэж байна. Яагаад гэвэл өвлөж авсан арга ажиллагаа, ур чадвар нь тусгайлсан нэмэлт арга ажиллагааг шаардахгүй байдагтай холбоотой. Жишээ нь: Мансууруулах бодис худалдахад

¹ Репецкая А.Л. /Эрхүүгийн Улсын Их Сургууль, Хуулийн Институт, Хууль зүйн ухааны доктор, профессор/-өгүүлэл.

оролцдог гүйгчид, залгигчид, тараан түгээгчид, зөөвөрлөгчид, хамгаалагчид зэрэг нь тусгайлсан арга ажиллагаа, ур чадвар шаардаад байдаггүй.

Нөгөө талаасаа эрүүгийн ертөнц дэх шинэ мэргэжлүүд болон гэмт үйл ажиллагааны төрлүүд нь урд өмнө нь хэзээ ч хэрэглэгдэж байгаагүй ур чадвар, арга ажиллагааг шаардах болсон төдийгүй гэмт үйл ажиллагаанд бус харин мэргэжлийн нууц үйл ажиллагаанд илэрч гарах болсон. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн нууц үйл ажиллагаанууд эрүүгийн ертөнц рүү шилжих үйл явц өрнөж байна гэсэн үг. Тухайлбал: Хууль бусаар ан хийгчид, хакерууд гар утасны оператор компаниудын хэрэглэдэг багаж хэрэгсэл, мэдлэг, арга ажиллагааг ашигладаг болсон байна.

Дээр дурдсан жишээ нь гэмт үйл ажиллагаа явуулдаг мэргэшсэн этгээдүүдийн орчин үеийн онцлог шинжийг тодорхойлж байгаа хэрэг юм.

Ажил үүргээ хуваарилах, гэмт чиг үүргээ хэрэгжүүлэх талаар тусгайлан бэлтгэгдэх, мэргэшсэн байдлаар гэмт хэрэг үйлдэх зэрэг шинж байдлыг хадгалсаар байгаа нь бүхэлдээ гэмт бүлэглэлийн хүчин чадал төвлөрч бөөгнөрөх, бүтэц зохион байгуулалтын илүү өндөр дээд түвшинд хүрэх хэрэгцээ шаардлагаа харуулж байна. Зөвлөлтийн үеийн мэргэшсэн эрүүгийн ертөнцөд болж өнгөрсөн дээрх дурдсан шилжилт хөдөлгөөн, үйл явц нь орчин үед мэргэшсэн гэмт явдал өргөжин хөгжих, түүний нийгмийн аюултай байдал өсөн нэмэгдэхэд хүрч байна.

Түүнчлэн нийгмийн амьдралд сөрөг ахуй нөхцлүүд үүсч улмаар нийгмийн оюун санаа эрүүгийн шинжтэй болж байгаа нь ихээхэн хор уршигтай гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй бөгөөд энэ нь мэргэшсэн гэмт явдал оршин байгаагийн үр дүн, нотолгоо юм.

Нийгэмд болж өнгөрч байгаа өөрчлөлтүүд нь мэргэшсэн гэмт явдалтай үр дүнтэй тэмцэх, түүнд нөлөөлөх нөхцөл байдлыг бий болгож байгаа төдийгүй мэргэшсэн гэмт явдлын нэн аюултай шинэ чиг хандлагууд үүсч бий болох, эрүүгийн ертөнц хүчээ нэгтгэх явдлыг таслан зогсоох, тодорхой түвшинд түүнийг “царцаах”, нийгмийн хөгжил, ухамсарт сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэх ёстой.

Түүнээс гадна мэргэшсэн гэмт явдалтай тэмцэхэд чиглэгдсэн одоогийн арга барил нь эрүүгийн ертөнцтэй тэмцэж байгаа тогтолцооноос төдийлөн өөрчлөгдсөн зүйлгүй байна. Мэргэшсэн гэмт явдалтай хийх тэмцэл нь ерөнхийдөө эрүүгийн гэмт явдалтай тэмцэхэд л чиглэгдэж байна. Энэ нь хууль сахиулах байгууллагуудын өнөөгийн бүтэц тогтолцоо болон байнга өөрчлөн зохион байгуулж байгаатай ч холбоотой байна. Үүнтэй уялдаатайгаар дээрх сөрөг үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тодорхойлж, энэхүү үйл явцад үүсч гарч байгаа төвөг бэрхшээлүүдийг илрүүлэн гаргаж ирэх шаардлагатай байна. Ингэж чадвал мэргэшсэн гэмт явдалтай хийх тэмцэл үр дүнд хүрнэ.

Эрүүгийн ертөнцийн (гэмт явдлын) хөгжлийн үндсэн учир шалтгаан нь

нийгмийн харилцааны систем (бүтэц) өөрчлөгдөж байгаа үйл явц, зөвлөлт нийгэм дэх янз бүрийн сөрөг үзэгдлүүд үүсч хөгжсөн явдлууд бөгөөд эдгээр нь улс орны нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг эрүүлжүүлэх “сүүдрийн эдийн засаг, эрүүгийн ертөнцийн хөгжлийг” сөрөн зогсох, мэргэшсэн гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд том үүрэг гүйцэтгэсэн төдийгүй, Оросын нийгмийн өмнө зогсож байсан үндэсний үзэл санаа хэмээн нэрлэгдэж байсан үндэстнүүдийг нэгтгэх гэсэн зорилгод хүрэхэд нөлөөлсөн.

Шинэ үе маань сансар огторгуйг эзэмших, эх орноо хамгаалах талаар төдийлөн бодохгүй. Харин өнөө оршин байгаа эрүүгийн ертөнцийн хүчирхэг дарамт шахалтын дор одоогийн залуучуудын зарим нь захиалгаар хүн алах, хакер сутенер болохыг л мөрөөддөг болсон нь нууц биш.

Нийгмийн бодитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь мэргэшсэн гэмт явдлын эдийн засаг, нийгмийн бааз суурийг хумьж, хязгаарлахад хүргэх ёстой.

Юуны өмнө хүмүүст хэвийн амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ажил мэргэжил, албан тушаалын хувьд эрүүгийн гэмт хэрэгтнүүдийн анхаарлыг татаж байдаг хүмүүс (Тухайлбал: хууль сахиулах байгууллагын албан тушаалтан, мэдээллийн сүлжээний программист, нягтлан бодогч гэх мэт) болон өмнө нь хийж байсан ажилтай нь холбоотойгоор (цэргийн тусгай анги нэгтгэлийн албан хаагч, тамирчид) аль эсвэл нийгмийн тодорхой бүлэгт

хамаарах хүмүүст (цыганууд) хууль, эрх зүйн зөв, зан төлвөөр дамжуулан нийгэмд дасан зохицох байдлыг бий болгоход чиглэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь чухал байна.

Өнөөгийн нийгэмд хүн амын ахуйн хэрэглээ өсөн нэмэгдэх байдал ажиглагдаж байгаа бөгөөд үүнийг хөхиүлэн дэмжихэд эрүүгийн зах зээл дээрх субъектууд ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. Хүлээгдэж байгаа эрэлт хэрэгцээ нь гэмт хэргийн замаар олж авсан бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр төрөл жагсаалтыг шинээр зохиоход хүргэж байгаа төдийгүй эрүүгийн чиг хандлага бүхий, мэргэшсэн ажил мэргэжлийг өвлөн авахад дэм туслалцаа үзүүлж, үлмаар хуурамч бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, ийм үйл ажиллагаа явуулдаг хүмүүст зориулагдсан зах зээлийг бий болгоход хүргэж байна.

Төрөөс хүн амын амьдралын зөв хэв маягийг хөхүүлэн дэмжиж байгаа нь мэргэшсэн гэмт явдлын нийгмийн хөрс суурийг арилгахад нөлөөлөөд зогсохгүй эрүүгийн мэргэшсэн гэмт этгээдүүдээс үзүүлж байгаа секс үйлчилгээний хүрээ болон архи согтууруулах ундаа хэрэглэгчдийн тоог эрс багасгаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээнүүд нь мэргэшсэн гэмт явдлын хүчийг сулруулж, түүний шалтгаан нөхцөлийг арилгаж устгах, саад хийхэд чиглэгдэх ёстой. Өөрөөр хэлбэл гэмт зан үйл, ёс заншил, эрүүгийн ёс суртахуун, эрүүгийн хууль тогтоомж дахь алдаа дутагдал, ял эдлүүлэх

байгууллагын үйл ажиллагааны талаарх хуурамч мэдээллийг таслан зогсоох ёстой.

Үүнтэй холбоотойгоор эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох. Тухайлбал: мэргэшсэн гэмт хэрэгтнүүд болон олон жил гэмт үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа гэмт бүлэглэлүүдэд оногдуулах ял шийтгэлийг чангаруулах (хүндрүүлэх) зэрэг эрх зүйн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь нэн чухал болоод байна.

Хууль тогтоох байгууллага дээрх хэрэгцээ шаардлагыг харгалзан 2009 онд ОХУ-ын Эрүүгийн хуулийн 210 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Мэргэшсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүдэд оногдуулах ял шийтгэлийг ялгавартай болгон” тусгаж өгсөн.

Хуулийн энэхүү заалтаар гэмт бүлэглэл болон эрүүгийн ертөнцийн шатлалын дээд түвшинд байгаа этгээдэд оногдуулах ялыг нилээд хэмжээгээр чангаруулж өгсөн.

Гэвч харамсалтай нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн энэхүү заалтыг практикт хэрэглэхэд ихээхэн бэрхшээл учрав.

Яагаад гэвэл гэмт бүлэглэл, эрүүгийн ертөнцийн шатлалын дээд түвшинг толгойлж байгаа этгээд гэсэн ойлголтыг хуульдаа тайлбарлаж өгөөгүй.

Гэмт нөхөрлөл нь өөрийн гишүүдийн тухайн нөхөрлөлд эзэлж байгаа байр суурь, албан тушаал, шатлан захирагдах ёсыг хэзээ ч баримтжуулж тодорхойлдоггүй тул шүүх дээр энэ байдлыг нотолж чадахгүйд хүрдэг. Үүнээс улбаалаад хууль тогтоогч тухайн

этгээдийн хэлбэрийн шинж тэмдгийг хэрхэн тодорхойлсноо эргэн харж үзэх шаардлагатай болсныг тэмдэглэх нь зүйтэй.

Мэргэшсэн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангид эрүүгийн мэргэшсэн байдлын шинжүүд болон тухайн этгээдийн хүлээх хариуцлага, эрх зүйн байдлыг тодорхойлсон зүйл заалтыг оруулж өгөх нь шаардлагатай байна.

ОХУ-ын 1992 оны Эрүүгийн хуулийн 25 дугаар зүйлийн (е)-д “мэргэшсэн байдал”-ыг ял хүндрүүлэх нөхцөл болгон заасан бөгөөд мөн хуулийн 180 дугаар зүйлийн (б)-д “хулгайн гэмт хэрэгт мэргэшсэн байх” гэж заагаад хуулийн 10 гаруй зүйлд үүнийг ял хүндрүүлэх шинж болгон тодорхойлсны гадна “мэргэшсэн байх нь нэг төрлийн ажил юм” гэсэн нэр томъёог хэрэглэж байжээ.

Үндсэн ялын дээд хэмжээг хязгаарлахгүйгээр тогтоож, үйлдсэн гэмт хэрэг тус бүрт оногдуулах ялыг нэмж ял оногдуулж байгаа гадаад орнуудын туршлагыг ч авч хэрэгжүүлж болох юм.

Эрүүгийн хуулиар тодорхойлогдсон “Эрүүгийн мэргэшсэн байдал”-ын шинж тэмдгүүд нь гэмт этгээдийн хувьд үнэхээр онцгойлон авч үзэх асуудал юм. Уг этгээдүүдэд ял оногдуулах тусгай журам ч байж болно.

Олон удаа хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээд амьдралынхаа эцсийн мөч хүртэл эсвэл ихэнх хэсгийг хорих байгууллагад ял эдэлж өнгөрөөх юм байна гэдгээ ухамсарлан ойлгох бөгөөд ингэснээрээ ял шийтгэлд хандах хандлага нь

“амьдралдаа нэг л удаа амьсгаа авч байгаа” мэтээр эрс өөрчлөгдөнө.

Мэргэшсэн гэмт явдлаас урьдчилан сэргийлэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийг шинэчлэн өөрчлөх, тухайлбал: онц аюултай гэмт хэрэгтэн, мэргэшсэн гэмт этгээдүүдтэй харьцах харилцааг бүхэлд нь чангаруулах зэрэг нь зохих үр нөлөө үзүүлнэ. Дээрх чиглэлээр хийгдэх өөрчлөлтүүд нь нийгмийн эсрэг хатуу чиг баримжаа бүхий этгээдүүдийн хүчийг сулруулах, эрүүгийн гэмт этгээдүүдийн уламжлалт зан үйл, гэмт үзэл баримтлалыг ял шийтгүүлсэн этгээдүүдийн дунд ухуулан таниулах явдлыг гаргуулахгүй байх зорилгоор тэдгээрийг тусгаарлахад чиглэгдсэн үйл ажиллагаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын системийг бүхэлд нь шинэчлэн өөрчлөх явдалтай хамт хийгдэх учиртай.

Эхний алхам нь анх удаа хорих ял эдлэж байгаа хүмүүсийг мэргэшсэн гэмт хэрэгтэн, онц аюултай гэмт хэрэгтнүүдээс тусгаарлаж ялыг нь эдлүүлэх явдал юм.

Мэргэшсэн гэмт явдалтай тэмцэхийн тулд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь боловсронгуй болгох, кармааны болон орон байрны хулгай хийдэг этгээдүүд, залилан мэхлэгчид, дээрэм хийдэг этгээдүүд, алан хядагч гэх мэт мэргэшсэн гэмт этгээдүүдтэй тэмцэх чиг үүрэг бүхий тусгай албад, нэгжүүдийг шинээр байгуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь чухал байна.

Эрүүгийн цагдаагийн газар зэрэг байгууллагуудад дээр дурдсан тусгай нэгж байгуулахын зэрэгцээ тэдгээрт ажиллаж байгаа ажилгунуудыг маш нарийн байдлаар мэргэшүүлж, мэргэшсэн гэмт этгээдүүдийг олж илрүүлэх, байнгын бүртгэл хяналттай болгох хэрэгтэй. Үүний тулд ОХУ-ын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа нэгж салбаруудын компьютер-мэдээллийн сүлжээнд мэргэшсэн гэмт этгээдүүдийн онцлог шинж тэмдэг, зан чанарын тодорхойлолт, гадаад дүр төрх, гэмт хэрэг үйлддэг арга зэрэг мэдээллийг оруулах шаардлагатай.

Тухайн мэдээллийн сангийн өгөгдлүүд нь мэргэшсэн гэмт этгээдүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд тус дэхөм болохын зэрэгцээ мэргэшсэн гэмт этгээдийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломж олгож, мэргэшсэн гэмт этгээдүүд болон тэдгээрийг тойрон хүрээлж байгаа хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж, гэмт зан үйл хийхээс сэрэмжлүүлнэ. Түүнээс гадна тухайн мэдээллийн баазын өгөгдлүүдийг одоо байгаа мэргэшсэн гэмт явдлын шинж чанар, бүтцийн өөрчлөлтөд хяналт, дүн шинжилгээ хийж, алс хэтдээ хэрхэн өөрчлөгдөхийг тодорхойлоход ашиглаж болох бөгөөд цаашид хэрхэн тэмцэх чиг хандлагаа тодорхойлоход нэн чухал эх сурвалж болно.

Мэргэшсэн гэмт явдалтай тэмцэхэд чиглэгдсэн иж бүрэн хөтөлбөр боловсруулах шаардлагатай. Гэхдээ энэ нь бие даасан тусгай хөтөлбөр

биш гэхэд төрөөс гэмт явдалтай тэмцэх хөтөлбөрийн зөвхөн нэг бүлэг ч байж болно.

Хамгийн гол нь мэргэшсэн гэмт явдлын шалтгаан нөхцөлийг таслан зогсоох, арилгахад чиглэгдсэн иж бүрэн арга хэмжээ байх нь чухал.

Мэргэшсэн гэмт этгээдүүдийн үйлдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн дотор эзлэх хувь хэмжээ нь бага байлаа ч гэсэн тэдгээрийн учруулж байгаа хохирол, хор уршиг асар их хэмжээтэй байдаг.

Мэргэшсэн гэмт хэрэгтэй тэмцэх бүтцэд тухайн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийг хамгаалах “хохилогч хамгааллын арга хэмжээнүүд” онцгой байр суурийг эзэлдэг.

Мэргэшсэн гэмт хэрэгтнүүд гэмт хэрэг үйлддэг “өөрийн” гэсэн аргатай бөгөөд тэрхүү арга нь мэргэшсэн гэмт хэрэгтнүүдийн мэргэшсэн байдал, зэрэглэлийг тодорхойлдог. Олонх тохиолдолд эдгээр аргууд нь хууль сахиулах байгууллагуудад илэрхий, тодорхой байдаг. Ийм учраас хулгай, дээрэм, залилан мэхлэх болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд ард иргэдийг тодорхой мэдээллээр хангах нь чухал. Энэ нь мэргэшсэн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга болно.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүст учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, дэм тус үзүүлэх талаар төрөөс эрүүгийн

чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа бодлогодоо эрс өөрчлөлт хийх хэрэгтэй. Дахин гэмт хэргийн хохирогч болгохгүй байх, учирсан материаллаг хохирлыг нь бүрэн төлүүлж, шударга ёсыг тогтооход төрөөс авч хэрэгжүүлж байгаа бүхий л арга хэмжээ чиглэгдэх ёстой.

Ял эдлэж байгаа ялтан заавал хөдөлмөр эрхлэх ёстой бөгөөд төрөөс ялтны хөдөлмөрлөх бүх нөхцлийг бүрдүүлснээр ялтанд хугацаанаасаа өмнө суллагдах болно гэсэн итгэл үнэмшлийг бий болгох нь чухал. Өөрөөр хэлбэл, зөвхөн учруулсан хохирлоо нөхөн төлсөн тохиолдолд ял эдлүүлэх байгууллагаас суллагдах юм гэдгийг “ял эдлэх хугацаатай” нь холбож өгөх хэрэгтэй. Хорих ангид ялтан “эрүүгийн мэргэшлийнхээ” түвшинг нэмэгдүүлээд гарах бус, нийгэмд ашигтай хөдөлмөр эрхэлж байх нь гэмт хэргийн хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, ялтны засрал хүмүүжлийг харуулах нэгэн хүчин зүйл болно.

Мэдээж хэрэг мэргэшсэн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар ОХУ урт замыг туулж ирсэн хэдий ч дэлхийн бусад орнууд ч энэ талаар арвин их туршлага хуримтлуулсаар ирсэн тул гадаад орнуудын хууль сахиулах байгууллагуудын мэргэшсэн гэмт явдалтай хийж буй тэмцлийн арга хэлбэрийг судалж хэрэгжүүлэх нь зүйтэй байна.